# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2022 оны эхний хагас жил/

2022 оны 06 дугаар сарын 29

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2022 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, зүйл, заалтын хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар хавсралтын дагуу Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван салбар чиглэлээр гаргуулав.

## **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**.

2022 оны эхний хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 174 шийдвэрийн 303 зүйл, заалтыг дээр дурдсан салбар чиглэлээр ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **85.1** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 15 шийдвэрийн 19 зүйл, заалтын хэрэгжилт - 74.4%;
- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 37 шийдвэрийн 46 зүйл, заалтын хэрэгжилт - 83.7%;

- Уул уурхайн бодлогын 57 шийдвэрийн 106 зүйл, заалтын хэрэгжилт - 81.2%;
- Хүнд үйлдвэрийн бодлогын 13 шийдвэрийн 16 зүйл, заалтын хэрэгжилт - 78.1%;
- Нийтлэг асуудлын 52 шийдвэрийн 116 зүйл, заалтын хэрэгжилт - 91.9%-ийн тус тус биелэлттэй байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2022 оны эхний хагас жил/

Хүснэгт-1

| Салбар, чиглэлийн нэр | Хяналтанд авсан тоо | | Хэрэгжилтийн явц /хувиар/ | | | | | Үнэлгээ /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэр | зүйл, заалт | 100% | 70% | 30% | 0% | үнэлээгүй | |
| НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО (ГЭББ) | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 1 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 7 | 8 | 5 | 3 | 0 | 0 | 0 | 88.7 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 7 | 9 | 1 | 3 | 4 | 0 | 1 | 53.7 |
| ГЭББ-ын дүн | 15 | 19 | 8 | 6 | 4 | 0 | 1 | **74.4** |
| ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО (ГТГТББТНТБ) | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 3 | 3 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 90.0 |
| УИХ-ын тогтоол | 1 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 70.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 7 | 8 | 5 | 3 | 0 | 0 | 0 | 88.7 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 25 | 33 | 17 | 9 | 4 | 0 | 3 | 81.6 |
| ГТГТББТНТБ-ын дүн | 37 | 46 | 25 | 14 | 4 | 0 | 3 | **83.7** |
| ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО (УУБ) | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 4 | 10 | 7 | 3 | 0 | 0 | 0 | 91.0 |
| УИХ-ын тогтоол | 6 | 20 | 10 | 6 | 2 | 0 | 2 | 82.2 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 4 | 9 | 7 | 2 | 0 | 0 | 0 | 93.3 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 15 | 19 | 8 | 6 | 3 | 0 | 2 | 77.0 |
| Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 26 | 46 | 21 | 17 | 6 | 1 | 1 | 71.1 |
| УУБ-ын дүн | 57 | 106 | 55 | 34 | 11 | 1 | 5 | **81.2** |
| ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО (ХҮБ) | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын тогтоол | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 2 | 4 | 1 | 3 | 0 | 0 | 0 | 77.5 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 7 | 8 | 2 | 4 | 2 | 0 | 0 | 67.5 |
| ХҮБ-ын дүн | 13 | 16 | 7 | 7 | 2 | 0 | 0 | **78.1** |
| ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 5 | 54 | 45 | 3 | 1 | 0 | 5 | 96.7 |
| УИХ-ын тогтоол | 2 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Ерөнхийлөгчийн зарлиг | 2 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 15 | 17 | 11 | 2 | 3 | 0 | 1 | 83.1 |
| Ерөнхий сайдын захирамж | 2 | 2 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 70.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 19 | 23 | 18 | 3 | 1 | 0 | 1 | 92.7 |
| ЗГ-ын албан даалгавар | 2 | 9 | 4 | 3 | 2 | 0 | 0 | 74.4 |
| Ерөнхий сайдын албан даалгавар | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Нийтлэг асуудлын дүн | 52 | 116 | 89 | 13 | 7 | 0 | 7 | **91.9** |
| **Эрх зүйн баримт бичгийн дүн** | **174** | **303** | **184** | **74** | **28** | **1** | **16** | **85.1** |

Нийт 174 шийдвэрийн 303 зүйл, заалтын 16 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 287 зүйл, заалтын 184 зүйл, заалт буюу 64.1% нь “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 74 зүйл, заалт буюу 25.8% нь “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 28 зүйл, заалт буюу 9.8% нь “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй, 1 зүйл, заалт буюу 0.3% нь “хэрэгжээгүй” 0 хувийн биелэлттэй байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
/Хууль тогтоомжийн төрлөөр/

Хүснэгт-2

| | | Бүгд | Монгол Улсын хууль | Улсын Их Хурлын тогтоол | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Зассгийн газрын албан даалгавар | Ерөнхий сайдын албан даалгавар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авагдсан шийдвэрийн тоо | | **174** | 15 | 10 | 8 | 2 | 2 | 46 | 3 | 84 | 2 | 1 |
| Заалтын тоо | | **303** | 71 | 26 | 13 | 3 | 2 | 56 | 3 | 119 | 9 | 1 |
| Үнээс | “бүрэн хэрэгжсэн” 100% | **184** | 58 | 15 | 11 | 3 | 2 | 30 | 1 | 59 | 4 | 1 |
| | “хэрэгжих шатанд” 70.0% | **74** | 7 | 7 | 2 | 0 | 0 | 17 | 2 | 36 | 3 | 0 |
| | “хэрэгжилт хангалтгүй” 30.0% | **28** | 1 | 2 | 0 | 0 | 0 | 6 | 0 | 17 | 2 | 0 |
| | “хэрэгжээгүй” 0% | **1** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 |
| | Үнэлгээ өгөөгүй | **16** | 5 | 2 | 0 | 0 | 0 | 3 | 0 | 6 | 0 | 0 |
| | **Үнэлгээ** | **85.1** | **95.7** | **85.4** | **95.3** | **100.0** | **100.0** | **82.4** | **80.0** | **79.0** | **74.4** | **100.0** |

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 15 хуулийн 71 заалтын хэрэгжилт – 95.7%;
- Улсын Их Хурлын 10 тогтоолын 26 заалтын хэрэгжилт – 85.4%;
- УИХ-ын Байнгын хорооны 8 тогтоолын 13 заалтын хэрэгжилт – 95.3%;
- Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 3 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 шийдвэрийн 2 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Засгийн газрын 46 тогтоолын 56 заалтын хэрэгжилт – 82.4%;
- Ерөнхий сайдын 3 захирамжийн 3 заалтын хэрэгжилт – 80.0%;
- Засгийн газрын хуралдааны 84 тэмдэглэлийн 119 заалтын хэрэгжилт – 79.0%;
- Засгийн газрын 2 албан даалгаврын 9 заалтын хэрэгжилт – 74.4%
- Ерөнхий сайдын 1 албан даалгаврын 1 заалтын хэрэгжилт – 100.0% байна.

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан 174 шийдвэрийн 303 зүйл, заалтын 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг **85.1** хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.
2. Нийт 303 зүйл, заалтын 16 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй, 184 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 74 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 28 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй, 1 зүйл, заалт “хэрэгжээгүй” 0 хувийн биелэлттэй байна.
3. Засгийн газрын хуралдааны 2022 оны 6 дугаар тэмдэглэлийн IX.9.4 заалтын хэрэгжилтийг “хэрэгжээгүй” 0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн. Уг тэмдэглэлээр Ашигт малтмалын томоохон орд тогтоогдсон бүс нутагт уул уурхайн цогц бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанаар 2022 оны 2 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад даалгасан боловч одоог хүртэл ажлын хэсгийг байгуулаагүй байна.
4. Нийт 28 зүйл, заалтын хэрэгжилтийг “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн бөгөөд үүнийг салбар чиглэлээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:
    - Геологи, эрдэс баялгийн бодлого – 4;
    - Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн бодлого – 4;
    - Уул уурхайн бодлого – 11;
    - Хүнд үйлдвэрийн бодлого – 2;
    - Нийтлэг асуудал – 7.
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа боловч хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан), баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.

**Тав. Зөвлөмж**.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Шинэ сэргэлтийн бодлого" зэрэг баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлттэй уялдуулан тайлагнах;
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай” 03 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах;
3. Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан) гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой бичүүлэх, үг үсэг, утга найруулгын алдааг засах;
4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын нэгдүгээр хавсралтад зааснаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15, 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлдэг тул энэ хугацаанаас ажлын 5 хоногийн өмнө нэгтгэн боловсруулсан тайланг албажуулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх;
5. “хэрэгжээгүй” 0 хувь, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа холбогдох шийдвэрийн зүйл, заалтыг хүчингүй болгуулах, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.

Жич: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/

2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

| № | *Шийдвэрийн дэс дугаар* | *Зүйл, заалтын дэс дугаар* | *Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга* | *Хэрэгжилтийн явц* | *Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)* | *Тасарсан болон удаааширч байгаа шалтгаан* |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО | | | | | | |
| 1.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 1 | 1 | 1 | **Цөмийн энергийн тухай**<br>**2009-07-16**<br>**Дугаар 2009.07.16**<br>28.10. Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. (28.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна.) | Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2015 оны 21 дүгээр захирамжаар Уул уурхайн сайдын ахалсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Ажлын хэсгийн гол зорилго нь уурхайн нөхөн сэргээлт, хаалтын үйл ажиллагаанаас тусдаа зөвхөн гэнэтийн аюул, осолтой холбогдон нийгэмд бий болох хохирлыг /эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдал/ арилгахад шаардагдах мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтооход чиглэсэн. Ажлын хэсэг нь ураны хайгуул, олборлолт, боловсруулалт явуулдаг улс орнуудын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хаалт хийх үйл ажиллагаанд зориулан тусгай сан үүсгэдэг туршлага, зарим тохиолдолд урьдчилан төлөвлөөгүй, гэнэтийн осол аваарын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан тусдаа сан үүсгэх эсхүл дээрх сантай нэгдмэл байдлаар зохицуулдаг талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн. Мөн Олон улсын байгууллагуудын /OECD-Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, IAEA-Олон улсын атомын энергийн агентлаг/ судалгааны үр дүнг судалж холбогдох санал зөвлөмжийг гаргасан. Цөмийн энергийн тухай хуулийн 45.3-т “Нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн ослын хор уршгийг арилгах ажлын зардлыг Засгийн газар хариуцна." гэж заасан байх тул санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээг аль болох их хэмжээнд байлгах асуудлыг УУХҮЯ-ны зүгээс баримталж Ажлын хэсгийн дүгнэлтээр төслийн хэмжээнд гэнэтийн ослын санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ нийт төслийн хугацаанд дунджаар 1.6 тэрбум доллар, туршилтын хугацаанд 0.8 сая доллар байх асуудлаар төслийн хөрөнгө оруулагч “Арева Монгол” ХХК-ийн удирдлагатай зөвшилцөж 900,000.0 ам.долларыг Төрийн санд байршуулахаар тогтсон. Ингээд Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо ордын ашиглалтын MV-018915 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадрах энержи” ХХК нь ураны ордын технологийн туршилт явуулахтай холбогдуулан нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг харгалзан байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх зорилгоор “Бадрах энержи” ХХК-ийн ураны ордын технологийн туршилт явуулахтай холбогдуулан Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын дагуу Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах гэрээний төслийг УУХҮЯ-наас боловсруулан СЯ, БОАЖЯ, МХЕГ, ЦЭК, АМГТГ-аас холбогдох саналыг авч тусгасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Бадрах Энержи ХХК-ийн гүйцэтгэх захирал нар байгуулж, Бадрах Энержи ХХК нь Төрийн сангийн 100900018351 тоот дансанд 900,000.0 /есөн зуун мянга/ ам.долларыг тухайн өдрийн Монголбанкны ханшаар байршуулсан. | | |
| 2 | 1 | 2 | 15.2. Дараах үйл ажиллагааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ: 15.2.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх; 15.2.2.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах; 15.2.3.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх. | Цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах чиглэлээр тайлангийн хугацаанд шинээр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоогүй. 2021.12.20-ны өдрийн байдлаар Геологи, уул уурхайн кадастрын мэдээллийн санд шүүлт хийж үзэхэд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 5, ашиглалтын 9 тусгай зөвшөөрөл хүчинтэй бүртгэлтэй байна. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.11.02-ны өдрийн 128/ШШ2020/0713 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021.01.27-ны өдрийн 67 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн 2021.04.05-ны өдрийн 99 дүгээр тогтоол, Улсын дээд шүүхийн 2021.06.28-ны өдрийн 53 дугаар тогтоолыг биелүүлж "Гурвансайхан" ХХК-ийн эзэмшлийн Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян сумдын нутаг Өлзийт нэртэй 10662.22 гектар талбайд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын MV-020634 дүгээр тусгай зөвшөөрлийг олгосон Кадастрын даргын /хуучин нэрээр/ 2016.07.22-ны өдрийн 512 дугаар шийдвэрийг хүчингүй болгосон Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2021.10.13-ны өдрийн 402 дугаар шийдвэр гаргасан. | 100% | |
| 1.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 1.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 1.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 1.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 3 | 1 | 1 | **Төслийн нэгж байгуулах тухай**<br>**2019-05-01**<br>**Дугаар 2019_176**<br>3.. Төслийн нэгжийг 5 жилийн хугацаатай ажиллуулж, үр дүнгийн тайланг тухайн жилийн 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК (П.Ганхүү)-д даалгасугай. | Газрын ховор элементийн төслийн нэгж нь Ховор металл, газрын ховор элементийн чиглэлээр дараах судалгааг хийсэн байна. Үүнд:<br>- ГХЭ-ийн зах зээлийн болон технологийн талаар, мөн хөгжингүй орнуудын ховор, газрын ховор элементийн талаар баримталж байгаа бодлогын талаарх судалгаа хийж байна.<br>- Монгол орны газрын ховор элемент болон ордуудын тухай мэдээлэл, Төслийн нэгжийн судалгааны мэдээллийг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн.<br>- Монгол орны газрын ховор элементийн ашиглалтын тусгай зөвшөөрөл, ханшийн судалгааны ажлыг гүйцэтгэж байна.<br>- Монгол орны газрын ховор элементийн хайгуул хийгдсэн ордууд, илрэлүүд, эрдэсжсэн цэгүүдтэй холбогдолтой тайлан, мэдээллүүдийг Геологи мэдээллийн төв архив болон аж ахуйн нэгжүүдээс цуглуулж, цахим болон цаасан хэлбэрээр архив, суурь мэдээлэл бэлтгэсэн.<br>- Төслийн хүрээнд ХБНГУ-ын Элчин сайдын яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугатын ГХЭ-ийн хүрээлэн, Хятад-Монголын технологи дамжуулах төв, ОХУ-ын Росатом зэрэг байгууллагуудтай ГХЭ-ийн техник, технологийн талаарх мэдээлэл болон мэргэжилтэн солилцох хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр санамж бичиг байгуулсан. | 70% | |
| 4 | 2 | 2 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**<br>**2021-05-05**<br>**Дугаар 2021_130**<br>2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах | 1. Тогтоолын хавсралтад нэмэлтээр оруулсан түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тайлбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан нэмэлт оруулж батлуулсан.<br>2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харъяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол”-ын 61 дэх заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 62-76 дахь заалтыг нэмсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | “Жунмэй инженеринг групп монголиа” ХХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн UDREP2&3/02, 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн UDREP2&3/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн солбицлуудыг хянаж 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 8/866 , 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 8/1685 дугаартай албан бичгээр хариуг хүргүүлсэн. Тус албан бичгээр хүргүүлсэн солбицлын дагуу 2022 онд “Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал /хайрга, дайрга/ олборлолтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа болно. | | |
| 5 | 3 | 3 | **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай**<br>**2020-11-04**<br>**Дугаар 2020_170**<br>2. Энэ тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгасугай. | Тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна.Энэ ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалаар ГЗБГЗЗГ, ЗТХЯ, Монгол төмөр ТӨХК, АМГТГ, Дорноговь аймгийн ГХБХБГ, Өмнөговь аймгийн ГХБХБГ, холбогдох сумдын газрын даамал нар ажиллаж байна | 100% | |
| 6 | 4 | 4 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2022-04-20**<br>**Дугаар 2022_165**<br>2. “Олон улс, улсын чанартай зам барих” төслийн хүрээнд хэрэгжих Дархан-Алтанбулагийн замаас Сэлэнгэ аймгийн Шаамар сум-Зэлтэрийн боомт чиглэлийн 120,85 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд | “Олон улс, улсын чанартай зам барих” төслийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 03/2319 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Дархан-Алтанбулагийн замаас Сэлэнгэ аймгийн Шаамар сум-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг шалгуулахаар ирүүлснийг талбайн давхцалыг шалган Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын 3.3-т заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/2993 дугаартай албан бичгээр ирүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай | | | |
| 7 | 5 | 5 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2022-04-20 Дугаар 2022_166** 2. Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Мон (3787/3788): “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн Хөвсгөл дэд төслийн хүрээнд хэрэгжих 37.9 км хатуу хучилттай авто зам, 7 байршлын зогсоолын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай | Хөвсгөл дэд төслийн хүрээнд хэрэгжих 37.9 км хатуу хучилттай авто зам, 7 байршлын зогсоолын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн 4 талбайн хайрга, дайрганы шинж чанар нийцэхгүй байгаа тул Засгийн газрын тогтоолын төсөлд нэмэлт оруулахаар яамдаас санал авахаар 2022.06.09-ний өдрийн 01/1648 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Замын ажил явагдаж байна. | 100% | |
| 8 | 6 | 6 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2022-04-27 Дугаар 2022_176** 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол”-ын 76 дахь заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 77-91 дэх заалтыг нэмсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор “Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах 15 талбайд хайрга, дайрга олборлолтын ажил явагдаж байгаа бөгөөд замын ажил үргэлжилж байна. | 100% | |
| 9 | 7 | 7 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2022-05-11 Дугаар 2022_195** | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Монгол Улсын хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ”-ний дагуу Дорноговь аймаг дахь хилийн Замын-Үүд боомтын өргөтгөл, шинэчлэлийн авто зам, талбайн барилгын ажил, Өмнөговь аймаг дахь хилийн Гашуунсухайт боомтын өргөтгөл, шинэчлэлийн авто зам, талбайн барилгын | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Монгол Улсын хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ”-ний дагуу Дорноговь аймаг дахь хилийн Замын-Үүд боомтын өргөтгөл, шинэчлэлийн авто зам, талбайн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг 1 дүгээр хавсралт, Өмнөговь аймаг дахь хилийн Гашуунсухайт боомтын өргөтгөл, шинэчлэлийн авто зам, талбайн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | ажилд тус тус олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайгаас олборлолт хийж, бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байна | | |
| 10 | 7 | 8 | 4. Авто зам, талбайн барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто замын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд тус тус даалгасугай | 2022 оны эхний хагас жилийн байдлаар авто зам барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайн солбицол батлах эрх олгох 4 тогтоолыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулаад байна. Тухайн тогтоолоор батлагдсан талбайнуудад олборлолт хийгдэж замын ажил явагдаж байна. | 70% | |
| 1.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 11 | 1 | 1 | **2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 74 дүгээр тэмдэглэл**<br>**2020-12-30**<br>**Дугаар 2020_74**<br>XXIX.7. . “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн эзэмшдэг “Овоот хяр” нэртэй ХҮ-21670 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай дахь “Хойд бүргэд” нэртэй алтны | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр “Овоот хяр” хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэх нарийвчилсан хайгуулын ажилд шаардагдах санхүүжилтийг 2020 оны орлогоос буюу өөрийн хөрөнгөөр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/37 дугаар тушаалаар геологи, хайгуулын ажлын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Үүнд: Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Геофизикийн соронзон хайгуулын ажил, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Геофизикийн цахилгаан хайгуулын ажил, Шар хөндий-Хан худгийн хайгуулын | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үндсэн ордод “Геологийн судалгааны төв” ТӨҮГ болон “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн хамтран гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажлын үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Хойд бүргэд” нэртэй алтны үндсэн ордын нарийвчилсан хайгуулын ажлыг дуусгах, уг тусгай зөвшөөрөл бүхий талбайд илэрсэн алт, алт-зэсний илрэлүүдэд нөөц тогтоох эрэл, хайгуулын нэмэлт ажилд шаардагдах эх үүсвэрийн асуудлыг судлан саналаа боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгав. | талбайнуудад гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Бүргэдийн хайгуулын талбайнуудад гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Овоот хярын хайгуулын талбайд гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Топогеодези /цооногийн топо холболт, байр зүйн зураг/-ийн ажил, Лабораторийн шинжилгээ, Овоот хярын эрлийн талбайн геологийн нөөцийн тайлан боловсруулах ажил, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Археологийн судалгаа, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн судалгаа хийх ажлын тендерийг www.tender.gov.mn цахим хуудаст байршуулан сонгон шалгаруулах ажиллагааг явуулж гүйцэтгэгчийг шалгаруулсан. Шалгарсан гүйцэтгэгч нар гэрээний дагуу геологи-хайгуулын хээрийн судалгааны ажлыг хэрэгжүүлж дууссан. Өнөөдрийн байдлаар суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна. | | |
| 12 | 2 | 2 | **2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл**<br>**2021-03-03**<br>**Дугаар 2021_14**<br>XII.4. 9. Монгол Улсын төрийн өмчит “Мон-Атом” компани, Бүгд Найрамдах Франц Улсын “Орано” группийнн хамтран хэрэгжүүлж буй “Бадрах Энержи” ХХК-ийн төслийн талаарх байр сууриа тодорхой болгох, цаашид авах арга хэмжээний тухай саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Монгол Улсын төрийн өмчит “Мон-Атом” компани, Бүгд Найрамдах Франц Улсын “Орано” группийн хамтарсан “Бадрах энержи” ХХК-ийн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт хэрэгжүүлж буй Зөөвч-Овоо төслийн туршилтын үйлдвэрийн үйл ажиллагааг 2021.07.09-ний өдрөөс ажиллуулах зөвшөөрөл олгосонтой холбоотойгоор уг төслийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах шаардлагагүй болсон. | /-/ | |
| 13 | 3 | 3 | **2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 56 дугаар тэмдэглэл**<br>**2021-10-20**<br>**Дугаар 2021_56**<br>YIII.8. . Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх геологи, судалгааны ажлын явц, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Засгийн газрын 2021 оны хуралдааны 56 дугаар тэмдэглэлээр өгсөн даалгаврын дагуу 2022 оны 1 дүгээр улиралд багтаан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх ажлын явцын талаар танилцуулгыг хийх боломжгүй болсон. Учир нь Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөлөөс шалтгаалан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд зарцуулахаар УИХ-аас баталсан 32.9 тэрбум төгрөгөөс 5.2 тэрбум төгрөгийг 2022 оны 2 дугаар сард тодотгон хасалт хийсэн. Үүнээс шалтгаалан 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан ажлуудын хэмжээ, төслийн тоонд өөрчлөлт орсон тул ажлын явцын талаарх танилцуулгыг дараа улиралд багтаан танилцуулахаар төлөвлөж байна.<br>Мөн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлыг орон нутгийн иргэдээс эсэргүүцэх, зогсоох зэрэг асуудлуудтай уялдуулан холбогдох танилцуулгыг 2022.06.22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулна. ЗГХЭГ-т тухайн хүсэлтийг 2022.06.07-ны өдрийн 01/1620 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 70% | |
| 14 | 4 | 4 | **2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл**<br>**2022-04-20**<br>**Дугаар 2022_24** | Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд заасны дагуу гол, мөрний урсац бүрэлдэх эх орчмын газартай давхцалтай ашигт малтмалын зөвшөөрөлтэй талбайнуудын мэдээллийг бэлтгэн нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хэрхэн | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XIY.8. . Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн тайлангийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд заасны дагуу гол, мөрний урсац бүрэлдэх эх орчмын газартай давхцалтай ашигт малтмалын зөвшөөрөлтэй талбайнуудын давхцлыг арилгах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт; | шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд санал боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.<br>Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох хуулийн үйлчлэлд хамааралтай үлдэж буй бусад нүүрсний 21 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувьд дараах нөхцөлтэй байсан. Стратегийн ордод хамаарагдаж буй -7 тусгай зөвшөөрөл, Холбогдох хууль эрх зүйн актуудын хүрээнд олон талт гэрээ байгуулж ажиллах эсвэл Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хандсан газар дээр нь шалгалтаар ажиллах хүсэлтийн дагуу асуудлыг шийдвэрлэх боломжтой – 14 тусгай зөвшөөрөл байгаагаас 2 тусгай эзэмшигчтэй /Шарын гол ХК, Мон-Ажнай ХХК 5 талт гэрээ байгуулсан байна. | | |
| 15 | 5 | 5 | **2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 1 дүгээр тэмдэглэл**<br>**2022-01-05**<br>**Дугаар 2022_1**<br>XX.12.1. Дорноговь аймгийн Улаанбадрах суманд цацраг идэвхт ашигт малтмал буюу уран олборлох үйл ажиллагаа явуулах талбайн байгаль орчны суурь нөхцөл, олборлох технологи, нөлөөллийг тодорхойлсон Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан нарт даалгав | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны захиалгаар Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр Дорноговь аймгийн Улаанбадрах суманд цацраг идэвхт ашигт малтмал буюу уран олборлох үйл ажиллагаа явуулах талбайн байгаль орчны мониторинг үнэлгээ сэдэвт судалгааны ажлыг Боловсрол соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Уг судалгааг хөндлөнгийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлснээр орон нутагт үүсээд буй нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхой дүгнэлтэд хүрэх юм. | 30% | |
| 16 | 5 | 6 | XX.12.2. Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн холбогдох мэдээллийг нийтэд мэдээлэх арга хэмжээг эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулан зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны захиалгаар Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр Дорноговь аймгийн Улаанбадрах суманд цацраг идэвхт ашигт малтмал буюу уран олборлох үйл ажиллагаа явуулах талбайн байгаль орчны мониторинг үнэлгээ сэдэвт судалгааны ажлыг Боловсрол соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Уг судалгааг хөндлөнгийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлснээр орон нутагт үүсээд буй нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхой дүгнэлтэд хүрэх юм. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | З.Мэндсайхан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал нарт даалгав | | | |
| 17 | 5 | 7 | **2022_24. 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл**<br>XIY.11.2. Авто замын барилгын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах нэмэлт талбайн солбицлыг батлуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав; | Дархан-Алтанбулагийн замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120,85 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/928 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 165 дугаар тогтоолоор батлагдсан.<br>Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 166 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хөвсгөл дэд төслийн хүрээнд хэрэгжих 37.9 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/1030 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 166 дугаар тогтоолоор батлагдсан.<br>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2019 онд байгуулсан “Монгол Улсын хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ”-ээр Дорноговь аймаг дахь хилийн Замын-Үүд боомт, Өмнөговь аймаг дахь хилийн Гашуунсухайт боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1313 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 195 дугаар тогтоолоор батлагдсан.<br>Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг баталсан Засгийн газрын 2019 оны 361 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1196 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан.<br>Засгийн газрын хуралдаанаар 4 асуудал хэлэлцүүлэн холбогдох тогтоол шийдвэрийг гаргуулаад байна.<br>Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 166 дугаар тогтоолд нэмэлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл холбогдох материалыг боловсруулан яамдаас санал авахаар 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/1648 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгөөр Баян-Өлгий аймагт хийгдэж буй Улаанхус сумын 4 км хатуу хучилттай авто зам, Толбо сумын 2.3км хатуу хучилттай авто зам, Бугат сумын бетон гүүрийн авто зам, барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах Засгийн газрын тогтоолын төсөл холбогдох материалыг боловсруулан яамдаас санал авахаар 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/1649 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Хуулиар хориглосон хязгаарласан талбайтай давхцалтайн улмаас геологи хайгуулын ажил гүйцэтгэх боломжгүй болсон аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг АМТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т заасны дахин дүйцүүлэн олгох асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/82 дугаартай албан бичгээр санал авахаар хүргүүлсэн. Уг тогтоолын төсөлд татгалзсан | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | санал ирүүлсэн яамдад тайлбар тодруулга боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/567 дугаартай албан бичгээр дахин санал авахаар хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамдаас санал авч буй 3 тогтоол байна. | | |
| 18 | 6 | 8 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58** XYI.4. 2. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, туршилтын олборлолт, ашиглалтын үйл ажиллагааны талаарх бодит мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шат дараатай гүйцэтгэх, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан газар дээрээс мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав нарт даалгав | Цахим хуудас, олон нийтийн сүлжээнд нийт 12 дотоод мэдээ, 33 гадаад мэдээ, 16 видео мэдээ, 15 контент тус тус байрлуулж нийт 138,946 хандалт авсан. Цөмийн энергийн салбарын олон нийтэд хүргэх, нийтийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Цөмийн нэгдсэн групп”-ийг 2020.09.04-ний өдөр үүсгэсэн. Нэгдсэн групп 2020.12.15-ны өдрийн байдлаар нийт 750 гишүүн, 16 орны 56 хотуудаас элссэн бөгөөд группд зочилж мэдээлэл авч байгаа гишүүдийг насны ангиллаар авч үзвэл 25-34 насны гишүүд 41.6 хувь, 35-44 насны гишүүд 24.9 хувийг тус тус эзэлж байна. | 70% | |
| 19 | 7 | 9 | **2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16** XYIII.11. . “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 01 тоот албан даалгаврын 4.8-д заасны дагуу эрчим хүчний салбарт цөмийн эрчим хүч ашиглах чиглэлээр баримтлах бодлогын талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг Монгол Улсад ашиглах суурь судалгааны ажлыг эхлүүлж, цаашид бодлогын ямар чиглэл баримтлах талаар саналаа боловсруулан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цөмийн энергийн комиссын дарга Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | Цөмийн эрчим хүчний түүхий эд ураны ордуудын нөөцийн мэдээллийг боловсруулж, геологи хайгуулын өмнөх судалгааны ажлаар тогтоогдсон илрэлүүдийн мэдээллийг агуулсан мэдээллийн сан бий болгохоор ажиллаж байна. | 30% | |
| | 15 | 19 | Геологи, эрдэс баялгийн бодлогын дундаж: 74.4 хувь | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| САЛБАР ЧИГЛЭЛ: 2. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО | | | | | | |
| 2.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 20 | 1 | 1 | **Хөрөнгө оруулалтын тухай**<br>**2013-10-03**<br>**Дугаар 2013.11.01**<br>11.2.1.. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; (11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:) | Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг БНЭУ-ын Экспорт-Импорт банктай байгуулсан Зээлийн ерөнхий хэлэлцээрийн холбогдох заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын холбогдох заалтын дагуу гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх арга хэмжээг авч ажиллав. | 100% | |
| 21 | 2 | 2 | **Газрын тосны тухай /Шинэчилсэн найруулга/**<br>**2014-07-01**<br>**Дугаар 2014_06**<br>8.1.9. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах; | Газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн төсөл, нөлөөллийн үнэлгээг Канадын Мерит төслийн зөвлөх Майк Поссенти, АМГТГ, МХЕГ, Петроматад ХХК, Түмэн-Ойл ХХК, Макс Ойл ХХК, Петрочайна Дачин Тамсаг ХХК, Жи Өү Эйч ХХК компаниудтай хамтран боловсруулсан. ХНХЯ, МХЕГ, Онцгой байдлын газар, Стандарт, хэмжил зүйн газруудад УУХҮСайдын 2022.02.11-ний өдрийн 01/316 дугаар албан бичгээр дүрмийн төсөлд санал авахаар хүргүүлсэн. Мөн яамны цахим хуудаст байршуулан санал авч, ирүүлсэн саналыг дүрмийн төсөлд тусгасан. Дүрмийн төслийг эцэслэн боловсруулж, батлуулахаар удирдлагуудад танилцуулж байна. | 70% | |
| 22 | 3 | 3 | **Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих**<br>**2021-01-29**<br>**Дугаар 2021.01.29**<br>3.3. Энэ хуульд заасан харилцааг нарийвчлан зохицуулах Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална. | Хуулийн 3.3 дахь хэсэгт заасан Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг ЗГ-ын 2021.08.11-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор батлуулав. | 100% | |
| 2.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 23 | 1 | 1 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>**2016-11-17**<br>**Дугаар 2016 №69**<br>2/2.. Түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. (2/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:) | Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна гэж хуульчилсан бөгөөд 2014 онд Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд болох Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт орших БХГ-97 талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөр 7%, Дорнод аймгийн Тамсагийн сав газарт орших Тосон-Уул-XIX талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд газрын тосны нөөц ашигласны төлбөрийг шууд авахаар дурдаагүй хэдий ч Монгол Улсад ногдох хувь хэмжээнд нөөц ашигласны төлбөрийг хамаарахаар гэрээнд тусгасан байдаг, харин Тамсаг-XXI талбайн хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 7.5%-иар гэрээнд тусгаж өгсний дагуу экспортолж буй газрын тосноос нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу авч Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. УУХҮСайдын 2018 оны А/12 дугаар тушаалаар байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх хэлэлцээр хийх үүрэг бүхий ажлын хэсэг Гэрээлэгч компаниудтай хэлэлцээр хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан бөгөөд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг бүрэн шинэчилсэн. Харин газрын тосны ашиглалт, экспортын үйл ажиллагаа явуулж буй Гэрээлэгч компаниудтай удаа дараа хэлэлцээр хийсэн боловч Гэрээлэгч тал өнөөг хүртэл хөрөнгө оруулалтаа нөхөж аваагүй алдагдалтай ажиллаж байгаагаас гадна 2014 | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох заалтууд нь хууль батлагдахаас өмнө БХГ байгуулсан Гэрээлэгчийн эрх ашиг, эдийн засгийн нөхцөл байдалд хохирол учруулах, сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа тул гэрээлэгч компанийн зүгээс нэгэнт байгуулсан гэрээг өөрчлөхгүй байх зарчмын байр суурийг тухай бүр илэрхийлсээр байна. Жилийн уулзалт бүрт уг асуудлыг хөндөж байгаа боловч үр дүнд хүрээгүй байна. | | |
| 2.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 24 | 1 | 1 | **Чиглэл өгөх тухай**<br>**2018-10-30**<br>**Дугаар 2018 №32 ЭЗБХ**<br>2.4/. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн олон талт эх үүсвэртэй байх бодлого баримтлах, Гашуунсухайт-Ганц модны боомтоор шатахуун импортлох ажлыг эхлүүлэх. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Өмнөговь аймаг дахь Шивээхүрэн болон Гашуунсухайт боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг баталсан. Үүний дагуу тус 2 боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2022.04.05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтад Шунхлай ХХК шалгарч, тус яамтай хамтран ажиллах тухай №21, №22 тоот гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Гэрээ байгуулж, үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Шивээхүрэн болон Гашуунсухайт боомтын хилийн зурвас дагуу шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг Засгийн газрын 2022 оны 53 дугаар тогтоолд хамтран ажиллахаар нэр дурдсан төрийн болон орон нутгийн холбогдох байгууллагуудад УУХҮСайдын 2022.05.30-ны өдрийн 01/1539 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | 100% | |
| 2.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 2.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 2.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 25 | 1 | 1 | **Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай**<br>**2022-04-20**<br>**Дугаар 2022_160**<br>3. АИ-92 автобензин импортлох, худалдаалах аж ахуйн нэгжтэй ниййлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах гэрээ байгуулан, биелэлтийг хангуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т үүрэг болгосугай | Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензин импортлох, худалдаалах аж ахуйн нэгжтэй ниййлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах “Хариуцлагын гэрээ”-ний загварыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулсан. Гэрээний загварын дагуу газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч 14 компанитай 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр хариуцлагын гэрээ байгуулсан ба УУХҮЯ болон АМГТГ гэрээний биелэлтийг хангуулан ажиллаж байна. “Хариуцлагын гэрээ” байгуулсан нэр бүхий 14 аж ахуйн нэгжүүдээс АИ-92 автобензиний гадаад захиалга, импорт, үлдэгдэл, нөөц, үнийн мэдээ, тайланг 7 хоног бүрийн мягмар гарагт авч, үлдэгдэл нөөц, үнийн байдалд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. Тус тогтоол батлагдсанаас хойших 2 сарын хугацаанд өргөн хэрэглээний АИ-92 автобензиний үнэ нэмэгдээгүй, 2390 төг/л тогтвортой хадгалагдаж, импорт, ниййлүүлэлт хэвийн түвшинд байгаа бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн байдлаар Улсын хэмжээнд Аи-92 автобензин нийт 49 мянган тонн буюу 37 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний үлдэгдэл, нөөцтэй байна | 100% | |
| 26 | 2 | 2 | **Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын талаар авах арга хэмжээний тухай**<br>**2022-04-20**<br>**Дугаар 2022_161**<br>3. Дотоодын зах зээлд борлуулж байгаа дизелийн түлшний хангамж, ниййлүүлэлт, | Тус тогтоолын дагуу импортоор оруулж ирсэн автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 0 болгон шинэчлэн тогтоосон. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд дотоодын зах зээлд борлуулж буй дизель түлшний хангамж, ниййлүүлэлт, жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээ авч, импортлогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласны үр дүнд бодит өртөг нь 3681 төгрөг болж нэмэгдсэн дизель түлшийг өнөөгийн байдлаар 3430 төгрөгөөр худалдан борлуулж байна. Дэлхийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | жижиглэнгийн үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (С.Мөнхчулуун) нарт үүрэг болгосугай. | зах зээл дээрх газрын тосны үнийн хэлбэлзэл, огцом нөлөөллийг бууруулах, дотоодын автобензин, дизель түлшний үнийг тогтвортой байлгах, цаашлаад өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор тус яамны зүгээс холбогдох ажлуудыг хууль тогтоомжоор олгосон чиг үүргийн хүрээнд тухай бүр шуурхай зохион байгуулан ажиллаж байна. Дотоодод борлуулах дизель түлшний үнийн огцом өсөлтийг саармагжуулах хүрээнд татварын зохицуулалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлсэн ба Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор Аи-92 автобензиний Гаалийн албан татварыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл тэг хувиар, дизель түлшний Онцгой албан татварыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал тэг хувиар тус тус тогтоохоор шийдвэрлэсэн. Дизель түлшний Онцгой албан татварыг тэглэснээр жижиглэгийн үнэ 500 төг/л-ээр нэмэгдэх нөхцөл байдлыг саармагжуулж чадсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд бүх төрлийн шатахуун импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс гадаад захиалга, импорт, үлдэгдэл, нөөц, үнийн мэдээ, тайланг 7 хоног бүрийн мягмар гарагт авч, үлдэгдэл нөөц, үнийн байдалд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. Тус тогтоол батлагдсанаас хойших сар гаруйн хугацаанд дизель түлшний үнэ нэмэгдээгүй тогтвортой хадгалагдаж ирсэн боловч дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт, ОХУ-аас нийлүүлэх 06 дугаар сарын хил үнэ нэмэгдэл, ам.долларын ханшийн өсөлт зэрэг гадаад нөхцөл байдал, хүчин зүйлсээс шалтгаалан 2022 оны 06 дугаар сарын 18-ны өдөр дизель түлшний жижиглэн борлуулалтын үнэ 300 төг/л-ээр нэмэгдсэн. Дизель импорт, нийлүүлэлт, хангамж хэвийн түвшинд хадгалагдаж байгаа ба 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар Улсын хэмжээнд нийт 70,6 мянган тонн буюу 29 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний үлдэгдэл, нөөцтэй байна. | | |
| 27 | 3 | 3 | **Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_74** 3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 2022 онд нэмж бүрдүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийг Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 2022 онд нэмж бүрдүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийг Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулан 2021.05.31-ний өдрийн 01/1380 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Улсын төсөвт тусгагдаагүй. | 70% | |
| 28 | 4 | 4 | **Газрын тосны хайгуулын талбай олгох тухай 2021-08-25 Дугаар 2021_266** 2. Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд газрын тос хайх тусгай зөвшөөрлийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д хууль тогтоомжийн дагуу олгох, хайгуулын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т даалгасугай. | Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д олгосон. Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд газрын тос хайх тусгай зөвшөөрлийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д хууль тогтоомжийн дагуу олгох асуудлын хүрээнд Давст XXXI талбайд хамаарах хайгуул, судалгааны ажлын тайлан, материал, мэдээллийг хүлээлцэх ажил хийгдэж дууссан. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-иас газрын тос хайх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлээгүй байна. Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайн мэдээлэлд үндэслэн талбайг 5 хэсэгт хуваан хэсэг, тус бүрт хөрөнгө оруулагч татахаар мэдээлэл боловсруулан ажиллаж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 29 | 4 | 5 | 3. Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд хамаарах хайгуул, судалгааны ажлын тайлан, материал, мэдээллийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д шилжүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний геологийн алба (О.Чулуун), Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (Д.Алтанцэцэг)-д тус тус үүрэг болгосугай. | Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд хамаарах хайгуул, судалгааны ажлын тайлан, материал, мэдээллийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д шилжүүлэх талаар УУХҮСайдын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2772, 01/2773, 01/2774 дугаартай албан бичгүүдээр АМГТГ, ҮГА болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-т тус тус чиглэл хүргүүлсэн албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу мэдээлэл, тайлан хуулбарлах ажил хийгдэж дууссан. Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-аас “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д Давст XXXI талбайд 1995-2009 оны хооронд хийгдсэн 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын анхдагч өгөгдөл болон боловсруулалтын 6 ширхэг зөөврийн хатуу диск, 232 ширхэг 3490 маркийн картриджид хадгалагдаж буй 3514.072GB (3.514 TB) хэмжээтэй мэдээлэл, цахим хэлбэрээр хуулбарлан авсан 57 цооногийн LAS өргөтгөлтэй каротажийн бичиглэл бүхий файлууд (302 MB хэмжээтэй) үнэ төлбөргүй хуулбарлан өгсөн. | 100% | |
| 30 | 5 | 6 | **Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай**<br>**2021-10-06**<br>**Дугаар 2021_311**<br>2. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн 2022 оны компанийн нөөцийн хэмжээ, бүтээгдэхүүний нэр, төрлийг хавсралт ёсоор баталсугай.<br>2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | Тус тогтоол батлагдан гарсантай холбогдуулан УУХҮСайдын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/18 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх гэрээний үлгэрчилсэн загварыг батлуулсан. Батлагдсан гэрээний загвар, тушаал шийдвэрийг 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 08/280 дугаар албан бичгээр АМГТГ-т хүргүүлсэн. АМГТГ тус батлагдсан гэрээний загварын дагуу аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан нөөцийн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 72, Аи-92 автобензин 36, Аи-95 автобензин 51, дизелийн түлш 28, ТС-1 65 хоногийн нөөцтэй байна. Мөн тус тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн 28 аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүжилтийг дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, ОХУ-аас ирүүлсэн 11 сарын хил үнийг үндэслэн нийт 762,575.97 сая төгрөгийн санхүүжилтийг хөнгөлттэй зээл хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн. Нэмэлт санхүүжилт олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулснаар шатахууны хангамж тогтворжиж, хомстол үүсэхгүй байх нөхцөл бүрдсэн. | 100% | |
| 31 | 6 | 7 | **Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар улсын хилийн зурвас газар ашиглуулах тухай**<br>**2022-01-26**<br>**Дугаар 2022_53**<br>2. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг газрын тос импортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтээр шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай. | Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Өмнөговь аймаг дахь Шивээхүрэн болон Гашуунсухайт боомт орчмын хилийн зурвас газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг баталсан. Үүний дагуу тус 2 боомт орчмын хилийн зурвас газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2022.04.05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтад Шунхлай ХХК шалгарч, тус яамтай хамтран ажиллах тухай №21, №22 тоот гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Гэрээ байгуулж, үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Шивээхүрэн болон Гашуунсухайт боомтын хилийн зурвас дагуу шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих үйл ажиллагаа эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг Засгийн газрын 2022 оны 53 дугаар тогтоолд хамтран ажиллахаар нэр дурдсан төрийн болон орон нутгийн холбогдох байгууллагуудад УУХҮСайдын 2022.05.30-ны өдрийн 01/1539 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 32 | 7 | 8 | **Газрын тос дамжуулах хоолой барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2022-03-02**<br>**Дугаар 2022_94**<br>2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос дамжуулах хоолойн байгууламж барихад шаардагдах 397.0 (гурван зуун ерэн долоо) сая ам.долларыг бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар)-д зөвшөөрсүгэй. 2. Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд үүрэг болгосугай. | Төслийн захиалагч Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төслийн санхүүжүүлэгч “ЭТТ” ХК, төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит Норинко компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр Хамтран ажиллах гэрээг, “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд 2022.4.21-ний өдөр дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээ, “МГТБҮ” ТӨХХК болон “ЭТТ” ХК-ийн хооронд 2022.4.22-ны өдөр дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээг, “ЭТТ” ХК болон “Норинко” компанийн хооронд 2022.4.22-ны өдөр нүүрс худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулсан. “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд байгуулсан, дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээний хүрээнд зураг төслийн ажил хийгдэнэ. | 70% | |
| 2.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 2.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 33 | 1 | 1 | **2020 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 69 дүгээр тэмдэглэл**<br>**2020-12-09**<br>**Дугаар 2020_69**<br>XYI.8. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулах талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд олон улсад нээлттэй сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй байгуулах гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | УУХҮЯ-ны ТНБД-ын 2021 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг олон улсын сонгон шалгаруулалтыг явуулж БНХАУ-ын Норинко интернейшнл компанийг шалгаруулсан. Шалгарсан компанитай гэрээ байгуулах талаар ЗГ-ын 2022.3.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл, 94 дүгээр тогтоолыг тус тус гаргуулж, хоолойн байгууламж барихад шаардагдах санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу Төслийн захиалагч Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төслийн санхүүжүүлэгч “ЭТТ” ХК, төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит Норинко компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр Хамтран ажиллах гэрээг, “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд 2022.4.21-ний өдөр дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээ, “МГТБҮ” ТӨХХК болон “ЭТТ” ХК-ийн хооронд 2022.04.22-ны өдөр дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээг, “ЭТТ” ХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.22-ны өдөр нүүрс худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулсан. “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд байгуулсан, дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээний хүрээнд зураг төслийн ажил хийгдэнэ. | 100% | |
| 34 | 2 | 2 | **2021 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 10 дугаар тэмдэглэл**<br>**2021-02-14**<br>**Дугаар 2021_10**<br>I.2. 19. Халдварт цар тахлын хүндрэлтэй нөхцөлд бүх төрлийн шатахуун, дизель | Тус тэмдэглэлийн 19 дүгээр заалтын дагуу газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнийн талаарх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 01/460 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | түлшний жижиглэнгийн үнийг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | | | |
| 35 | 3 | 3 | **2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл**<br>**2021-03-03**<br>**Дугаар 2021_14**<br>XII.4. 4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолой барих санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, тус бүтээн байгуулалтын ажлыг ойрын үед эхлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт, Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг ОХУ болон бусад улсаас нийлүүлэх боломжийг судлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Олон улсын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шалгарсан компанитай төслийн санхүүжилтийг шийдвэрлэн, холбогдох гэрээнүүдийг байгуулсан. Үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг ОХУ болон бусад улсаас нийлүүлэх боломжийн талаар судалж байна. | 70% | |
| 36 | 4 | 4 | **2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br>**2021-03-10**<br>**Дугаар 2021_17**<br>XII.7.6. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, агаарын хөлгийн шатахууныг олон эх үүсвэрээс нийлүүлэх болон “Жет А-1” төрлийн түлш импортлох боломжийг судалж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Иргэний нисэхийн ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т | УУХҮСайдын 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/50 дугаар тушаалаар төрийн өмчит “Эрчис ойл” компанитай хамтран “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийг хамтран ашиглах санал ирүүлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай гэрээ, хэлэлцээр хийх бэлтгэл ажлын хүрээнд гэрээлэгчтэй хамтран ажиллах зарчмыг тодорхойлох үүрэг бүхий ХЗДХЯ, УУХҮЯ, ЗТХЯ, ИНЕГ-ын хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг тус шатахуун хангамжийн байгууламжийг ашиглаж болох боломжит хувилбаруудын талаарх холбогдох тооцоо, судалгааг хийсэн. Эрчис ойл компани болон ОХУ-ын РН-Аэро компанитай хамтран ажиллах хэлцэл хийж, Санамж бичгийг байгуулах асуудлаар танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулж, УУХҮСайдын 2022.03.01-ний өдрийн 01/520 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэн Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. ОХУ-ын Москва хотноо 2022.03.10-ны өдөр “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийг ашиглах талаар хамтран ажиллах тухай Санамж бичигт УУХҮСайд Г.Ёндон болон Роснефть НХН-ийн Ерөнхийлөгч И.И.Сечин нар гарын үсэг зурсан. | 100% | |
| 37 | 5 | 5 | **2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл**<br>**2021-07-07**<br>**Дугаар 2021_41**<br>XXYII.2.. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаа болон охин компаниудын өнөөгийн байдал, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд аудит хийсэн дүн, Ажлын хэсгийн дүгнэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Газрын тос боловсруулах | Газрын тосны хайгуулын Матад XX талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дугээр дүгнэлтийг үндэслэн, УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн “Матад-XX талбайн нөөц бүртгэх тухай” А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг “баталгаат (1P)” зэрэглэлээр 1,151,194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,931.0 тонн (1.04 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай (2P)” зэрэглэлээр 3,051,724.0 тонн (23.01 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай+боломжтой (3P)” зэрэглэлээр 5,385,942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит бус цахим хуралдаанаар Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт болон тус үйлдвэрийг түүхий эдээр хангахтай холбоотой судалгааны материалыг танилцуулж, Ерөнхий сайдын захирамж | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэрийг түүхий газрын тосоор тогтвортой тасралтгүй, найдвартай хангах судалгаа, тооцоог хийж, нөөц болон олборлолтыг өсгөх ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав; | гаргахаар тогтсон бөгөөд захирамжийг албажуулахаар ЗГХЭГ-т 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/1634 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. | | |
| 38 | 6 | 6 | **2021 оны 7 дугаар сарын 28-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл**<br>**2021-07-28**<br>**Дугаар 2021_44**<br>Х.1. 2. . Эдийн засаг, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн тээвэрлэж буй ачаа барааны талаарх мэдээлэл хүсэлтийг Замын-Үүд хилийн Боомтын зөвлөлд тухай бүр хүргүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт даалгав. | Эдийн засаг, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн тээвэрлэж буй ачаа барааг Замын-Үүд хилийн боомтоор татан авах болон уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх санал, мэдээллийг бэлтгэн тухай бүр Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа зэрэг байгууллагуудад хүргүүлж ажилласан. Тухайлбал, тус яамнаас 2021.11.30-ны өдрийн 02/2961, 2022.12.06-ны өдрийн 03/3022, 2022.01.14-ний өдрийн 02/93, 2022.02.23-ны өдрийн 03/453, 2022.03.25-ны өдрийн 03/761 дүгээр албан бичгүүдийг дээр дурдсан байгууллагуудад хүргүүлсэн байна. | 100% | |
| 39 | 7 | 7 | **2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл**<br>**2021-06-23**<br>**Дугаар 2021_36**<br>XII.9.2. Нийслэлийн хүн амын хэрэгцээнд шаардлагатай сайжруулсан шахмал түлш болон "Тавантолгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үндсэн түүхий эд (мидлинг), барьцалдуулагчийн нөөц бүрдүүлэлт, тээвэрлэлтэд онцгой анхаарал тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, "Тавантолгой түлш" ХХК (М.Ганбаатар)-д; | "Таван толгой түлш" ХХК нь Улаанбаатар хотын 6 дүүргийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах хүчин чадлаа нэмэгдүүлэн ажиллаж, шахмал түлшний үндсэн түүхий эд /мидлинг/-ийг Дундын бүс болон Баруун, Зүүн үйлдвэрийн бүсэд нийт 725,600 тонн татан төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласан. 2021.10.25-ны өдрөөс хойш нийт 4796 тээврийн хэрэгслээр 214 895 тонн мидлинг тээвэрлэсэн. Сайжруулсан шахмал түлшний мидлинг тээвэрлэх зардлыг 2018 онд 65000 төгрөг байхаар тогтоосон бөгөөд бараа материал, тээврийн зардлын үнийн өсөлттэй уялдуулан 85000 төгрөг болгон өсгөх холбогдох тооцоо судалгааг хийж гүйцэтгэсэн. Энэхүү тооцоо, судалгааг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.10.29-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор нийт 400 мянган тонн мидлинг тээвэрлэхэд шаардагдах 40.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.<br>Мидлинг тээвэрт Зэвсэгт хүчний жанжин штабын тээврийн хэрэгслийг оролцуулах асуудлаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр холбогдох бусад албан тушаалтантай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, ЗХЖШ-ын 80 тээврийн хэрэгслийг мидлинг тээвэрлэлтэд дайчлан ажиллуулсан. ЗХЖШ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу эдгээр автомашиныг нэг удаа татан авах түлш шатахууны зардлыг шийдвэрлэсэн. Мөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай тээвэрлэлтийн хариуцлагын гэрээтэй аж ахуй нэгж байгууллагуудыг мидлинг тээвэрт оролцуулах зорилгоор 3 удаагийн уулзалт зохион байгуулсан бөгөөд "Говь шанх транс" ХХК, "Монгол тээвэр нэгдэл"-ийн 16 тээврийн компани мидлинг тээвэр хийх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.<br>Мидлинг тээврийн тонн тутмын үнийг 85000 төгрөг болгон тогтоосноор 4894 тээврийн хэрэгсэл гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд өдөрт 10000-11000 тонн мидлинг тээвэрлэж байна.<br>Үүнээс гадна "Энержи Ресурс" ХХК-тай өдөрт ачилт хийх машины тоог 200 хүртэл нэмэгдүүлэх, нэг машинд 66 тонн хүртэл ачилт хийх асуудлаар харилцан тохиролцож, мидлинг тээврийн маршрутыг баталсан бөгөөд Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас Даланзадгад сум хүртэл 59.2 км замын дагуу шинээр тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, хуучин тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх ажлыг зохион байгуулсан. Сайжруулсан шахмал түлшний үндсэн түүхий эд (мидлинг), барьцалдуулагчийн нөөц бүрдүүлэлт, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран тухай бүр шаардлагатай ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшээр тасралтгүй хангах зорилгоор сайжруулсан шахмал түлшний үндсэн түүхий эд (мидлинг), барьцалдуулагчийн нөөц бүрдүүлэлтэд тогтмол хяналт тавин ажилласан бөгөөд 2021-2022 оны өвлийн улиралд нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд 497,200 тонн сайжруулсан шахмал түлш нийлүүлж ажилласан. 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлшний түүхий эд /мидлинг/-ийн 88,423.5 тонн, барьцалдуулагч 5,510.7 тонн нөөцтэй байна. “Таван толгой түлш” ХХК нь 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 200,000 тонн сайжруулсан шахмал түлш нөөцлөхөөр ажиллаж байгаа бөгөөд 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 30,931 тонн түлш нөөцлөөд байна. | | |
| 40 | 8 | 8 | **2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 47 дугаар тэмдэглэл**<br>**2021-08-18**<br>**Дугаар 2021_47**<br>XIY.5. . Шатахууны үнэ тогтворжуулах сангийн үйл ажиллагаа болон бусад улс орны туршлага, эрх зүйн орчин, хүрэх үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан шатахууны үнийг тогтворжуулах сан байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, санхүүжилтын эх үүсвэрийн талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | Тус тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг тус тус боловсруулж, санал авахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/2432 дугаар албан бичгээр яамдад хүргүүлсэн. Тус хуулийн төслийг дэмжих боломжгүй талаар Сангийн яамнаас 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 8-215680 дугаар албан бичгээр санал ирүүлсэн. Иймд хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх боломжгүй болсон. | /-/ | |
| 41 | 9 | 9 | **2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл**<br>**2021-10-13**<br>**Дугаар 2021_55**<br>XY.13.2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэдэх “Эрдэнэс газ” төслийн нэгжийг татан буулгаж, төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Хаянхярваад; | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэдэх “Эрдэнэс газ” төслийн нэгжийг татан буулгаж, төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шийдвэрийн төслийг боловсруулах асуудлаар Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын албаны дарга Баяр-Эрдэнэ, “Эрдэнэс монгол ХК-ийн дэд дарга Энхболд, “Эрдэнэс газ” төслийн нэгжийн дарга Амарсайхан нар уулзалт зохион байгуулсан ба “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зүгээс төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шаардлагагүй гэж үзсэн | /-/ | |
| 42 | 10 | 10 | **2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>**2021-11-03**<br>**Дугаар 2021_58**<br>XII.6.8. Гадаад зах зээлийн шатахууны үнийн хэт өсөлтөөс хамаарсан дотоодын | Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Засгийн газрын 2020 оны 232 дугаар тогтоолоор байгуулагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн хуралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, шатахууны хангамжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, гадаад хүчин зүйлсээс хамаарч дотоодод борлуулах шатахууны жижиглэнгийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | жижиглэнгийн үнийн огцом хэлбэлзлийг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт | үнийн огцом хэлбэлзлийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Тус хуралдаанаас өргөн хэрэглээний Аи-92 автобензины хангамж, нөөцийг Засгийн газрын холбогдох тогтоолд заасан хэмжээгээр бүрдүүлж, тус бүтээгдэхүүний жижиглэн борлуулалтын үнийн өөрчлөлтийг огцом хэлбэлзэл үүсгэхгүйгээр сүүлийн 6 сарын хөдөлгөөнт дундаж үнээр тооцож өөрчлөлт оруулах, цаашид үе шаттайгаар зах зээлийн горимд аажмаар шилжүүлэх бодлого баримтлан ажиллахыг УУХҮЯ, АМГТГ болон шатахууны худалдаа эрхлэгч ААН-үүдэд зөвлөмж болгосон. | | |
| 43 | 11 | 11 | **2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл**<br>**2021-12-08**<br>**Дугаар 2021_63**<br>ХҮ.3.1.2. Бусад салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний инфляцид үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд; | Шатахууны хил үнийн өндөр өсөлттэй холбоотой аж ахуйн нэгжүүдийн худалдан авах чадвар буурсан, эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон зэрэг асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн 28 аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүжилтийг дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, ОХУ-аас ирүүлсэн 11 сарын хил үнийг үндэслэн нийт 762,575.97 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгох асуудлыг Монголбанктай хамтран шийдвэрлэж, арилжааны банкуудаар дамжуулан зээлийг олгоод байна. Ингэснээр МУ-ын газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нөөц тогтвортой байна. Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 160 дугаар тогтоолыг батлуулсан. Тус тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн ОХУ-ын Роснефть НХН-ээс урт хугацааны газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулсан дотоодын аж ахуйн нэгжүүдийн 2022 оны 4,5,6 дугаар саруудад Аи-92 автобензин худалдан авах урьдчилгаа төлбөрийн зориулалтаар 2022 онд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр арилжааны банкуудаас авах зээлийн үнийн дүнгийн 85 хүртэлх хувийн эх үүсвэрийн эргэн төлөлтөд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг СЯ, Монголбанктай хамтран шуурхай зохион байгуулж 4, 5, 6 дугаар саруудын Аи-92 автобензинийн худалддан авалтад шаардлагатай урьдчилгаа төлбөр болох 100,8 сая ам.долларыг аж ахуйн нэгжүүдэд Засгийн газрын баталгааг үндэслэн арилжааны банкуудаар дамжуулан зээл олгох асуудлыг шийдвэрлэсэн. Уг ажлын дүнд өргөн хэрэглээний Аи-92 автобензинийн жижиглэн борлуулатын үнэ 4, 5, 6 дугаар саруудад тогтвортой, хангамж хэвийн үргэлжилж байна. | 100% | |
| 44 | 11 | 12 | ХҮ.5.4. Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, Евро-5 ангиллаас доош чанартай шатахууныг жижиглэнгээр худалдан борлуулахыг үе шаттай хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Улсын хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар нийт 680,6 мянган тонн шатахуун импортлон хэрэглэснээс Евро-5 стандартын шатахуун 144,7 мянган тонн буюу нийт шатахууны 21,3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автобензин дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар дэлгэрэнгүй тооцоо судалгаа, танилцуулга бэлтгэн УУХҮСайдын 2022.02.24-ний өдрийн 01/469 дүгээр албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. Мөн Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Евро 5 стандартын шаардлага хангасан автобензины импорт, үнийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, УУХҮ-ийн дэд сайдын 2022.02.14-ний өдрийн 02/345 дугаар албан бичгээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн.<br>Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, чанар стандартын шаардлага хангахгүй шатахуун гарган авах зориулалтаар импортолж буй зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах замаар агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулах тухай УУХҮ-ийн Дэд сайдын 2021.01.12-ны өдрийн 02/67 дугаар бичгээр ОББҮХ-нд хүргүүлсэн. Дээрх асуудал ОББҮХ-ны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан ба тус чиглэлээр ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажилласан. Үүний үр дүнд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дах хэсэгт “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах” гэж хориглох тухай нэмэлт орсон. Ийнхүү автотээврийн хэрэгслээс ялгаруулах агаарын бохирдлыг үр дүнтэй бууруулахын тулд Агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлагад хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдсэн. | | |
| 45 | 12 | 13 | **2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 64 дүгээр тэмдэглэл**<br>**2021-12-14**<br>**Дугаар 2021_64**<br>XIY.11. . Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Роснефть” НХН хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл болон “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн үйл ажиллагааг эрхлэх хамтарсан компани байгуулах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Роснефть” НХН хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт импортыг хамтарсан компаниар хийх тохиолдолд дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг эхний ээлжид борлуулах нөхцөлийг тусгах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн үйл ажиллагаа явуулах хамтарсан компани нь дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг эхний ээлжид борлуулах тухай нөхцөлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Роснефть” НХН хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичигт тусгасан. Тус Санамж бичгийг ОХУ-ын Москва хотноо 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдөр УУХҮСайд Г.Ёндон болон Роснефть НХН-ийн Ерөнхийлөгч И.И.Сечин нар гарын үсэг зурж баталгаажуулсан | 100% | |
| 46 | 13 | 14 | **2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 59 дүгээр тэмдэглэл**<br>**2021-11-10**<br>**Дугаар 2021_59**<br>XIII.5. . Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. 1. Үүнтэй холбогдуулан уг | Хийн хоолойн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-ийг тусгай зориулалтын компани “Газопровод Союз Восток” ХХК 2021.12.15-ны өдөр монголын талд хүлээлгэн өгсөн.<br>2022 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов нар Монгол Улсын Засгийн газар болон “Газпром” НХН-ийн Хамтарсан ажлын хэсгийн 2022–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж тус төлөвлөгөөний дагуу 2022.02.28-ны өдөр инженерийн хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудын даалгаврыг баталж “Газопровод Союз Восток” ХХК болон “Газпром Проектирование” ХХН-ийн хооронд инженер хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг гүйцэтгэх Гэрээнд гарын үсэг зурсан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төслийн талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт даалгав: 1.1. Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг улам эрчимжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; 1.2. Байгалийн хий нийлүүлэх магистраль шугамнаас Монгол Улс өөрийн дотоодын хийн хэргэлгээгээ авах эсэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт; 1.3. Уг төслийг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ авах асуудлыг судлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт. | Үүний дагуу 2022.04.28-ны өдөр инженерийн хайгуул судалгааны ажил эхэлж, судалгааны ажил явагдаж байна. Байгалийн хий дамжуулах хоолойн шугамын чиг /трасс/-ийг тодорхойлох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.04.05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулан ажилд нь оруулаад байна. Мөн Шадар сайдаас өгсөн чиглэлийн дагуу төслийн хэрэгжилтэд төрөөс дэмжлэг үзүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох яамдаас саналыг авч ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулуулах хүсэлтийг 2022.04.28-ны өдрийн 01/1231 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | | |
| 47 | 14 | 15 | **2022 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр 2 дугаар тэмдэглэл 2022-01-06 Дугаар 2022_2** Ү.1. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрт гарсан гал түймрээс үүдэн гарсан хохирлыг тооцож, нэн яаралтай сэргээн засварлах ажлыг зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрт гарсан гал түймрээс шалтгаалсан хохирлыг тооцож, “Таван толгой түлш” ХХК нь “ДЦС-4” ТӨХК, “ДЦС-3” ТӨХК, “ДЦС-2” ТӨХК, “Амгалан ДС” ТӨХК-ийн инженер техникийн ажилтнуудтай хамтран шуурхай сэргээн засварлаж, үйлдвэрийг хэвийн ажиллагаанд залгаж, үйлдвэрийн 1 дүгээр шугамыг 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр, 2 дугаар шугамыг 01 дүгээр сарын 24-ний өдөр тус тус ажиллагаанд оруулсан. | 100% | |
| 48 | 15 | 16 | **2022 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр 2 дугаар тэмдэглэл 2022-01-12 Дугаар 2022_3** XXYII.4.2. Автобензин, дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2022 оны 1 дүгээр улирал багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт | Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автобензин дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар дэлгэрэнгүй тооцоо судалгаа, танилцуулга бэлтгэн УУХҮСайдын 2022.02.24-ний өдрийн 01/469 дүгээр албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. Мөн Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Евро 5 стандартын шаардлага хангасан автобензины импорт, үнийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, УУХҮ-ийн дэд сайдын 2022.02.14-ний өдрийн 02/345 дугаар албан бичгээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн.<br>Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, чанар стандартын шаардлага хангахгүй шатахуун гарган авах зориулалтаар импортолж буй зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах замаар агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулах тухай УУХҮ-ийн Дэд сайдын 2021.01.12-ны өдрийн 02/67 дугаар албан бичгээр ОББҮХ-нд хүргүүлсэн. Дээрх асуудал ОББҮХ-ны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан ба тус чиглэлээр ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажилласан. Үүний үр дүнд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дах хэсэгт “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах” гэж хориглох тухай нэмэлт орсон. Ийнхүү автотээврийн хэрэгслээс ялгаруулах агаарын бохирдлыг үр дүнтэй бууруулахын тулд Агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлага хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдсэн. | | |
| 49 | 15 | 17 | XXYII.5. . “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний баруун бүсийн үйлдвэрийн 1 дүгээр цехийн засварын ажлыг эрчимжүүлэх, шаардагдах санхүүжилт зардлын тооцоог гаргаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар нарт даалгав. | Сайжруулсан шахмал түлшний 1 дүгээр үйлдвэрийн засварын ажлыг шуурхай зохион байгуулж, 14 хоногт багтаан шугамыг багтаан ашиглалтад оруулж шаардагдах санхүүжилтийг тооцоо судалгаанд үндэслэн шийдвэрлэн ажилласан. | 100% | |
| 50 | 15 | 18 | XXYII.5.2. Зүүн бүсийн үйлдвэрийн талбайд сайжруулсан шахмал түлшний шинэ технологи бүхий үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгав. | Эрчим хүчний яамнаас өгсөн мэдээллээр Зүүн бүсийн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх, техник, шинэчлэлийн төлөвлөөгүй ажлын зардалд 50.0 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд хөрөнгө оруулалтын асуудлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК шийдвэрлэхээр ажиллаж байна.<br>Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнд сайжруулсан шахмал түлшний шинэ үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайжруулсан шахмал түлшний технологи боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. | 30% | |
| 51 | 16 | 19 | **2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр 5 дугаар тэмдэглэл**<br>**2022-01-19**<br>**Дугаар 2022_5**<br>XYIII.7. . Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулах дэвшилтэт технологийн судалгаа, туршилт хийж, үр дүнг 2022 оны 1 улиралд багтаан танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, “Эрдэнэс-Тавантолгой” ХК (Б.Ганхуяг), “Тавантолгой түлш” ХХК (М.Ганбаатар)-д; | “Тавантолгой түлш” ХХК-ийн өнөөгийн байдлын талаар Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан. Уг танилцуулгад сайжруулсан шахмал түлшний түүхий эдэд дулааны аргаар боловсруулсан нүүрсийг хэрэглэснээр түлшний чанар сайжрах талаар боломжтой талаар тусгасан.<br>Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Тавантолгой Түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулах дэвшилтэт технологийн шинэчлэлд шаардагдах санхүүжилтийг тус компанийн төсвийн тодотголд тусгаж баталсан байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас “Тавантолгой Түлш” ХХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2022 онд нийт 81,896 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.<br>Сайжруулсан шахмал түлшний чанар, технологийг сайжруулах, стандартыг шинэчлэхээр Эрчим хүчний яам болон “Таван толгой түлш” ХХК, эрдэмтдийн багаас бүрдсэн ажлын хэсэг ажиллаж байна. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 52 | 17 | 20 | **2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр 5 дугаар тэмдэглэл**<br>**2022-01-26**<br>**Дугаар 2022_6**<br>IX.10.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн “Техник эдийн засгийн үндэслэл”-ийг ОХУ-ын “Газпром” НХН-тэй хамтран баталсан талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, барилгын ажлыг 2024 оноос өмнө эхлүүлэх чиглэлээр ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан нарт даалгав. | ОХУ-аас БНХАУ руу дамжуулан барих байгалийн хийн хоолой /трассын хувилбар нь/ нь манай улсын нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг хүн ам ихээр төвлөрсөн суурьшлын бүсүүдээр дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн. Байгалийн хий дамжуулах хоолойн шугамын чиг /трасс/-ийг тодорхойлох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.04.05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулан ажилд нь оруулаад байна. Мөн Шадар сайдаас өгсөн чиглэлийн дагуу төслийн хэрэгжилтэд төрөөс дэмжлэг үзүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох яамдаас саналыг авч ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулуулах хүсэлтийг 2022.04.28-ны өдрийн 01/1231 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 30% | |
| 53 | 18 | 21 | **2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр 29 дүгээр тэмдэглэл**<br>**2022-05-18**<br>**Дугаар 2022_29**<br>XIY.4. . “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах танилцуулгыг бэлтгээд байна. | 70% | |
| 54 | 19 | 22 | **2022 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 8 дугаар тэмдэглэл**<br>**2022-02-01**<br>**Дугаар 2022_8**<br>YII.1.2. Эдийн засаг, стратегийн ач холбогдолтой бүтээн байгуулалтын төсөл болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрлэлд шаардлагатай материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад дагалдах хэрэгслийг тээвэрлэж байгаа ачаа барааны талаарх мэдээлэл, хүсэлтийг | Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэр барих, үйлдвэрт тос дамжуулах хоолой барих төслийн барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг шуурхай тээвэрлэн оруулж ирүүлэх хүсэлтийг холбогдох мэдээллийн хамт тухай бүр Боомтын зөвлөлд хүргүүлж ажиллаж байна. Тухайлбал 2022.02.11-ний 03/320, 2022.04.29-ний 03/1250 дугаартай албан бичгээр тус тус хүсэлт хүргүүлж ажиллав. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа, БНХАУ-ын Хөх хот дахь Ерөнхий консулын газар, Эрээн дахь Консулын газарт тухай бүр гарган өгч байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт даалгав. | | | |
| 55 | 20 | 23 | **2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл**<br>**2022-03-02**<br>**Дугаар 2022_14**<br>XIY.7.8. Шатахууны нийлүүлэлтийг тогтвортой хангах, нийлүүлэлтийн доголдлоос шалтгаалсан үнийн өсөлт, зохиомол хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт; | Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой хангах, нийлүүлэлтийн доголдлоос шалтгаалсан үнийн өсөлт, зохиомол хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төсөл хэлэлцүүлж Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай Засгийн газрын 161 дүгээр тогтоолыг батлуулсан | 100% | |
| 56 | 21 | 24 | **2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br>**2022-03-23**<br>**Дугаар 2022_17**<br>IX.2.2. Шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн шатахууны нөөц бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийн талаар Монголбанктай хамтран судалж дүнг танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, шатахуун худалдан авах урт хугацааны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хүрээнд 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 29-ний өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо УУХҮЯ, АМГТГ, НИК, Шунхлай, М-Ойл, Лекс Ойл, Магнай Трейд зэрэг аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл Роснефть компанитай хамтарсан уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар импортлогч аж ахуйн нэгжүүд болон Роснефть компани хооронд байгуулсан урт хугацааны гэрээний хэрэгжилт, захиалгын тоо, хэмжээ, чанар стандарт, үнийн асуудлаар холбогдох саналуудыг хэлэлцсэн. Мөн шатахууны хил үнийн өндөр өсөлттэй холбоотой аж ахуйн нэгжүүдийн худалдан авах чадвар буурсан, эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн 28 аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүжилтийг дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, ОХУ-аас ирүүлсэн 11 сарын хил үнийг үндэслэн нийт 762,575.97 сая төгрөгийн санхүүжилтийг хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн. Тус зээл нь Монголбанкны бодлогын хүү болох 6-9,5 хувь болон Арилжааны банкны 3 хувийн хүү нэмэгдэж нийт 9-12,5 хувийн хүүтэй олгогдсон. Нийт 19 аж ахуйн нэгжид 364,774.55 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг олгоод байна. | 100% | |
| 57 | 21 | 25 | IX.3.1. Монголбанкны алт, валютын нөөцийг тогтвортой байлгах, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, дизель түлшний онцгой татварыг бууруулах, азотын бордооны импортын өнөөгийн байдлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, хомстлоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор компанийн | Өгөгдсөн үүрэг даалгавартай холбогдуулан танилцуулга, мэдээлэл, шийдвэрийн төсөл бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 160 дугаар тогтоолыг батлуулсан. Тус тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн ОХУ-ын Роснефть НХН-ээс урт хугацааны газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулсан дотоодын аж ахуйн нэгжүүдийн 2022 оны 4,5,6 дугаар саруудад Аи-92 автобензин худалдан авах урьдчилгаа төлбөрийн зориулалтаар 2022 онд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр арилжааны банкуудаас авах зээлийн үнийн дүнгийн 85 хүртэлх хувийн эх үүсвэрийн эргэн төлөлтөд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн болон азотын бордоо импортлогч аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай нэмэлт санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Монголбанктай зөвшилцөн, саналаа Засгийн газрын хуралдаанаар танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | | | |
| 58 | 22 | 26 | **2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 25 дугаар тэмдэглэл**<br>**2022-04-27**<br>**Дугаар 2022_25**<br>XX.3.1. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав | Газрын тосны хайгуулын Онги-V талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан Капкорп Монголиа болон газрын тосны ашиглалтын Матад-XX талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад орон нутгийн зүгээс талбайн мэдээлэл Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэлгүй гэсэн шалтгаанаар талбайд орж ажиллах боломж олгохгүй байгаа болно. Уг асуудлаар ААН хэд хэдэн удаа Дорнод аймгийн Матад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааныг хийгэсэн боловч холбогдох зөвшөөрлийг олгохоос татгалзсан хариу аваад байна. Иймд шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан Барилга хот байгуулалтын яамнаас газар ашиглах талаарх гэрчилгээг олгуулахаар холбогдох мэдээлэл болон албан хүсэлтийг хүргүүлэхээр холбогдох чиглэлийг өгч ажиллаж байна. Петро Матад XXK нь газрын тосны ашиглалтын үйл ажиллагааг Матад XX талбайд явуулахаар 218 км2 талбайг улсын тусгай хэрэгцээний газраар бүртгүүлж, газрын гэрчилгээ гаргуулах хүсэлтээ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамд хүргүүлсэн бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2022 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 01/547 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд уламжилсан байна. Тус компани нь Матад XX талбайд 2022 оноос эхлэн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх газрын тосны ашиглалтын төслийн хүрээнд газар ашиглах зөвшөөрөл авах хүсэлтээ 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 104/21, 2022 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 002/022, 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 028/022, 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 078/022 дугаартай албан бичгүүдээр Дорнод аймгийн Матад сумын Засаг даргад хүргүүлсэн боловч Матад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар Петро Матад XXK-ийн газар ашиглах тухай хүсэлтийг дэмжээгүй тухай албан бичгийг 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 1/167 дугаартай албан бичгээр Петро Матад XXK-д ирүүлсэн байна. | 30% | |
| 59 | 22 | 27 | XX.1.6. Гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх үнэн бодит мэдээ, мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтарч хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр хүргэж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт. | Монгол Улсын Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 160 дугаар тогтоолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан гэрээ байгуулахаар тусгагдсан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/102 дугаар тушаалаар Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах талаарх “Хариуцлагын гэрээ”-ний загвар баталсан. Уг батлагдсан загвар гэрээний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий “Шунхлай” XXK, “Ойн бирж” XXK, “Синчи газ” XXK ,“Тод петролиум” XXK, Монсуль XXK,“Магнайтрейд” XXK, “Содмонгол групп” XXK,“Энгүүнжим” XXK,“М-Ойл групп" XXK, “Нью энержи стар” XXK, “Эн Пи петролиум “XXK,“НИК” XXK,“Гор газ” XXK, “Ундарга-Увс” XXK зэрэг 14 аж ахуйн нэгжтэй хариуцлагын гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна .Мэдээллийг тухай бүр нийтэд мэдээлж ажиллаж байна | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 60 | 22 | 28 | XX.5. “Тавантолгой түлш” XXK-ийн өнөөгийн байдал, 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх ажлын талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 200,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн шийдвэрлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | 200,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төсвийн тодотголд тусган Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022.05.25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлуулсан байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас “Тавантолгой Түлш” XXK болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2022 онд нийт 81,896 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | 100% | |
| 61 | 22 | 29 | XX.5.5. Зүүн бүсийн үйлдвэрийн талбайд байгаль орчинд ээлтэй, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бүрэн автомат сайжруулсан шахмал түлшний шинэ үйлдвэр барих тооцоо, судалгааг үндэслэн барилга угсралтын ажлыг эхлүүлэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, “Тавантолгой түлш” XXK-ийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн нарт, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | Зүүн бүсийн үйлдвэрлэлийн талбайд байгаль орчинд ээлтэй орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бүрэн автомат сайжруулсан шахмал түлшний шинэ үйлдвэр барих тооцоо судалгааг “Тавантолгой түлш” XXK-иас “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ирүүлээгүй байна. | /-/ | |
| 62 | 22 | 30 | XX.5.6. Сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулах, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ашигтай ажиллуулах зорилгоор хагас коксын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах, холбогдох судалгааг үндэслэн үйлдвэр барих санхүүжилтийг шийдвэрлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг шуурхай зохион байгуулахыг “Тавантолгой түлш” XXK-ийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн нарт | Хагас коксын үйлдвэрийг ТЭЗҮ болон зураг төсөв боловсруулах ажлын зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төсвийн тодотголд тусган Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022.05.25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлуулсан байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас “Тавантолгой Түлш” XXK болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2022 онд нийт 81,896 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | 70% | |
| 63 | 23 | 31 | **2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2022-05-25**<br>**Дугаар 2022_30**<br>XY.3. . “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн үйл | Тагнуулын ерөнхий газрын хүсэлтийн дагуу МИАТ ТӨХК-ийн өмнөх жилүүдийн түлш шатахуун худалдан авалтын талаар болон холбогдох бусад тооцоо судалгаа, дэлгэрэнгүй мэдээллүүдийг бэлтгэн хүргүүлсэн. Уг асуудлыг ЗТХЯ-тай хамтран мэдээлэл танилцуулахаар бэлтгэж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааны талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжид ОХУ-аас нийлүүлэх онгоцны түлшний импортын талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | | | |
| 64 | 24 | 32 | **2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 20 дугаар тэмдэглэл**<br>**2022-04-08**<br>**Дугаар 2022_21**<br>I.1. . Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төсөл батлагдмагц хуулийг хэрэгжүүлэх шуурхай арга хэмжээний талаарх саналаа Монголбанктай хамтран боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт; | Монгол Улсын Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 160 дугаар тогтоолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан гэрээ байгуулахаар тусгагдсан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/102 дугаар тушаалаар Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах талаарх “Хариуцлагын гэрээ”-ний загвар баталсан. Уг батлагдсан загвар гэрээний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий “Шунхлай” ХХК, “Ойн бирж” ХХК, “Синчи газ” ХХК ,“Тод петролиум” ХХК, Монсуль ХХК,“Магнайтрейд” ХХК, “Содмонгол групп” ХХК,“Энгүүнжим” ХХК,“М-Ойл групп" ХХК, “Нью энержи стар” ХХК, “Эн Пи петролиум “ХХК,“НИК” ХХК,“Гор газ” ХХК, “Ундарга-Увс” ХХК зэрэг 14 аж ахуйн нэгжтэй хариуцлагын гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна .Мэдээллийг тухай бүр нийтэд мэдээлж ажиллаж байна | 70% | |
| 65 | 25 | 33 | **2022 оны 2 дугээр сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл**<br>**2022-02-23**<br>**Дугаар 2022_12**<br>X.4.2.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх гэрээний багцын тендерийн ажлын явц, төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал, бүтээгдэхүүний үнийн тооцоолол, өөрчлөлт цар тахлын үеийн нөхцөл байдал тулгамдаж буй асуудал, төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай бараа, материал, машин механизм, тээвэрлэлтийн асуудлаар холбогдох гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөгжлийн банкны зээлийн хүүг бууруулах, үйлдвэрийн түүхий эдийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэргийг судлан үзэж, холбогдох тооцоо, судалгаа хийн Ерөнхий сайдын 2020 оны 8 дугаар 21-ний өдрийн 32 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг (Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан)- | УУХҮЯ, ГХЯ болон МГТБҮ-ийн зүгээс Энэтхэгийн төр засгийн байгууллага, Экспорт-Импортын банктай холбогдон төсөлд учирсан хүндрэлээс гарах арга замыг хамтран шийдвэрлэх санал, хүсэлтийг тавьж Энэтхэгийн засгийн газраас Экспорт-Импорт банк, Төслийн менежментийн зөвлөх “Инженерс Индиа Лимитед” компанийн удирдлагын түвшний багийг Монголд ирүүлж, 2022.03.30-04.03-ны өдрүүдэд уулзалт, хэлэлцээ хийсний үр дүнд Энэтхэгийн Засгийн газрын Зээлийн журамд өөрчлөлт оруулах замаар сонгон шалгаруулах ажиллагааг хөнгөвчлөх, илүү өрсөлдөөнийг бий болгох, Энэтхэгээс нийлүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувь хэмжээг 50 хувь болгож бууруулсан. Мөн EPC II, EPC III-ын хувьд шууд 1 үе шаттай “Түргэвчилсэн тендер” нээлттэй зохион байгуулахаар шийдвэрлэж тендерүүдийг зарлаад байна. Хөгжлийн банкны зээлийн асуудлаар 2022.06.10-ны өдрийн 02/1659, 2022.06.15-ны өдрийн 01/1689 дугаартай албан бичгээр тус тус саналыг Хөгжлийн банканд хүргүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | т танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (Д.Алтанцэцэг) нарт; | | | |
| | 37 | 46 | Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон нөөцийн талаарх бодлогын дундаж: 83.7 хувь | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| САЛБАР ЧИГЛЭЛ: 3. УУЛ УУРХАЙН БОДЛОГО | | | | | | |
| 3.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 66 | 1 | 1 | **Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26** 3.2.. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын 2017.05.24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг батлуулж, мөрдөж байна. Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 355 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангагдах хүртэл бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлтийг гаргахгүй байх чиглэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01/493 дугаартай албан бичгээр ирүүлсэн нь одоо хүртэл мөрдөгдөж байгаа тул 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс хойш Бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гаргаагүй байна.<br>2022 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Үнэт металлын Үндэсний форум дээр гарсан бичил уурхай эрхлэх боломжтой талбайн мэдээллийг Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бэлтгэх, энэхүү мэдээллээр холбогдох талуудыг хангах тухай 2 хүсэлтийг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал болгон форумаас гарах зөвлөмжид оруулсан. Үнэт металлын үндэсний холбоо форумаас гарсан зөвлөмжийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэх боломжийг судлахад шаардлагатай бичил уурхайн нөхцөл байдлын талаар Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд, Ашигт малтмал, газрын тосны газрын зохион байгуулсан хэлэлцүүлгийн “Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвтэй илтгэлд бичил уурхайн өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг бэлтгэн мэдээллээр хангаж ажилласан.<br>Бичил уурхайтай холбоотой мэдээллээр хангаж ажилласан. Үүнд: Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх болон Уул уурхайн салбарын 100 жилийн ойн хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 21-ээс 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд 20 аймгийг хамруулан Ашигт малтмал, газрын тосны газрын зохион байгуулсан хэлэлцүүлэгт тавигдсан “Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвтэй илтгэлд бичил уурхайн талаарх мэдээллийг бэлтгэж оруулсан.<br>2022 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулсан Үнэт металлын Үндэсний форумын Үнэт металлын салбарт төрийн байгууллагын гүйцэтгэж буй үүрэг, оролцоо хэлэлцүүлэгт Алтны олборлолт, бичил уурхайн талаар мэдээлэл хийлээ.<br>Манай орны бичил уурхайн туршлага судлахаар ирсэн Этиопи улсын 13 төлөөлөгчдөд 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Бичил уурхайн илтгэл тавьж хэлэлцүүлэв. | 100% | |
| 67 | 2 | 2 | **Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16** | ЗГ-ын 2015.03.30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ыг баталсан. Журмын хэрэгжилтийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн аймгийн Засаг | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн аймгийн Засаг дарга гэрээ байгуулж, хяналтыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ. | дарга, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хангаж байна. | | |
| 68 | 2 | 3 | 3 дугаар зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг Засгийн газар батална. Уг журам, гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100 хувь урьдчилан байршуулах нөхцөл, хяналт тавих төрийн байгууллагын албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус тусгасан байна. | Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам, гэрээний загварыг баталсан. Журамд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100 хувь урьдчилан байршуулах нөхцөл, хяналт тавих төрийн байгууллагын албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус тусгаж батлуулсан. Тус журмын дагуу гэрээ байгуулсан 42 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2021 оны гэрээний хэрэгжилтийг 2022 оны 01 дүгээр сарын 23ны өдөр 5 талт гэрээний ажлын хэсэг хуралдан дүгнэн, гэрээг сунгалаа. Ашигт малтмал хайх ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн заагт хамаарагдсан нийт 516 ашиглалтын тусгай зөвшөөрлийн судалгааг хийж, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор мэдээллийн санг тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд тус тус хөтлөн баяжуулсан | 100% | |
| 69 | 2 | 4 | 4.3.. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно. (4.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.) | ЗГ-ын 2011.06.08-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн заагийг хавсралтаар баталсан. Уг тогтоолд ЗГ-ын 2014 оны 260, 2015 оны 130 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон. Монгол Улсын ЗГ-ын 2012.06.05-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор МУ-ын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 1 дүгээр, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг 2 дугаар, Ойн сан бүхий газрын хилийн заагийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсан. ЗГ-ын 2014 оны 260, 2014 оны 281, 2015 оны 130, 302, 2016 оны 155 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. ЗГ-ын 2015.03.03-ны өдрийн 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-ыг, 2 дугаар хавсралтаар "Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээний загвар"-ыг тус тус баталсан. ЗГ-ын 2015.07.07-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор ЗГ-ын 2012 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "МУ-ын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 1 дүгээр, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Ойн сан бүхий газрын хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтаар баталсан. Мөн энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай" ЗГ-ын 174 дүгээр тогтоол, "Хилийн заагийг тогтоох" тухай 194 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосон. Засгийн газрын 2015.03.03-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сэргээлт хийлгэх журам"-д заасны дагуу Энгийн хамгаалалтын бүсэд гэрээ байгуулсан 38 аж ахуйн нэгжийн 40 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээний хугацааг АМГТГ-аас сунгаж ажилласан. | | |
| 70 | 3 | 5 | **Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай /Шинэчилсэн найруулга/ 2013-01-31 Дугаар 2013.03.04** 6.3.. Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын болон шинжээчийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Журмыг УУХҮСайдын 2021.08.04-ний өдрийн А/202 дугаар тушаалаар батлуулж, ХЗДХЯ-наас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021.10.14-ний өдрийн 5493 дугаарт бүртгүүлсэн. | 100% | |
| 71 | 3 | 6 | 17.3.. Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрэм, Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалт, пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.02.23-ны өдрийн А/33 дугаар тушаалаар баталсан. Ажлын хэсэг ажиллаж байна. | 70% | |
| 72 | 3 | 7 | 17.6.. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрэм, Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалт, пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.02.23-ны өдрийн А/33 дугаар тушаалаар баталсан. Ажлын хэсэг ажиллаж байна. | 70% | |
| 73 | 3 | 8 | 5.2.. Засгийн газар энэ хуулийн 5.1.5-д заасан жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно. (5.1.5.Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалтыг батлах;) | "Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд жагсаалтын дагуу үйл ажиллагаа явуулж, улирал бүр тайлангаа УУХҮЯ-нд ирүүлж байна. | 100% | |
| 74 | 3 | 9 | 15.6. Тэсэлгээчний эрхийг Монгол Улсын иргэнд олгох бөгөөд тэсэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас тэсэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг сайдын тушаалаар батлуулахаар төсөл боловсруулаад байна. | 70% | |
| 75 | 4 | 10 | **Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29** 8.1.4.. Дамжин өнгөрөх болон улс хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хүрээнд ачаа тээврийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг батлах; (8.1.Цар тахлаас | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020.04.30-ны өдрийн тушаалаар "Хилийн автозамын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам"-ыг баталсан. Энэхүү журмын 1.4.-д "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг Онцгой нөхцөл байдалд зохион байгуулах" тухай асуудлыг тусгуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | | | |
| 3.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 76 | 1 | 1 | **Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай**<br>**2021-12-30**<br>**Дугаар 2021 №103**<br>1.1/. Оюу толгой төслийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 34 хувь /Эрдэнэс Оюу Толгой ХХК/-д ногдох Оюу Толгой ХХК-иас Туркойс Хилл Ресурсес Лтд-д төлөгдөх 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хуримтлагдаад байгаа нийт 2.3 тэрбум ам.долларын өрийг 100 хувь тэглэх; (1.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагчтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчаас ирүүлсэн саналыг харгалзаж дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй:) | 1. Монгол Улсын Их Хурлын 2019.11.21-ний өдрийн “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” 92 дугаар тогтоолоор нийт 7 арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан бөгөөд тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Оюу Толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагчтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагч Рио Тинто группийн Ерөнхий захирал Якоб Стаусхолм болон Туркойз Хилл Ресурсес компанийн Гүйцэтгэх захирал Стив Тибоу нараас 2021.12.13-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж, дараах 5 санал бүхий албан бичгийг ирүүлсэн. Үүнд:<br>Оюу Толгой төслийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 34%-д ногдох нийт 2.3 тэрбум ам.долларын өрийг 100% тэглэх. Ингэснээр өмнө нь тооцоолж байсан 22 тэрбум ам.долларын өр үүсэхгүй, улмаар “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 34% эзэмшлийн үнэ цэн нэмэгдэж, ногдол ашиг авах хугацаа наашлах;<br>ДУББСТ болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г цуцаалж дуусгавар болгох;<br>Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн санхүүжилтэд хөндлөнгийн аудит оруулахыг зөвшөөрөх;<br>Гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас хүртэлх нэмэлт зардлыг хөрөнгө оруулагч тал 100% хариуцаж “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх;<br>“Оюу Толгой” ХХК-ийн засаглалыг сайжруулах байдлаар гүний уурхайн төслийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авч холбогдох зардлыг харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу “Оюу Толгой” ХХК төлөх; Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулах; төслийн байгаль орчин, нийгэм, засаглалыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах гэсэн.<br>Түүнчлэн, тус албан бичигт “Энэхүү шийдвэрүүдийг гаргахад амаргүй байсан бөгөөд энэ нь манай эцсийн санал гэдгийг дурдахын дашрамд хөрөнгө оруулагчдаас Монгол Улсад шилжүүлж буй томоохон үнэ цэн бөгөөд цаашдын хамтын ажиллагааны итгэлцлийн суурь болно гэдэгт бид итгэж байна. Ингэснээр Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоол хэрэгжсэн гэж бидний зүгээс үзэж байна” гэж дурдсан байдаг.<br>2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хурлын 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу Толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг шинэчлэн байгуулагдсан бөгөөд тус Ажлын хэсгийн дарга Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар 2021.12.22-ны өдөр “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангуулах тухай” тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцүүлэхээр УИХ-ын даргад өргөн барьсан. Улмаар Улсын Их Хурлын 2021.12.30-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангуулах тухай” тогттолын төслийг хэлэлцүүлж батлуулсан.<br>3. “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 34%-д ногдох зээлийг тэглэх бичгийн Англи хэл дээрх төсөл (Deed Poll, Confirmation of debt forbearance and Current outstanding balance (the “Confirmation”))-ийг хөрөнгө оруулагч тал (Rio Tinto)-аас 2022.01.13-ны өдөр ирүүлсэн. “Эрдэнэс Оюу толгой” ХХК-иас тус саналыг дэмжих боломжгүй талаар дэлгэрэнгүй тайлбар, танилцуулгыг бэлтгэж, 2022.01.14-ний өдөр Ажлын дэд хэсгийн Хуулийн дэд хэсэгт хүргүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Улмаар “Оюутолгой” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралдаан 2022.01.24-25-ны өдрүүдэд хуралдаж, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 34%-д ногдох зээлийг тэглэх бичиг болох Албан ёсны мэдэгдэл, түүний хавсралт Батламжийн талаар хэлэлцээгүй бөгөөд “Огтлох малталтыг эхлүүлэхийг дэмжих тухай” ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэн баталж, түүний хавсралтаар “Оюу Толгойн далд уурхайн төсөл огтлох малталтыг эхлүүлэх шалгуур нөхцөл, техникийн шалгуур нөхцөлтэй холбоотой нэмэлт мэдээлэл”-ийг Монгол, Англи хэл дээр хавсаргаж баталсан байна.<br>Улмаар 2022.01.25-ны өдрийн албан ёсны мэдэгдлийг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захиралд “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ц.Цэрэнхүү 2022.01.26-ны өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд тус албан ёсны мэдэгдлийн дагалдах баримт бичгээр “Өрийг хүчингүй болгосон тухай болон одоогийн үлдэгдэл төлбөрийн тухай батламж” (Батламж)-ийн загвар хавсаргасан байна. | | |
| 77 | 1 | 2 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК-ийн хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө" болон "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө"-г хуульд нийцүүлэн цуцалж, хүчингүй болгох | 1. “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн зүгээс 2009.10.06-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”, 2011.06.08-ны өдөр байгуулсан “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, 2015.05.18-ны өдөр байгуулсан “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-г тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт албан хүргүүлсэн.<br>2. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021.11.22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021.11.23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн.<br>3. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг 2021.10.18-нд УИХ дахь МАН бүлэгт, 2021.11.08-нд УИХ дахь АН бүлэгт тус тус танилцуулсан.<br>4. ДУББСТ, ДУББСНТ-г дуусгавар болгох, цуцлах тухай Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн төсөлд “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н зүгээс “ДУББСТ, ДУББСНТ-ийг хүчин төгөлдөр бус болохыг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ”-г байгуулах саналыг боловсруулж, 2022.01.14, 2022.01.16, 2022.01.28, 2022.03.16-ны өдрүүдэд тус тус “Ажлын хэсэг”-т хүргүүлсэн.<br>6. Уг асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг судалж, санал дүгнэлтээ гаргах, улмаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцэн тохиролцох ажиллагаа явагдаж байна. | 70% | |
| 78 | 1 | 3 | 1.3/. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх; | 1. Далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн зардал нэмэгдэж, ашиглалтад орох хугацаа хойшилсон тухай асуудлаар мэргэшсэн шинжээч сонгон, хөндлөнгийн дүгнэлт гаргуулж, тайлагнах үүрэг бүхий “Тусгай хороо”-г “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Монголын талын ТУЗ-ийн гишүүдийн санаачилгаар 2020.11.30-ны өдрийн 253 дугаар тогтоолоор байгуулсан.<br>2. Тусгай хорооны 2021.03.15-ны өдрийн 7 дугаар хурлаар Хөндлөнгийн шинжээчдийн багийг сонгон ажиллуулсан. Хөндлөнгийн шинжээчдийн багийн гол зорилго нь төслийн бүтээн байгуулалтын ажлын хуваарь, зардал хэтрэхэд нөлөөлсөн үндсэн шалтгаануудыг тодорхойлох байв. Түүнчлэн, Хөндлөнгийн шинжээчдийн багийн дүгнэлт тайланд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хоёр мэргэжилтэн Хянан магадлагаа (Peer review) хийсэн. 2021.07.31-ний өдөр Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн Тусгай Хороонд | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зориулж Хөндлөнгийн Шинжээчдийн багийн бэлтгэсэн “Эцсийн Тайлан” гарсан. Хөндлөнгийн шинжээчдийн баг нь Төслийн зардлын хэтрэлт нь зөвхөн геотехникийн асуудал, далд уурхайн бүтээн байгуулалт, уулын цулын малталтаас шалтгаалаагүй гэж дүгнэсэн. Тогтвортой олборлолт хийх хүртэл Төслийн хугацаа нь 22 сараар хойшилж, Капитал зардал дуусах үе шат хүртэл 34 сар нэмэгдсэн нь ИХНБУМ (EPCM)-ийн үйлчилгээ болон Эзэмшигчийн Төслийн Менежментийн багын зардлууд хэтрэх гол шалтгаан болсон. Гүний уурхайн дэд бүтцийн байгууламжууд болох материал дамжуулах систем, бутлуурын байгууламжууд нь мөн зардлын хэтрэлтэд ихээр нөлөөлсөн. Гадаргуун дэд бүтцийн байгууламжууд болох босоо ам, агуулах, төвийн дулааны станц, ажилчдын хувцас солих байр зэрэгт зардал нилээд өссөн .<br>Гадаад валютын орлогын тооцоолол нь цэвэр зардлын хэтрэлтийг бууруулахад нилээд нөлөөлсөн.” гэж дүгнээд санхүүгийн аудит хийлгэхийг зөвлөсөн.<br>3. Тогтоолын энэ заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хөндлөнгийн, хараат бус, мэргэшсэн, хүлээн зөвшөөрөгдсөн аудиторуудыг судлах, харилцаа тогтоох, санал болгох, сонгох зэрэг зохион байгуулалтын ажиллагааг эхлүүлж, тэдгээр аудиторуудтай хамтран ажиллах бэлтгэлийг ханган ажиллаж байна.<br>4. “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 274 дүгээр тогтоолд тусгагдсан Хөндлөнгийн аудит ажиллуулах асуудлыг Тусгай хорооны дүрэмд тусгаж, хэрэгжилтийг хангуулах ажиллагаа хийгдэж байна.<br>5. Тусгай хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр хөндлөнгийн, хараат бус хуулийн фирмийг авч ажиллуулж холбогдох зардлыг “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 274 дүгээр тогтоолд заасны дагуу “Оюу Толгой” ХХК хариуцана.<br>6. Одоогоор санхүүгийн аудит хийлгэх газрыг судалж байгаа бөгөөд Эрдэнэс Оюу толгой ХХК-н зүгээс санхүүгийн аудитын хамрах, хүрээ ажлын далгаварыг бэлтгэн тусгай хороонд хүргүүлээд байна. | | |
| 79 | 1 | 4 | 1.4/. Оюу толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, Эрдэнэс Оюу Толгой ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, Оюу Толгой ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх | 1. Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн УИХ-01/231 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичигт: ““Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Түр хорооны хуралдаанаар хэлэлцэх явцад тогтоолын 1.4 дэх дэд заалтын тухайн хэсгийг Улсын Их Хурлын гишүүд хэрхэн үзэж томьёолсон талаар Түр хорооны албан бичгийг хавсарган хүргүүлж байна.” гэж дурдаж, түүний хавсралтаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэний 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн УИХ-03/213 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичгийг Рио Тинто группийн Зэсийн группийн Гүйцэтгэх захиралд хүргүүлсэн байна.<br>Тус албан бичигт:<br>“Чуулганы хуралдааны явцад Оюу Толгой төслийн 2022-2023 оны эхний хагас хүртэлх хугацаанд шаардагдах нэмэлт санхүүжилт, зардлыг ОТ ХХК-д өрийн нэмэлт дарамт учруулахгүй байхаар, санхүүжилтийн хүүгүй эх үүсвэр ашиглах зарчим баримтлахыг УИХ-ын ихэнх гишүүд онцгойлон анхааруулж, санал хэлсэн бөгөөд өөрөөр хэлбэл, Оюу Толгой төсөлд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг өндөр хүүтэй хувь нийлүүлэгчдийн болон арилжааны, түүнчлэн төслийн санхүүжилтээс бусад санхүүжилтийн боломжит дараах хувилбарыг ашиглаж санхүүжүүлэх боломжтой гэж санал гаргасан УИХ-ын гишүүд үзсэн болно. Үүнд:<br>“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-д өрийн нэмэлт дарамт учруулахгүй байхаар тооцож хувьцааны санхүүжилтээр хийх;<br>Тухайн жилд санхүүжүүлэх үйл ажиллагааг санхүүгийн тухайн жилийн үйл ажиллагааны явцад үүсэх чөлөөт мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тооцох;<br>Шаардлагатай бол зарим санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилгаа төлбөр байдлаар урьдчилан авч, эргэн төлөлтийг бүтээгдэхүүнээр төлөх; | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компанийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс хүүгүй нөхцөлөөр” гэжээ.<br>Энэхүү албан бичигт 2022-2023 оны эхний хагас хүртэлх Оюу Толгой төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилт, зардлыг шийдвэрлэхдээ “ОТ ХХК-д өрийн нэмэлт дарамт учруулахгүй, санхүүжилтийн хүүгүй эх үүсвэр ашиглах” зарчмыг баримталж, санхүүжүүлэх боломжтой хувилбаруудын тухай УИХ-ын гишүүдийн гаргасан саналуудыг дурджээ. Үүнд:<br>Монголын талд нэмэлт өр үүсгэхгүй, хувьцааны санхүүжилт хийх;<br>Гадаадын хөрөнгө оруулагч тал өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хүүгүй санхүүжүүлэх;<br>Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн чөлөөт мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх;<br>Шаардлагатай бол зарим санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилгаа төлбөрийн байдлаар урьдчилан авч, эргэн төлөлтийг бүтээгдэхүүнээр төлөх гэсэн байна.<br>2. Уг асуудлыг 2022.06.15-16-ны өдрүүдэд хуралдахаар товлогдсон ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит 49 дүгээр хурлын хэлэлцэх асуудалд багтаасан боловч 2022.06.22-ны өдрийн байдлаар Оюу Толгой төслийн санхүүжилттэй холбогдуулан танилцуулсан “Урьдчилгаа төлбөрийн гэрээ”-ний нөхцөл нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.4 дэх заалтад: “Оюу толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, Эрдэнэс Оюу Толгой ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, Оюу Толгой ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх;” гэсэнтэй нийцүүлэх шаардлагыг тавьж, зарим нэмэлт мэдээлэл, санхүүгийн тооцоолол, харьцуулсан судалгаа, холбогдох хариу тайлбартай танилцах шаардлагын хүрээнд уг хурал түр завсарласан болно.<br>3. УИХ-н 103 дугаар тогтоолын 1.4 заалтын дагуу “Оюу Толгой” ХХК нь Хувь Нийлүүлэгчдийн зээлийг 2022 оны 1 дүгээр сараас, энгийн хувьцааг 2021 оны 3 дугаар сараас хойш нэмж гаргаагүй.<br>4. “Оюу Толгой” ХХК-иас ТУЗ-н 2022.03.15-ны хуралд ОТ ХХК-н 2022-2024 оны санхүүжилтийн төлөвлөгөөг танилцуулсан. Үүнд:<br>Төслийн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, үндсэн төлбөрийн төлөлтийг хойшлуулах,<br>Урьдчилгаа төлбөрийн санхүүжилт хийх,<br>Давуу эрхтэй төслийн зээл нэмж авах зэрэг санхүүжилтийн хувилбаруудыг танилцуулсан.<br>5. “Эрдэнэс Оюу толгой” ХХК-н зүгээс санхүүжилтийн хувилбаруудын нөхцөлүүдийг нарийвчлан судалж 103-р тогтоолтой нийцэхгүй байна гэсэн дүгнэлт гаргасан байна.<br>6. ТРК болон Рио Тинто-оос ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн гэрээтэй холбоотой санал, болон PWC-н дүгнэлт, ЭОТ ХХК-ийн санхүүгийн зөвлөхүүдээс гаргасан дүгнэлт зэрэгт дүн шинжилгээ хийж, нэгдсэн дүгнэлт гаргаж, урьдчилгаа төлбөрийн гэрээний нөхцөлийг УИХ-н 103-р тогтоолд нийцүүлэх талаар холбогдох саналыг боловсруулж холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээд байна. | | |
| 80 | 1 | 5 | 1.5/. Оюу Толгой ХХК-ийн засаглалыг сайжруулах, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулах, ус ашиглалт, байгаль орчин, нийгэм, засаглалыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах | 1. Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2020 оны 217 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон Оюутолгой ХХК нь хамтран ажиллаж ХөОГ-ний 7.3.3-т заасны дагуу Монгол Улсын Нэгдсэн сүлжээнээс Оюутолгой ХХК-ийг цахилгаан эрчим хүчээр хангах тухай гэрээний төслийг харилцан тохиролцсон.<br>2. 2022.01.27-ны өдөр Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Оюу Толгой уурхайг урт хугацаанд “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-г Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Диспетчерийн үндэсний төв ХХК, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК болон Оюутолгой ХХК-ийн хооронд байгуулсан.<br>3. Эрдэнэс Оюу толгой ХХК-ийн зүгээс ус ашиглалтыг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийгдэж байна. Үүнд: | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Оюу Толгой төслийн хүрээнд жилдээ 8-14 мянган хүн ажиллаж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хүн амын унд ахуйн хэрэглээний 3.0 сая.м3 усыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 заалтын дагуу усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөгдсөн бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын 326, 327 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах, ундны усанд төлбөр ногдуулах тухай асуудлаар Усны газартай хамтран ажиллаж байна.<br>Оюутолгой ХХК нь улсын хяналт шинжилгээний сүлжээнд өнөөгийн байдлаар нийт 12 мониторингийн цэг холбогдсон байгаа бөгөөд цаашид Гүний хоолойн ордын талбай дахь цооногуудаас сонгон авч улсын хяналт шинжилгээний сүлжээнд нэмэлт мониторингийн цэгүүд холбохоор төлөвлөн ажиллаж байна.<br>4. “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 274 дүгээр тогтоолын 6 дахь заалтын хэрэгжилтийг хангуулж “**ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ**”-ний төслийг боловсруулж, зөвшилцөж, харилцан тохиролцохоор Оюутолгой ХХК-д хүргүүлсэн. | | |
| 81 | 1 | 6 | 1.6/. татварын актуудын биелэлтийг хангуулах, цаашид нэг мөр ойлгож дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрүүлж, хэрэгжүүлэх | 1. 2013-2015 оны татварын маргаан:<br>2013-2015 оны татварын аудитын үр дүнд Монгол Улсын ТЕГ-аас Оюу Толгой ХХК-д 2018.01.10-ны өдөр шийтгэлийн хуудас ногдуулж, нийт 377 тэрбум төгрөгийн татвар, торгууль төлөх, ирээдүйд шилжүүлэн тооцох татварын алдагдлыг (ИШТТА) 612 тэрбум төгрөгөөр бууруулах шаардлага тавьсан. Үүнээс Оюу Толгой ХХК 11 тэрбум төгрөгийн татвар, торгууль төлөх шаардлага, мөн ирээдүйд шилжүүлэн тооцох татварын алдагдлыг 579 тэрбум төгрөгөөр бууруулахыг хүлээн зөвшөөрсөн. Шийтгэлийн хуудсаар ногдуулсан татвар, торгуулийн мөнгөн дүнгийн үлдсэн хэсэг болох 366 тэрбум төгрөг буюу 128 орчим сая ам.доллар, мөн ИШТТА-аас бууруулахаар шаардсан үлдсэн 33 тэрбум төгрөгийг Оюу Толгой ХХК-иас хүлээн зөвшөөрөөгүй.<br>Засгийн газар, Оюу Толгой ХХК-иас (РТ, Туркойз Хилл Ресурс) уг татварын маргааныг олон улсын арбитраар шийдвэрлүүлэх шийдвэрт хүрсэн. Арбитрын мэдэгдлийг 2020.02.20-ны өдөр гаргасан. 2022.02.11-ний өдөр Татварын арбитрын явцыг 2022.08.12-ны өдөр хүртэл хойшлуулж, энэ хугацаанд тохиролцоонд хүрэхээр зорьж байгаа ч албан ёсны хэлэлцээр хараахан эхлээгүй байна.<br>ТЕГ-ын нэхэмжлэхийн дагуу Оюу Толгой ХХК 366 тэрбум төгрөг буюу 128 орчим сая ам.долларыг улсын төсвийн дансанд 2021 оны 3 дугаар сард шилжүүлсэн. Маргаан Оюу Толгой ХХК-д эергээр шийдвэрлэгдсэн тохиолдолд энэхүү мөнгөн дүнг буцаан авах эрхтэй. Оюу Толгой ХХК арбитрт хандсан маргаантай асуудлууд (нийт 358 тэрбум төгрөг)-ыг Захиргааны хэргийн шүүхээс 2021.05.19-ны өдөр татан авсан. Мөн өдөр Захиргааны хэргийн шүүх үлдэж буй 2 асуудал (1.8 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн татвар болон 33 тэрбум төгрөгийн ИШТТА)-ыг татварын албаны талд шийдвэрлэсэн. Энэхүү шүүхийн шийдвэрээр Оюу Толгой ХХК-д 5.8 тэрбум төгрөгийн хүү, торгуульд өршөөл үзүүлсэн. “Оюу Толгой” ХХК дээрх шүүхийн шийдвэрийн тодорхой хэсгээр 2021 оны 7 дугаар сард Дээд шүүхэд давж заалдсан. 2021 оны 11 дүгээр сард Дээд шүүхээс өмнөх шүүхийн шийдвэрийг өөрчлөхгүй хэвээр үлдээх шийдвэр гаргасан. Оюу Толгой ХХК-иас Дээд шүүхийн шийдвэрийн дагуу 5.8 тэрбум төгрөгийг буцаан олгох хүсэлтийг ТЕГ-д гаргасан бөгөөд өнөөг хүртэл хариу нь гараагүй байна.<br>2. 2016-2018 оны татварын маргаан:<br>Татварын ерөнхий газраас Оюу Толгой ХХК-ийн 2016-2018 оны татварын аудитыг 2020 оны 12 дугаар сард дуусгаж 649 тэрбум төгрөг буюу 228 сая ам.долларын нөхөн ногдуулалтын акт тавьсан. Үүнээс гадна Татварын ерөнхий газар нөхөн ногдуулалтын актаар Оюу Толгой ХХК-ийн ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлын дүнг 3.4 их наяд төгрөгөөр бууруулан шийдвэрлэсэн. Үүний нэлээд хэсэг нь хувь нийлүүлэгчийн зээлд төлсөн хүүгийн төлбөр болон менежментийн үйлчилгээний төлбөрийн татварын хасагдах зардлын бууралт юм. Татварын хасагдах зардлыг бууруулахдаа үнэ | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шилжилтийн дүрэм журмын дагуу тухайн дүнг “сунгасан гарын зарчмаар” тооцоолоогүй гэж үзсэн.<br>Үүний дийлэнх хувь нь өмнөх татварын хяналт шалгалтаар дэвшүүлсэнтэй ижил асуудлууд бөгөөд олон улсын арбитрын маргаан дээр хянагдаж байгаа асуудлууд болно. Өнөөг хүртэлх хугацаанд дараах арга хэмжээ хэрэгжээд байна. Үүнд:<br>Оюу Толгой ХХК 2021.04.02-ны өдөр Нэмэлт өөрчлөлт оруулсан нэхэмжлэлийг олон улсын арбитрт хүргүүлсэн.<br>МУЗГ 2021.04.30-ны өдөр Хариу тайлбар болон Сөрөг нэхэмжлэл гаргасан.<br>РТ, ТХР- ийг маргаанд оролцуулах МУЗГ-ын хүсэлтийг хүргүүлсэн ба арбитрын шүүх хурал 2023 оны 2 дугаар сар хүртэл хойшлогдсон.<br>ТЕГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөл Оюу Толгой ХХК-ийн гомдлыг 2021.04.05-ны өдөр хэлэлцээд Нөхөн ногдуулалтын актыг хэвээр үлдээсэн. Оюу Толгой ХХК Захиргааны хэргийн шүүхэд 2021 оны 6 дугаар сард нэхэмжлэл гаргасан ба Захиргааны хэргийн шүүх 2021 оны 10 дугаар сард арбитрын шийдвэр гарах хүртэл хэргийг түдгэлзүүлсэн. ТЕГ-ын нэхэмжлэхийн дагуу Оюу Толгой ХХК 649 тэрбум төгрөг буюу 228 орчим сая ам.долларыг улсын төсвийн дансанд 2021 оны 2, 3 сард шилжүүлсэн. Маргаан Оюу Толгой ХХК-ийн хувьд эргээр шийдвэрлэгдсэн тохиолдолд энэхүү мөнгөн дүнг буцаахаар байна. | | |
| 82 | 1 | 7 | 2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссанаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолыг хэрэгжсэн гэж үзсүгэй. | УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын 1 дэх заалт бүрэн хэрэгжиж, тогтоолд заасан үр дүнг нэгтгэн үнэлсний дараа уг заалтын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх боломж бүрдэнэ. | /-/ | |
| 83 | 2 | 8 | **Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**<br>**2022-01-18**<br>**Дугаар 2022 №08**<br>1.1/. Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй: 1/Ашигт малтмалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/; 40/Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төсөл; | Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг тус тус боловсруулах ажлын хэсгийг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгааг хийн, хуулийн төслийг боловсруулж байна. Хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Хуулийн төслийн боловсруулалтын явцаас танилцуулбал: 1/ Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулах зорилгын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийгээд байна. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, тайланг хийгээд байна. Үүнд: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөө, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг болно.<br>МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуульд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | | |
| 84 | 3 | 9 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>**2016-11-17**<br>**Дугаар 2016 №69**<br>2/1.. Коксжих нүүрсний экспортын үнийг дэлхийн зах зээлийн үнийн түвшинтэй нийцүүлэх, нэгдсэн нэг үнээр экспортод гаргах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (2/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:) | Дэлхийн зах зээлийн нүүрсний үнэ болон Монгол Улсаас экспортод гарч буй нүүрсний үнийг Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 342, 465 дугаар тогтоолын дагуу уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн дунджийг тогтоох зарчмаар тооцон олон нийтэд мэдээлж байна. | 100% | |
| 85 | 4 | 10 | **Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2018-06-29**<br>**Дугаар 2018 №73**<br>1.1/. Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх; | Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус яамнаас “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” саналыг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 296 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компани "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК-ийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 28 дугаар тогтоолын дагуу байгуулж, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийцүүлэн олон улсын болон дотоодын зах зээлд үе шаттайгаар үнэт цаас гаргах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, үйлчилгээ авах гэрээг байгуулан ажиллаж байсан. Гэвч УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас баталсан 2019 оны 296 дугаар тогтоолыг 2020 оны 146 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул гадаадын хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.<br>Эрдэнэс-Тавантолгой” ХК-иас нэрлэсэн үнээр худалдахаар санал болгосон хувьцаанаас үндэсний 488 аж ахуйн нэгжүүд нь нийт хувьцааны 0.05% буюу 7,065,038 ширхэг хувьцааг эзэмшиж байна. | /-/ | |
| 86 | 4 | 11 | 1.2/. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Оюутолгой-Ханги, Тавантолгой-Баруннаран чиглэлийн авто замын төгсгөлөөс Цагаандэл уул чиглэлийн тусгай зориулалтын авто зам болон Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам зэрэг төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн 435 км, Тавантолгой-Баруннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км авто замын төслүүдийг концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр тусгасан.<br>ЗГ-ын дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх концесс эзэмшигч нарыг сонгон шалгаруулж холбогдох гэрээг байгуулсан байна.Үүнд:<br>1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын авто замын концессын гэрээг Засгийн газрын 2018 оны “Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 229 дүгээр тогтоолын дагуу “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК, (“Чайна тиэсижү сивил инженеринг групп” ХК болон “Дардан говь” ХХК-ийн түншлэлийн байгуулсан компани);<br>2. Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн 435 км авто замын концессын гэрээг Засгийн газрын 2019 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 238 дугаар тогтоолын дагуу “Тахилт хайрхан транс” ХХК; | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 3. Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км авто замын концессын гэрээг Засгийн газрын 2018 оны “Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 330 дугаар тогтоолын дагуу “Ундрах говь” ХХК тус тус эзэмшиж байгаа байна. Харин Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх “Тавантолгой төмөр зам” ХХК-ийг Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын дагуу байгуулсан бол Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх "Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолоор тус тус байгуулсан бөгөөд "Эрдэнэс Тавантолгой" ХК төмөр замын компаниудын 66 хувийг эзэмшиж шаардагдах хөрөнгө оруулалтыг оруулж, , төслүүдийг хэрэгжүүлж байна. | | |
| 87 | 4 | 12 | 1.4/. Өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станц болон нүүрс химийн үйлдвэрийг Тавантолгойн ордыг түшиглэн барих талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Улсын Их Хурлын 2020.08.28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.5.1.4-д “Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ” гэж, 3.2.1.6-д "Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна" гэж тус тус тусгагдсан.<br>Мөн Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийг төрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилгоор "Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийг байгуулсан бөгөөд уг компанийн 30 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д эзэмшүүлэх замаар хөрөнгө оруулах шийдвэр гаргасан.<br>Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “Чайна металлуржикал инженеринг компани” /CMEC/ боловсруулж 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.<br>Улмаар “Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт “Norinco International Cooperation” Ltd шалгарч 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр EPC гэрээг байгуулсан. | 100% | |
| 88 | 5 | 13 | **Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай 2019-11-21 Дугаар 2019 №92**<br>1.1/. 1.Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, Эрдэнэс Монгол ХХК болон Айвенхоу Оюу Толгой (Ви Ви Ай) Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Оюу Толгой ХХК хооронд 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-ний хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2008 оны “Үндсэн зарчим, удирдамж батлах тухай” 40 дүгээр тогтоол, 2009 оны “Оюу толгой ордыг ашиглах | 1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.12.18-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 174 дүгээр захирамжаар “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019.11.21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчилсэн.<br>2. Монгол Улсын Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 74 дүгээр тогтоолын 1 дэх заалтаар “Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах “Ажлын ерөнхий төлөвлөгөө” батлагдсан.<br>Улмаар дээрх Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020.03.31-ний өдрийн “Ажлын дэд хэсэг байгуулах тухай” 23 дугаар тушаалаар “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019.11.21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.12.18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий Ажлын дэд хэсэг”-ийг Санхүүгийн асуудал хариуцсан, Хуулийн асуудал хариуцсан, Техникийн хамтарсан хэсэгтэйгээр байгуулж, тэдгээрийн ажиллах чиглэлийг заажээ. Уг ажлын дэд хэсгийг ХЗДХСайдын 2021.02.24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан Ажлын хэсгийн хуралдаан 2021.02.18-ны өдөр цахимаар, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгө оруулалтын гэрээний тухай” 57 дугаар тогтоол болон Монгол Улсын хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах; | 2021.02.20-ны өдөр ХЗДХЯ-ны хурлын танхимд, 2021.02.23-ны өдөр Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит танхим”-д, 2021.03.05-06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханбогд сум Оюутолгой ХХК-ийн уурхайд тус болсон.<br>4. “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн зүгээс 2009.10.06-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”, 2011.06.08-ны өдөр байгуулсан “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, 2015.05.18-ны өдөр байгуулсан “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-г тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт албан хүргүүлсэн.<br>5. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021.11.22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021.11.23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн.<br>6.ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг 2021.10.18-нд УИХ дахь МАН бүлэгт, 2021.11.08-нд УИХ дахь АН бүлэгт тус тус танилцуулсан.<br>7. УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолын 1.1-д “... шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах ...” гэсний дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-ээс сонгогдсон 3 хуулийн этгээд, 2 зөвлөх тогтоолын хэрэгжилтийг хангуулахад гэрээний үндсэн дээр /нууцлалын/ мэргэшлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлэн ажилласан. | | |
| 89 | 5 | 14 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г Монгол Улсын эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах; | 1. “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд гарын үсэг зурах эрх олгосон Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 27, 94, 99, 123 дугаартай захирамжуудыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.11.18-ны өдрийн 128/ШШ2019/0808 дугаар шийдвэрээр илт хууль бус болохыг тус шүүхийн шийдвэрээр тогтоож хүчин төгөлдөр болсон. Уг шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай нэр бүхий иргэдийн хүсэлтийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021.08.27-ны өдрийн 128/ШТ2021/0090 дугаартай тогтоолоор хангахаас татгалзаж, уг тогтоолыг давж заалдах гомдол гаргах эрхгүй байх заалтыг тусгаж шийдвэрлэсэн.<br>2. 2015.05.18-ны өдөр байгуулагдсан “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний 35 заалтыг тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт хүргүүлсэн.<br>3. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021.11.22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021.11.23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг 2021.10.18-ны өдөр УИХ дахь МАН бүлэгт, 2021.11.08-ны өдөр УИХ дахь АН бүлэгт тус тус танилцууллаа.<br>5. ДУББСТ, ДУББСНТ-г дуусгавар болгох, цуцлах тухай Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн төсөлд “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н зүгээс “ДУББСТ, ДУББСНТ-ийг хүчин төгөлдөр бус болохыг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ”-г байгуулах саналыг боловсруулж, 2022.01.14, 2022.01.16, 2022.01.28, 2022.03.16-ны өдрүүдэд тус тус “Ажлын хэсэг”-т хүргүүлсэн.<br>6. Уг асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг судалж, санал дүгнэлтээ гаргах, улмаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцэн тохиролцох ажиллагаа явагдаж байна. | | |
| 90 | 5 | 15 | 1.3/. Оюу толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоололд зааснаар нэрлэсэн үнээр 53 хувиас бууруулахгүй байх хүрээнд Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хувилбаруудыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах; | 1. “Оюу Толгой” ХХК-с ирүүлсэн санхүүгийн загварт нарийвчилсан шинжилгээ хийж, Гол параметерүүдийн Монгол Улсын ЗГ-ын төслөөс хүртэх мөнгөн урсгалд нөлөөлөх мэдрэмжийн шинжилгээг хийж, нөлөөллөөр нь эрэмбэлсэн.<br>2. Дээрх судалгаанд үндэслэж Монгол Улсад ногдох мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх боломжит хувилбаруудыг боловсруулж, үр дүнг тооцоолж, танилцуулга материал бэлтгэж холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан.<br>3. Хөрөнгө оруулагчдын хоорондох хэлэлцээрт шаардлагатай мэдээллийг бэлтгэж, МУЗГ-ын 34 хувийн эзэмшилд ногдох зээлийн үлдэгдэлийг тэглэхтэй холбоотой санхүүгийн тооцоолол, мэдээллийг бэлтгэж эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>4. 2022.01.25-ны өдөр МУЗГ-т ногдох 34%-ийн хувьцааны зээлийн өр болох 2,363 сая ам.долларын өр тэглэгдсэнээр МУЗГ төслөөс бодит мөнгөн ногдол ашиг хүртэх нөхцөл бүрдсэн бөгөөд  ирээдүйд төслөөс хүртэх өгөөжийн хувь 53%-д хүрэх төсөөлөлтэй байна. | 100% | |
| 91 | 5 | 16 | 1.4/. Оюу толгой ордын зэс, алт, мөнгө болон бусад дагалдах элементийн нөөцийн үнэлгээг Монгол Улсад мөрдөгдөж байгаа олон улсын стандартын дагуу дахин хийж, үүнд үндэслэсэн техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах; | Оюу Толгойн бүлэг ордын нөөцийг 2015-2018 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан дахин тодотгон, тооцоолж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанд 2021 онд танилцуулж бүртгүүлсэн. Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөс орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг тогтоогдсон нөөцийг иж бүрэн ашиглах хүрээнд боловсруулж, танилцуулах даалгаварыг Оюутолгой ХХК-д өгсөн.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайдын 2021.11.24-ний өдрийн А/284 дугаар тушаалаар “Оюутолгой болон Засгийн газар хоорондын мэдээллийн тэнцвэртэй байдал, ойлголтын зөрүүг арилгах зорилго бүхий ажлын хэсэг”-ийг байгуулж, Ажлын хэсгийг газар дээр нь ажиллуулсан. Уг ажлын хэсэгт Оюутолгой ХХК-ийн зүгээс Хойд Хюго ордын 1 дүгээр давхрын хэмжээнд хийгдэж буй судалгааны ажлын үр дүнд үндэслэн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, 2023 оны 4- дүгээр улиралд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх төлөвлөгөөг танилцуулсан байна. | 70% | |
| 92 | 5 | 17 | 1.5/. Байгаль орчны болон усны нөхцөл байдлын үнэлгээг шинэчлэн хийлгэж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 175 дугаар“Газрыг улсын хэрэгцээнд авах тухай” тогтоолыг өөрчилж, говийн бүсийн гүний ус ашиглах нөхцөлийг харгалзан тогтоох; | “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-иас Оюутолгой ХХК-д гүний хоолойн газрын доорх ус ашиглалтын үеийн нөөцийг дахин үнэлүүлэх талаар санал хүргүүлж, 2022 оны үйл ажиллагааны төсөвт хайгуулын ажил хийх зардлыг тусгуулсан.<br>2022.06.20-ны өдрийн байдлаар гүний хоолойн газрын доорх усны ордын ашиглалтын үеийн нөөцийг дахин үнэлэх ажлыг гүйцэтгэх гэрээт компани сонгон шалгаруулах ажил явагдаж байгаа бөгөөд сонгон шалгаруулалтыг ирэх 7 дугаар сард багтаан дуусгах төлөвлөгөөтэй байна.<br>“Эрдэнэс Оюу Толгой” ХХК дээр дурдсан ажлыг гүйцэтгэх ажлын даалгаварт “Усны газар”-тай хамтран санал хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Оюу Толгойн ордоос зэс-алт олборлох төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний нэмэлт тодотголыг 2016 онд гүйцэтгэсэн. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Оюутолгой ХХК-иас орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд нэмэлт, тодотгол хийсний дараа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний нэмэлт тодотголыг боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэхээр төлөвлөж байна. | | |
| 93 | 5 | 18 | 1.6/. Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах; | Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн зүгээс 2009.10.06-ны өдөр байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ", 2011.06.08-ны өдөр байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ", 2015.05.18-ны өдөр байгуулсан "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-г тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт албан хүргүүлсэн байна.<br>Оюутолгой ХХК-тай байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний 3.7-д "Оюу толгой төслийн ил, далд уурхайгаас дараагийн 5 /таван/ жилд олборлож боловсруулахаар тооцсон Бүтээгдэхүүний тоо хэмжээг заасан хүснэгтийг Хөрөнгө оруулагч жил бүр шинэчилж, Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх..." гэж заасны дагуу уг хүснэгтийн загварыг боловсруулж, 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 2/2057 дугаартай албан бичгээр Оюутолгой ХХК-д хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам"-ын 2.1.1-д заасныг тус тус үндэслэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж Оюутолгой ХХК-ийн Далд уурхайн бүтээн байгуулалттай газар дээр нь танилцаж, ашиглалтад хүлээн авах эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргахаар 2022 оны 05 дугаар сарын 24-нөөс 25-ны хооронд ажиллаж, далд уурхайг Панел-0-ийн хүрээнд хүлээн авсан. | 100% | |
| 94 | 5 | 19 | 1.7/. Оюу толгой төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэх. | "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн үндсэн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Их Хурлын "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 2019 оны 92 дугаар тогтоолын 1.7-д заасны дагуу "Оюу Толгой" ХХК-д менежментийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 274 дүгээр тогтоолоор "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн дээрх чиглэлийн үйл ажиллагааны 4 жилийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна. | 70% | |
| 95 | 6 | 20 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай**<br>**2020-08-28**<br>**Дугаар 2020 №24**<br>2.4/. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан экспортыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгон иргэдийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт нөлөө үзүүлэх 10 томоохон төслийг санхүүгийн боломжит бүх арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэх. | "Эрдэнэс-Тавантолгой" ХК нь Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой түлш, Тавантолгой дулааны цахилгаан станц, Тавантолгойн нүүрс ачих байгууламж зэрэг үндэсний хэмжээний томоохон төслүүдэд нийтдээ 3,340,753 сая төгрөг санхүүжилтийг хийсэн байна. | 100% | |
| 3.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 96 | 1 | 1 | **Чиглэл өгөх тухай**<br>**2015-05-29**<br>**Дугаар 2015 №09 АБГББХ**<br>3. Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хувь нийлүүлэгчдийн | Оюутолгой ХХК нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа хүдрийн далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, баяжуулах боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм, тэсэлгээний ажлын | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хооронд нягтлан бодох бүртгэлийн стандартын зөрүү, уул уурхайн салбарт хуримтлуулсан туршлагын ялгаа зэргээс хамааран үл ойлголцол, хууль тогтоомжийн зөрүү зэргийг арилгах, олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт, дүрэм журмыг нэг мөр болгож цэгцлэх, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах | аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм зэргийг мөрдөж ажиллаж байна. | | |
| 97 | 2 | 2 | **Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай**<br>**2019-04-09**<br>**Дугаар 2019 №04 ЭЗБХ**<br>2.4/. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтын 7 дахь дэд заалтад заасан эх үүсвэрийг хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлж, уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих чиглэлээр хувьцааны болон зээлийн хөрөнгө оруулалтыг хийх. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020 оны А/102, А-177, 2021 оны А/52, А-82 дугаар хамтарсан тушаалд 2022.04.05-ны өдрийн А/62, А-97 дугаар хамтарсан тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хөнгөлөлттэй санхүүжилт олгох журмын 6.1-д заасны дагуу уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийг хангасан алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгох үйл ажиллагаа явагдаж байна.<br>Дээрх үйл ажилагааны хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Монголбанкинд нийт 51 аж ахуйн нэгжийн жагсаалтыг хүргүүлсэн бөгөөд эхний ээлжид БМНС ХХК, “Хаан булаг интернэйшнл” ХХК, Илт гоулд ХХК-иудад 20 тэрбум төгрөгийн урьдчилгаа болон урт хугацааны санхүүжилтийг олгоод байна | 100% | |
| 98 | 3 | 3 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2021-12-28**<br>**Дугаар 2021 №6 ҮБХ.**<br>I.1. Нүүрсний экспортыг нэгдүүлэхтэй холбоотой хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх төслүүд /чингэлэгт тээврийн терминал, жолоочгүй тээврийн хэрэгсэл, дүүжин тээвэр, конвейнерийн систем/ | Засгийн газрын 2021 оны 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулсан. Тухайлбал, Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан. Харин Шивээхүрэн боомтод 11.6 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Монголын алт (МАК)” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Жавхлант орд” ХХК, “Цагаан өвөлжөө” ХХК “Сан транс” ХХК-иуд гүйцэтгэж 2022.06.16-ны өдөр Шивээхүрэн терминал ХХК-ийг байгуулсан. Түүнчлэн Сангийн яамны дэргэдэх Хөгжлийн хөтөч төслийн нэгжээс хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, үүний дагуу Замын-Үүд, Гашуунсухайт боомтуудад өргөтгөл шинэчлэлтийн ажлуудыг 2021 онд эхлүүлсэн. Улсын Их Хурлын 2021.12.30-ны өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 1 дүгээр зүйлд “Боомтын сэргэлт” гэсэн арга хэмжээ тусгагдсан. | 100% | |
| 99 | 3 | 4 | I.2. Экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төмөр замын төслүүд /Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Богдхан төмөр зам, нүүрс ачилтын байгууламж, холболтын болон хилийн төмөр зам/ | “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 66 хувийг тус тус эзэмшиж байна. Мөн тус компани Тавантолгойн нүүрс ачилтын байгууламж, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслүүдийн холболтын төмөр зам, хилийн холболтын төмөр замын төслүүдийг хариуцан ажиллаж байна. Эрдэнэс Тавантолгой ХК 2022 оны эхний хагас жилийн байдлаар Тавантолгойн нүүрс ачилтын байгууламж – 81.0 тэрбум төгрөг,Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслүүдий холболтын төмөр зам – 118.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.<br>Харин хилийн холболтын төмөр замын асуудлаар Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу БНХАУ-ын Чайна Энержи компанитай 2022 оны 03 дугаар сард хэлэлцээр хийж эхэлсэн. Хэлэлцээний хүрээнд төмөр зам ашиглалтад орохоос өмнө жилд 5 сая тонн, ашиглалтад орсны дараа жилд 20 сая тонн нүүрс нийлүүлэх гэрээ байгуулах талаар урьдчилсан байдлаар тохиролцож, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ашиглалтад орохын өмнөх 2 жилд хамаарах 10 сая тонн нүүрс худалдах, худалдан авах гэрээний төслийг Чайна Энержи компанид хүргүүлээд байна. | | |
| 100 | 3 | 5 | I.3. Үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулах төслүүд /Тавантолгойн цахилгаан станц, нүүрс баяжуулах, кокс-химийн, төрөл бүрийн сайжруулсан түлшний үйлдвэр, метан хийн болон дамжуулах хоолойн төслүүд, тэдгээртэй холбоотой бусад барилга байгууламж/ | Улсын Их Хурлын 2020.08.28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.5.1.4-д “Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ” гэж, 3.2.1.6-д "Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна" гэж тус тус тусгагдсан.<br>Мөн Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийг төрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилгоор "Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийг байгуулсан бөгөөд уг компанийн 30 хувийг “Эрдэнэс Таванголгой” ХК-д эзэмшүүлэх замаар хөрөнгө оруулах шийдвэр гаргасан.<br>Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “Чайна металлуржикал инженеринг компани” /CMEC/ боловсруулж 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.<br>Улмаар “Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт “Norinco International Cooperation” Ltd шалгарч 2022 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр EPC гэрээг байгуулсан.<br>“Тавантолгой түлш” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2021.10.13-ны өдрийн 316 дугаар тогтоолоор тус компанийн нийт хувьцааны 51 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д эзэмшүүлэх шийдвэр гарсан.<br>“Тавантолгой Түлш” ХХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2022 онд нийт 81,896 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.<br>ЗГ-ын 2022.03.02-ны өдрийн 94 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд “Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос дамжуулах хоолойн байгууламж барихад шаардагдах 397 сая ам долларыг бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Батбаатар/-д тус тус даалгасугай” гэж тусгагдсан.<br>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд "Норинко интернэшнл күүпэрэйшн" лимитед компанитай 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 253 тоот Нүүрс худалдах, худалдан авах гэрээг байгуулсан. | 100% | |
| 101 | 3 | 6 | I.6. Ил уурхайн ашиглалтын өртөг, зардлыг бууруулж, олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлд далд уурхайн ашиглалтын технологийг нэвтрүүлэх боломжийг судлах | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. | 100% | |
| 102 | 3 | 7 | 2. Эрдэнэс-Тавантолгой хувьцаат компанийн бие даан болон бусад этгээдтэй хамтран хөрөнгө оруулж, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг энэ тогтоолын 1 дэх заалтад тусгагдсанаар хязгаарлаж, тэдгээрийг тус компанийн борлуулалтын орлого болон гадаад дотоод зах зээлд үнэт цаас гаргах, зээл авах, нүүрс урьдчилан | “Эрдэнэс-Таван толгой” ХК нь Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой түлш, Тавантолгой дулааны цахилгаан станц, Тавантолгойн нүүрс ачих байгууламж зэрэг үндэсний хэмжээний томоохон төслүүдэд санхүүжилтэд нийтдээ 3,340,753 сая төгрөг зарцуулсан байна. Эдгээр төслүүдийн санхүүжилтийн асуудлыг дотоод зах зээлд үнэт цаас гаргах, нүүрс урьдчилан борлуулах замаар шийдвэрлэж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | борлуулах зэрэг эдийн засгийн үр ашигтай нөхцөлөөр санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай. | Тухайлбал, “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь 2021 онд стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой 2 их наяд хүртэлх төгрөгийн болон ам.долларын бонд гаргах хүсэлтийг Монголын хөрөнгийн биржид хүргүүлж Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо хянаж, холбогдох зөвшөөрлийг олгосны үндсэн дээр 2 удаагийн арилжааг хийж нийт 856.0 тэрбум төгрөг, 172.8 сая ам.долларын хөрөнгийг татан төвлөрүүлсэн. | | |
| 103 | 3 | 8 | 3. Төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувь оролцоо, эзэмшил, борлуулалтын асуудлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахдаа менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай. | - ЗГ-ын 2021.12.08-ны өдрийн 367 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр "Эрдэнэс Монгол" ХХК-ийг Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр "Эрдэнэс Монгол" ХХК-ийг тогтоосугай” гэж заасан. Засгийн газрын тогтоолын дагуу "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах ажлыг "Эрдэнэс Монгол" ХХК хариуцан ажиллаж байна. | 100% | |
| 104 | 4 | 9 | **2019 №04/01. Засгийн газарт чиглэл өгөх тухай БОХХААБХ/ӨБХ/ / 2019-05-28 / УИХ-ын байнгын хорооны тогтоол**<br>1.1/. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухахй хуулийн биелэлтийг нийслэл болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт хангасан талаар танилцуулах; | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5-д зааснаар хайрга, дайрганы түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох эрх нь орон нутгийн удирдлага Засаг даргад хадгалагддаг. Орон нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход Ашигт малтмал, газрын тосны газраас дүгнэлт гаргадаг бөгөөд Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар давхцал байгаа тохиолдолд олгох боломжтой дүгнэлтийг гаргахгүй, хориотой юм. Харин урт нэртэй хууль гарахаас өмнө Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Төв аймгийн Алтанбулаг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт олгогдсон байдаг бөгөөд уг газруудыг Засаг дарга цуцлаад шийдвэр болон холбогдох мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлсэн тохиолдолд УУККС бүртгэх боломжтой. | 70% | |
| 3.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 3.д. УАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 105 | 1 | 1 | **Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай**<br>**2019-12-31**<br>**Дугаар 2019_60/40**<br>2.8. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах | Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;” тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019.05.02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан. Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12.01-ний өдрийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019.08.23-ны өдрөөс 12.1-ний өдрийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн. Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт “Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ" гэж заасны дагуу уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд нийт 17 тэрбум төгрөгийг байршуулсан байна.<br>2020 онд "Эм жи эйч" ХХК-ийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт эзэмшиж байгаад цуцлагдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон 40.65 га талбайгаас 10 га талбайд хийх техникийн нөхөн сэргээлтийг тус компанийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөөр гүйцэтгэсэн байна. | | |
| 3.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 106 | 1 | 1 | **Тогтоол хүчингүй болгох тухай**<br>**2017-03-20**<br>**Дугаар 2017_96**<br>4. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслэн Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн боомтын төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулах нийт хөрөнгө оруулалтад нь багтаан тооцуулах талаар хөрөнгө оруулахыг сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай. | "Гашуун Сухайтын Төмөр Зам" ХХК-д оруулсан хувь хөрөнгийн хэмжээг татан авах ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, холбогдох дүгнэлтийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан. ТУЗ-өөс хувь хөрөнгөө татан авах ажлыг гүйцэтгэхийг даалгасан тогтоолыг 2017.05.25-нд гаргасан. Үүний дагуу "Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт" аудитын шалгалт хийлгэх зардлыг шийдвэрлэх хүсэлтийг хүргүүлсэн. Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг барьж байгуулах, ашиглалтад оруулах хөрөнгө оруулагчийг татах чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэл болон Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд төмөр замын суурь бүтцийг өмчлөх эрх нь зөвхөн төрд хамаарах тул хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлээс бус төрийн өмчит компанийн санхүүжилтээр шийдвэрлэх шаардлага бий болсон. Энэ хүрээнд Тавантолгой ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах чиглэлээр УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолыг батлуулсан. Тус тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоол батлагдан уг төмөр замыг барьж байгуулах этгээдээр төрийн өмчит компани болох ЭТТ ХК болон Монголын төмөр зам ХХК-ийн хамтарсан охин компани болох Тавантолгой төмөр зам ХХК-г байгуулж, холбогдох төмөр зам барих тусгай зөвшөөрлийг уг компанид өгсөн. Монголын төмөр зам болон ЭТТ оруулсан хөрөнгийн хэмжээгээр тус компанид хувьцаа эзэмших бөгөөд төмөр зам эхлүүлэх ажлыг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхийг ЭТТ-д зөвшөөрч төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 2022.07.01-ний өдөр ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | 100% | |
| 107 | 2 | 2 | **Жагсаалт шинэчлэн батлах тухай**<br>**2022-04-20**<br>**Дугаар 2022_164**<br>2. "Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан нарт үүрэг болгосугай. | "Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд жагсаалтын дагуу үйл ажиллагаа явуулж, улирал бүр тайлангаа УУХҮЯ-нд ирүүлж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 108 | 3 | 3 | **“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-08-08 Дугаар 2018_245**<br>1.. Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангахад шаардагдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан үйлчилгээг үзүүлэх чадвартай гүйцэтгэгчийн тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, холбогдох гэрээг байгуулан хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай. | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” саналыг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 296 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компани "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК-ийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 28 дугаар тогтоолын дагуу байгуулж, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийцүүлэн олон улсын болон дотоодын зах зээлд үе шаттайгаар үнэт цаас гаргах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, үйлчилгээ авах гэрээг байгуулан ажиллаж байсан.<br>Гэвч УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас баталсан 2019 оны 296 дугаар тогтоолыг 2020 оны 146 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул уг ажил зогссон. | /-/ | |
| 109 | 3 | 4 | 7.. Азийн хөгжлийн банктай байгуулсан “Засаглал, менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн зээлийн хөрөнгийн ашиглалтыг Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт тус тус үүрэг болгосугай. | Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоол болон Засгийн газрын 2018 оны 245, Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолуудаар Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай холбогдох шийдвэрүүд гарсан. Гэвч Засгийн газрын 2020.04.27-ны өдрийн хуралдаанаар 2019 оны Засгийн газрын 296 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан тул гадаадын зах зээлд хувьцаа гаргах ажил зогсонги байдалд орсон. | /-/ | |
| 110 | 4 | 5 | **Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-10 Дугаар 2019_135**<br>3.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг Монголбанкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй. | “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК хооронд 2019.10.24-ний өдөр “Үнэт цаас худалдах, худалдан авах тухай гэрээ”-г холбогдох хууль, журмын дагуу байгуулсан. 2019.12.27-нд Санхүүгийн зохицуулах хорооноос 407 дугаар тогтоол гаргаж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үнэт цаасыг албан ёсоор бүртгэж авсан. Үнэт цаас худалдан авах ажлыг “ЭТТ” ХК-аас үе шаттай зохион байгуулж 2020 оны 7 дугаар сард нийт 750 тэрбум төгрөгийн үнэт цаасны бүрэн худалдан авч төлбөрийг “Монголын төмөр зам” ТӨХК-д шилжүүлж дууссан. Одоогийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Монголын төмөр зам” ТӨХК-аас гаргасан 750 мянган ширхэг үнэт цаасыг эзэмшиж “Хаан банк” ХХК-ийн кастодиан үйлчилгээний газарт хадгалуулж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд 2019 оноос өнөөг хүртэлх хугацаанд нийт 1,180,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2022 онд 24,184 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. | 100% | |
| 111 | 5 | 6 | **Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** | Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ЗГ-ын 2020.09.09-ний өдрийн хуралдааны 48, 2020.11.04-ний өдрийн хуралдааны 58, 2022.01.26-ны өдрийн хуралдааны 6 дугаар тэмдэглэл гаргуулсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2018-06-29**<br>**Дугаар 2018 №73**<br>1.5/. Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | захиалгаар Дэлхийн банкны “2030 Усны нөөцийн бүлэг” нь “Монголын Өмнөд говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт-хангамжийн гидроэкономик шинжилгээ”-г 2020 онд хийж гүйцэтгэсэн.<br>Судалгаа, шинжилгээний үр дүнд өмнийн говийн ашиглах боломжтой газрын доорх усны нийт 20 ордыг нийгэм, эдийн засаг, байгаль орчны шалгуур үзүүлэлтээр үнэлж, хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн газрын доорх усны ордоос эхэлж ашиглах талаар зөвлөмж өгсөн ба үүнд Өмнийн говийн бүсэд гадаргын усыг шилжүүлэн ашиглах төсөл хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд Загийн усны хоолой болон Цагаан цавын газрын доорх усны ордуудыг ашиглах боломжтойг тодорхойлсон. | | |
| 112 | 6 | 7 | **Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>**2019-07-24**<br>**Дугаар 2019_304**<br>2.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д зөвшөөрч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т даалгасугай | “Эрдэнэс Тавантолгой” ХК нь холбогдох шийдвэрийн дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 66 хувийг эзэмшиж байгаа бөгөөд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,584.07 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 75.4%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд 2022 оны 7 дугаар сард багтаан төмөр замыг иж бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. | 100% | |
| 113 | 6 | 8 | . 4.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай. | Төслийн бүтээн байгуулалтын ажил 75.4%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд 2022 оны 7 дугаар сард багтаан төмөр замыг иж бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. | 70% | |
| 114 | 7 | 9 | **Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай**<br>**2020-09-23**<br>**Дугаар 2020_113**<br>2. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний үндсэн дээр барилгын ажлыг 2020 онд багтаан эхлүүлэх арга хэмжээ | Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийг санхүүжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Тавантолгой төмөр зам” ХХК ЭТТ-2022/13 дугаартай санхүүжилтийн гэрээг байгуулсан бөгөөд төслийн бүтээн байгуулалтад 2022 оны 6 дугаар сарын байдлаар нийт 118 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үлдэгдэл санхүүжилтийг өмнөх санхүүжилтийн зарцуулалтын тайланг үндэслэн олгохоор төлөвлөн ажиллаж байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 2022 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар нийт 70.08 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | | | |
| 115 | 8 | 10 | **Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**<br>**2020-09-30**<br>**Дугаар 2020_125**<br>2. Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тавдугаар хэсгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.” гэсэн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын 2020.12.30-ны өдрийн 167, А/698, А/336, А/242 дугаар хамтарсан тушаал батлагдсан. Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах байнгын ажиллагаатай ажлын хэсэг 2022 онд хуралдаагүй байна. Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын “Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн No169, А/698, А/336, А/242 дугаартай хамтарсан тушаалын үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтот түвшинд “Жилд дунджаар 2000 га талбайг нөхөн сэргээх” гэсний дагуу уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн 2022 оны ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны баталгаажсан 294 төлөвлөгөөнд 13040.5 га талбайд дүйцүүлэх нөхөн сэргээлт хийлгүүлэхээр тусгуулан, мэдээллийн санд нэгтгэсэн. | 100% | |
| 116 | 9 | 11 | **Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2021-04-07**<br>**Дугаар 2021_89**<br>1. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, барилгын ажлыг 2021 оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), барьж байгуулах ажиллагаа нь төмөр замын хөдөлгөөний болон техникийн аюулгүй ажиллагаа, барилга байгууламжийн технологийн горим, стандарт, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | “Тавантолгой төмөр зам” ХХК нь “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв” төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2021 оны 11 дүгээр сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг техник, эдийн засгийн үндэслэлд төлөвлөснөөр төсөл нь бутлуур, конвейерийн систем, овоолго үүсгэгч, овоолгоос тэжээгч, ачилтын бункер зэрэг дамжлага бүхий бүрэн автоматчилагдсан, цогц системээр дамжуулан жилд нийт 20.0 сая тонн нүүрсийг төмөр замд ачих хүчин чадалтай байх ба үүнээс Нүүрс баяжуулах үйлдвэрт 10.0 сая тонн нүүрсийг нийлүүлнэ.<br>Өнөөгийн байдлаар төслийн ажлын зураг төслийг Өмнөговь аймгийн Ерөнхий архитектур болон холбогдох яам, тамгын газраар баталгаажуулах ажил хийгдэж байна. Талбайн бэлтгэл ажил, бүтээн байгуулалтын ажлыг албан ёсоор 2022 оны 4 дүгээр сарын 22-нд эхлүүлсэн ба өнөөдрийн байдлаар төслийн нийт гүйцэтгэл 21.5 хувьтай байна. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн зүгээс төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны 4-р улиралд бүрэн дуусгаж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн. | 70% | |
| 117 | 10 | 12 | **Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай** | Уул уурхайн компьютержсон кадастрын системд 2022 онд нэмэлтээр цахим архивын систем хийгдэж ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн цаасан материалуудыг цахимжуулж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд 607 тусгай зөвшөөрлийн 91,971 гаруй хуудас баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэн архивлаад байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2020-01-15**<br>**Дугаар 2020_17**<br>1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн иж бүрдлийг бүрэн хангуулах, цахим мэдээллийн төрөлжсөн санг 2020 оны I улиралд багтаан байгуулах, тус мэдээллийн санг холбогдох төрийн байгууллагууд ашиглах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай | Тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн цахим архив үүсгэх ажил нь 2020 оны 10 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт хүчинтэй болон хүчингүй болсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн хувийн хэрэг болох 4351 тусгай зөвшөөрлийн 689 мянга гаруй хуудсыг цахим файл үүсгэн хадгалаад байна.<br>Манай байгууллагын зүгээс бусад төрийн байгууллагуудад мэдээллийн санд холбогдох сервис гарган ажиллаж байна. Одоогоор Байгаль орчин аялал жуулчлалын яам холбогдон ажиллаж байгаа бөгөөд Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газрын дарга болон Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нарын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/140, А/270 дугаар хамтарсан тушаалаар Ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл олгосон газрын зураг зүйн болон Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сангуудын нэгдсэн уялдаа холбоог хангах, мэдээллээ саадгүй солилцох, шинэчлэх боломжтой "Дундын мэдээллийн сан"-г байгуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна. Газрын харилцаа геодези, зураг зүйн газартай 2021 онд байгуулсан Мэдээлэл солилцох тухай 2021/80 дугаартай гэрээний дагуу Геологи уул уурхайн компьютержсон кадастрын системийн сантай холбох сервисийг үүсгэсэн бөгөөд Газрын харилцаа геодези, зураг зүйн газраас гаргах сервис хүлээгдэж байна. | | |
| 118 | 11 | 13 | **Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай**<br>**2021-04-28**<br>**Дугаар 2021_113**<br>1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай. | Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “Чайна металлуржикал инженеринг компани” /CMEC/ боловсруулж 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бүртгүүлсэн. “Эрдэнэс Тавантолгой” ХК CMEC компани хооронд байгуулсан гэрээний дагуу 2 дугаар шатны ажил болох нүүрс баяжуулах үйлдвэрийн FEED буюу урьдчилсан зураг төслийг ажлыг 2021 оны 8 дугаар сард хүлээлгэн өгсөн. “Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” түлхүүр гардуулах нөхцөлтэй нээлттэй тендерийг холбогдох журмын дагуу 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдөр, 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тус тус зарласан боловч тендер амжилтгүй болсон. Улмаар тендерийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр дахин зарласан бөгөөд тендерт “ENR” TOP 250 листэд бүртгэлтэй “Power construction corporation of China” Ltd, “Norinco International Cooperation” Ltd гэсэн хоёр компани материал ирүүлсэн. Тендер шалгаруулалтад “Norinco International Cooperation” Ltd-ийн ирүүлсэн тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрхийг олгож, 2022 оны 4 дүгээр сарын 14-нд EPC гэрээг байгуулсан бөгөөд одоогоор тус компанитай хамтран төслийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж байна. Төслийн талбай дээр барилгын угсралтын ажлын бэлтгэл ажил хийгдэж байна. | 70% | |
| 119 | 12 | 14 | **“Тавантолгой түлш” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2021-10-13**<br>**Дугаар 2021_316**<br>3. “Тавантолгой түлш” ХХК-ийн нийт хувьцааны 51 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д эзэмшүүлэхээр тогтоосугай. 2. “Тавантолгой түлш” ХХК-ийн Засгийн газрын эзэмшлийн 49 хувийн хувьцааны төрийн өмчийн төлөөллийн 39 хувийг Эрчим хүчний яам, 10 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр тус тус тогтоосугай. 3. Энэ тогтоолын 1, 2 дахь заалтаар “Тавантолгой түлш” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн | “Таван толгой түлш” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” болон “Түр хороо байгуулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, ТУЗ-ийн тогтоолыг гаргасан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2022 оны төсвийн төсөлд “Таван толгой түлш” ХХК-ийн өр төлбөрийг барагдуулах хөрөнгийг тусгасан. Таван толгой түлш” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж, компанийн шинэчилсэн дүрмийг баталгаажуулж, Улсын бүртгэлийн Ерөнхий газар бүртгүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эзэмшлийн хувь хэмжээ болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн төлөөллийг хэрэгжүүлэгч этгээдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсантай холбогдуулан “Тавантолгой түлш” ХХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хэрэгжүүлэхийг “Тавантолгой түлш” ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Ганбаатарт даалгасугай. 4. “Тавантолгой түлш” ХХК-ийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай. | | | |
| 120 | 13 | 15 | **Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-10-20 Дугаар 2021_321** 4. “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг орон нутагт хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, тухайн орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Их, дээд сургуулийг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт нэр авахаар БШУЯ-наас 2021.11.29-ний өдрийн 1б/6140 дүгээр албан бичгийг ирүүлсэн. Тус ажлын хэсэгт УУХҮЯ-ны Статистик судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Эрдэнэбат, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Жадамба нарыг оролцуулахаар 2021.12.08-ны өдрийн 02/3044 дүгээр албан бичгийг БШУЯ-д хүргүүлсэн. | 30% | |
| 121 | 13 | 16 | 5. Энэ тогтоолын 1.1-д заасан төрийн өмчийн их, дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, 1.2-т заасан Шинжлэх ухаан, технологийн | Их, дээд сургуулийг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт УУХҮЯ-наас төлөөлөл ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн нар Их сургуулийн цогцолбор төсөл хамтран хэрэгжүүлэхээр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зураад байна. Ингэснээр Ш.Отгонбилэгийн нэрэмжит Эрдэнэт цогцолбор дээд сургуулийг уул уурхай | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сургуулийн харьяа сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, 1.3-т заасан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Монгол Улсын Их сургуулийн бүрэлдэхүүн “Эрдэнэт” сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болон нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга С.Батжаргал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Х.Бадамсүрэн) нарт тус тус даалгасугай. | технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх ажил хийгдэж, ШУТИС-ийн 3 хөтөлбөрийг Эрдэнэт цогцолбор дээд сургуульд нутагшуулж, тухайн 3 хөтөлбөрөөр мэргэжилтэн давхардуулан бэлтгэхгүй байх нөхцөл бүрдэж байна. | | |
| 122 | 14 | 17 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай 2020-09-23 Дугаар 2020_117**<br>3. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааг хаалттай хүрээнд нэрлэсэн үнээр худалдах замаар нийт хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, цаашид “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу үе шаттай шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Баярсайхан)-д тус тус даалгасугай | “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг эзэмшигч “Тавантолгой-Зүүнбаян” ХХК-ийн 66 хувийг эзэмшиж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 123 | 15 | 18 | **Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-01-15**<br>**Дугаар 2020_17**<br>5.. Ашигт малтмалын ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам”-ыг шинэчлэн боловсруулж 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай. | АМГТГ-ын даргын 2020.04.03-ны өдрийн А/35 дугаар тушаалаар “Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам”-ын явц, хэрэгжилтийн үр дүн, биелэлтийг судалж, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулах үүрэг бүхий 9 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдан журмын төслийг боловсруулсан болно. | 30% | |
| 124 | 15 | 19 | 11.. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээн авсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэргүй болон Монгол Улсын хилийн зурваст олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, бичил уурхайтай холбогдох хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох асуудлыг тус тус судалж, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зохих журмын дагуу боловсруулж, 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт үүрэг болгосугай | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2021 онд санал өгсөн. “Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын 1 дэх заалтад Ашигт малтмалын тухай хуулийн төсөл (Шинэчилсэн найруулга)-ийг хэлэлцэхээр тусгасан боловч тайлангийн хугацаанд хэлэлцээгүй. | 30% | |
| 3.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 125 | 1 | 1 | **2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 1 дүгээр тэмдэглэл**<br>**2022-01-05**<br>**Дугаар 2022_1**<br>XX.2. 10. “Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолоор түр хаасан хилийн Даян, | Өнөөгийн байдлаар Монгол Улсын Хятадын талтай хиллэж байгаа дараах хилийн боомтууд ажиллаж байна. Үүнд: Монгол Улсын хилийн Булган, Бургастай, Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги, Замын-Үүд, Баянхошуу зэрэг боомтууд байна.<br>Улсын хэмжээнд 2022.06.17-ны өдрийн байдлаар нийт 7.1 сая тонн нүүрс, 687.7 мянган тонн зэсийн баяжмал, 1.6 сая тонн төмрийн хүдэр, баяжмал тус тус экспортод гаргасан байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Байтаг, Сүмбэр, Хавирга боомтоор уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох боломж, нөхцөлийг судалж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт; | | | |
| 3.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 126 | 1 | 1 | **2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл**<br>**2018-07-04**<br>**Дугаар 2018_29**<br>XX.4. 2. . Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлох, улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг судлах, байгалийн өнгөт чулууны жишиг үнэлгээг тогтоолгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт; | Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол , 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу уул уурхайн экспортын дараах бүтээгдэхүүнүүдийн олон улсын зах зээлийн үнийг Сангийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан 2018 оны 200/А/177 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийтэд мэдээлж байгаа болно. Үүнд: Цайр, зэс, цагаан тугалга, хар тугалга, хөнгөн цагаан, молибдени, алт, мөнгө, нүүрс, төмөр, жонш, гянтболдын хүдэр, манганий хүдэр зэрэг багтаж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Монгол Улсад үнэт металл, эрдэнийн чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эдээр хангах болон худалдаалах зэрэг асуудлуудыг олон улсын чиг хандлагад нийцүүлэх зорилгоор "Үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, түүний эргэлтийн тухай" хуулийн төслийг үзэл баримтлалын төслийн хамтаар боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулахаар Хууль, зүй дотоод хэргийн яаманд 2018.07.25-ны өдрийн 01/2026 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 30% | |
| 127 | 2 | 2 | **2020 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 35 дүгээр тэмдэглэл**<br>**2020-06-12**<br>**Дугаар 2020_35**<br>XIX.4. . “Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын нутаг дэвсгэрт орших “Асгат”-ын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зарим арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшиж байгаа стратегийн ач холбогдол бүхий “Асгат”-ын ордын техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулсны үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах саналаа Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт даалгав. | Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын нутаг дэвсгэрт орших “Асгат”-ын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зарим арга хэмжээний талаар Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 16 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |
| 128 | 3 | 3 | **2020 оны 11 дүгээр сарын 18ны өдөр 64 дүгээр тэмдэглэл**<br>**2020-11-18**<br>**Дугаар 2020_64**<br>YIII.1.2. Ашигт малтмал хууль бусаар олборлохтой тэмцэх, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар төлөвлөгөө | Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн ажлын албаны Дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээнд манай яам нэгдэж “Ногоон дуу хоолой” нэртэйгээр 2022 оны 04 дүгээр сарын 25-аас 05 дугаар сарын 25-ны хооронд орон даяар “Зөв мод-зөв арчилгаа” уриан дор доорхи ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга)-т; | 1.“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээнд нэгдэх тухай уриалгыг 2022 онд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгөө ирүүлсэн 439 аж ахуйн нэгжийн цахим хаягаар хүргүүлсэн.<br>2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Үндэсний геологийн албаны албан хаагчид Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон тус сарын аяны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Баянзүрх дүүргийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 120 модыг ойн мэргэжлийн инженерийн заавар зөвлөмжийн дагуу тарьсан.<br>3.Ашигт малтмал, Газрын тосны албан хаагчид “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон тус сарын аяны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн агропаркад 500 модыг ойн мэргэжлийн инженерийн заавар зөвлөмжийн дагуу тарьсан.<br>4.Сарын аянд нэгдэх, аж ахуй нэгжүүдийг нэгдэн оруулах тухай албан бичгийг Ашигт, малтмал газрын тосны газарт хүргүүлсэн.<br>5.Ашигт малтмал, газрын тосны газар нь Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Уул уурхайн нөхөн сэргээлтийн корпорац болон худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагийн Монгол дахь салбартай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд 680 сая мод тарихаа илэрхийлсэн, томоохон 30 компанийн мэргэжилтнүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын уул уурхайн нөхөн сэргээлтийн туршлага, ойжуулалт, мод тарих аргачлал, технологи сэдвийн хүрээнд сургалт, семинарыг зохион байгуулсан.<br>Хууль бус ашигт малтмалын олборлолттой холбоотой мэдээллийг санд нэгтгэх зорилгоор МХЕГ, Экологийн цагдаагийн албанд 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр албан бичиг хүргүүлэв. | | |
| 129 | 4 | 4 | **2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр 53 дугаар тэмдэглэл**<br>**2021-09-29**<br>**Дугаар 2021_53**<br>XIX.3. . Эдийн засгийг дэмжих шинэ сэргэлтийн бодлого (Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төслийн боловсруулалтын явц, хилийн Гашуунсухайт боомтын дахь чингэлэг тээврийн терминалын талаар авах зарим арга хэмжээний тухай)-ын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2019 онд байгуулсан “Монгол Улсын хилийн боомт дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ”-ний хүрээнд хийгдэх Замын-Үүд, Гашуунсухайт боомтын авто зам, талбайн барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал (элс, хайрга, дайрга)-ын талбайн солбицол тогтоох болон ашиглах эрх олгох тухай асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын | Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2019 онд байгуулсан “Монгол Улсын хилийн боомт дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ”-ний хүрээнд хийгдэх Замын-Үүд, Гашуунсухайт боомтын авто зам, талбайн барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгуулахаар хүсэлт ирүүлсэн талбайнууд нь хуулиар хориглосон, хязгаарласан талбайтай давхцалтай байна. Иймд хариуцсан төслийн нэгжтэй хамтран талбайн байршлыг өөрчлөн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шинэ солбицол хүлээж байна. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав. | | | |
| 130 | 5 | 5 | **2020 оны 12 дугаар сарын 2-ны өдөр 68 дугаар тэмдэглэл**<br>**2020-12-02**<br>**Дугаар 2020_68**<br>IX.2. 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уулын ажлын төлөвлөгөө, тайланг уул уурхайн болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран хянаж, баталгаажуулдаг байх асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уулын ажлын төлөвлөгөө, тайланг уул уурхайн болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран хянаж судлах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулж, уг асуудлыг шийдвэрлэхээр шинээр бий болох хууль эрх зүйн орчинг бий болгох тухай дүгнэлт гарсан. Улмаар УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан ба тус ажлын хэсгээс уг асуудлыг тусган хуулийн төслийг 2021 онд боловсруулаад байна. | 70% | |
| 131 | 6 | 6 | **2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл**<br>**2021-03-05**<br>**Дугаар 2021_15**<br>III.2.3. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замыг барьж байгуулах ажлыг эрчимжүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 113 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/217, А/293 дугаар тушаалаар "Тавантолгой-Гашуунсухайт”, “Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замыг холбох холболтын төмөр замын барилгын ажлыг эхлүүлсэн. Төслийн бүтээн байгуулалтын ажил 2022 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар нийт 70.08 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70% | |
| 132 | 6 | 7 | III.2.4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д; | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд 2019 оноос өнөөг хүртэлх хугацаанд нийт 1,180,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2022 онд 24,184 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. | 70% | |
| 133 | 7 | 8 | **2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 21 дүгээр тэмдэглэл**<br>**2021-03-31**<br>**Дугаар 2021_21**<br>YII.9. Хилийн боомтуудын экспорт, импортын хэвийн үйл ажиллагааг хангах, ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, тасалдалгүй байхаар зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | Монгол-Хятадын хилийн бүсийн “Ногоон гарц” түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх саналыг боловсруулж 2021.02.16-ны өдрийн 01/373 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.<br>Үүний дүнд Ховд аймгийн нутаг дэвсгэр орших Булган боомтыг амралтын өдрүүдэд ажиллуулж хүчин чадлыг нэмэгдүүлсэн.<br>Мөн нүүрсний тээврийн жолооч нарыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг дархлаажуулалт болох вакцинжуулалтад хамруулах ажлыг 2021.03.18-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн жолооч нарыг нэн түрүүнд вакцинд хамруулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргуулан Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт 11000 вакцины тун хүргүүлснээр Гашуун сухайт боомтын 5449, Оюутолгойн тээврийн 200, Шивээ хүрэн боомтын 1658, нийт 7307 тээврийн жолооч, тээвэр хариуцсан ажилчдыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг вакцинд хамруулсан болно. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан 2022 оны 47 дугаар захирамжаар байгуулагдсан “Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, холбогдох мэдээлэл, саналыг тухай бүр өгч ажилласан.<br>Улсын хэмжээнд 2022.06.17-ны өдрийн байдлаар нийт 7.1 сая тонн нүүрс, 687.7 мянган тонн зэсийн баяжмал, 1.6 сая тонн төмрийн хүдэр, баяжмал тус тус экспортод гаргасан байна. | | |
| 134 | 8 | 9 | **2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2021-05-12**<br>**Дугаар 2021_30**<br>XIX.5. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт ажилласан талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав: 1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх замаар “Ногоон бүс” түр журмыг бүрэн хэрэгжүүлж “Гашуунсухайт” боомтын үйл ажиллагааг хэвийн горимд оруулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | Монгол-Хятадын хилийн бүсийн “Ногоон гарц” түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх саналыг боловсруулж 2021.02.16-ны өдрийн 01/373 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.<br>Үүний дунд Ховд аймгийн нутаг дэвсгэр орших Булган боомтыг амралтын өдрүүдэд ажиллуулж хүчин чадлыг нэмэгдүүлсэн.<br>Мөн нүүрсний тээврийн жолооч нарыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг дархлаажуулалт болох вакцинжуулалтад хамруулах ажлыг 2021.03.18-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан.<br>Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн жолооч нарыг нэн түрүүнд вакцинд хамруулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргуулан Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт 11000 вакцины тун хүргүүлснээр Гашуун сухайт боомтын 5449, Оюутолгойн тээврийн 200, Шивээ хүрэн боомтын 1658, нийт 7307 тээврийн жолооч, тээвэр хариуцсан ажилчдыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг вакцинд хамруулсан болно.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан 2022 оны 47 дугаар захирамжаар байгуулагдсан “Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, холбогдох мэдээлэл, саналыг тухай бүр өгч ажилласан. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд хийх нүүрсний тээврийн үйл ажиллагаа 2022.05.25-ны өдрөөс эхэлсэн бөгөөд улсын хэмжээнд 2022.06.10-ны өдрийн байдлаар нийт 6.36 сая тонн нүүрс экспортод гаргасан байна. | 70% | |
| 135 | 9 | 10 | **2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл**<br>**2021-02-17**<br>**Дугаар 2021_11**<br>XII.12. 8. Бүс нутгийн логистикийн төвүүдийн байршлыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох судалгааг хамтран хийж, 2021 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт; | Уул уурхайн салбарыг хөгжүүлэх, эрчимжүүлэхэд зохицуулах хууль дүрэм журам шаардлагатай байгаагаас гадна, дэд бүтэц, бүтээгдэхүүний тээвэр, логистикийн хангалтгүй байдал, орон нутаг, иргэний хөдөлгөөнүүдийн эсэргүүцэх үйл ажиллагаа, бүтээгдэхүүний үнийг олон улсын зах зээлийн үнээр өгч чаддаггүй, дундын зуучлагчдын үнээр борлуулдаг зэрэг олон шалтгаан байгааг нөхцөл байдлын дүн шинжилгээний судалгаагаар тогтоосон. Уул уурхайн салбарын дэд бүтэц /цахилгаан хангамж, усан хангамж/, бүтээгдэхүүний тээвэр, логистикийн хангалтгүй байдлыг сайжруулах, төр бодлогоор дэмжих. Төлөвлөсөн төмөр замыг барьснаар үйл ажиллагаагаа эхлэх, эрчимжүүлэх уул уурхайн компанийн тоо 20% нэмэгдэх боломжтой гэж судалгаагаар гарсан. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн 3 удаагийн хуралд оролцож Бүсийн хөгжлийн зорилтод хөтөлбөрт уул уурхайн салбарын зорилго, зорилт, үйл ажиллагаа бүс нутгийн логистикийн төвүүдийн байршлыг тодорхойлж холбогдох бусад мэдээллийг бэлтгэн Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022.04.29-ний өдөр танилцуулсан. | 70% | |
| 136 | 10 | 11 | **2021 оны 5 дугаар сарын 12-ний өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2021-05-12**<br>**Дугаар 2021_30**<br>XIX.5.4 . “Тавантолгой-Зүүнбаян” төмөр замын ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл | Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд 2019 оноос өнөөг хүртэлх хугацаанд нийт 1,180,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2022 онд 24,184 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт | | | |
| 137 | 11 | 12 | **2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 45 дугаар тэмдэглэл**<br>**2021-08-04**<br>**Дугаар 2021_45**<br>XII.6. . Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэсэн ажлын төлбөр, тооцоо, зардал болон төслийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нарт даалгав; | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд 2019 оноос өнөөг хүртэлх хугацаанд нийт 1,180,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2022 онд 24,184 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. | 70% | |
| 138 | 12 | 13 | **2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 56 дугаар тэмдэглэл**<br>**2021-10-20**<br>**Дугаар 2021_56**<br>YIII.7. . Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үе шатанд хүрснийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтийн явцын талаар Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |
| 139 | 13 | 14 | **2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл**<br>**2021-12-08**<br>**Дугаар 2021_63**<br>IY.. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад даалгав: 1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх; 2. “Эрдэнэс Монгол” | Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 147 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж “Эрдэнэс Монгол” ХХК-ийн шинэчилсэн зохион байгуулалтын бүтцийн талаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 28 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани, төслийн нэгжүүдийг группын зохион байгуулалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ХХК-ийн үр ашиггүй зардлыг бууруулах, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх оновчтой бүтцийг бий болгох үүднээс бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон шинэчлэх арга хэмжээ авах; 3. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдсэн стратеги төлөвлөгөө, бодлогод нийцүүлэн охин болон хараат компаниуд Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх шаардлагатай эсэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх. | | | |
| 140 | 14 | 15 | **2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр 48 дугаар тэмдэглэл**<br>**2020-09-09**<br>**Дугаар 2020_48**<br>XI.1. 3. Тавантолгойн нүүрсний ордын уурхайн үйл ажиллагаатай уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох, ус ашиглах зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Өмнөговь, Дорноговь, Хэнтий аймгийн Засаг дарга нарт | Улсын Их Хурлын чуулганы 2020.08.28-ны өдрийн хуралдаанаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна”, “Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ” гэсэн зорилтууд тусгагдсан. Үүнтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц болон бусад дэд бүтцийн төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж байна. Улсын Их Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барихаар төлөвлөж байгаа Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрт олгосон 220 л/сек усны зөвшөөрлийг “Эрдэнэс- Тавантолгой” ХК-д шилжүүлж өгөхийг хүссэн хүсэлтийг 2020.10.08-ны өдрийн 03/2510 дугаар албан бичгээр Байгаль орчин аялал, жуулчлалын яаманд хүргүүлсэн. Тавантолгойн нүүрсний ордод түшиглэн байгуулагдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр БОАЖЯ-ны байр суурийг сонсох, харилцан мэдээлэл, санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох уулзалтыг УУХҮСайд Г.Ёндон, Усны газрын дарга Ш.Мягмар, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, Дэлхийн банкны “2030 Усны нөөцийн бүлэг”-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Д.Доржсүрэн болон бусад холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2021.04.03-ны өдөр зохион байгуулсан. Мөн тус яамнаас Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн усан хангамжийн асуудлын талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022.01.26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Түүнчлэн Тавантолгойн ордын нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийг Загийн усны ордоос ашиглах зөвшөөрлийг “Эрдэнэс Тавантолгой” ХК авсан байна. | 100% | |
| 141 | 15 | 16 | **2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл**<br>**2022-02-23**<br>**Дугаар 2022_12**<br>X.3.1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдэд олгох үлдэгдэл санхүүжилт болон төмөр замаар зүгшрүүлэх тээврийг эхлүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 2022 оны 3 дугаар сарын эхний хагаст багтаан шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав; | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд 2019 оноос өнөөг хүртэлх хугацаанд нийт 1,180,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2022 онд 24,184 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 87%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд 2022 оны 10 дугаар сард багтаан төмөр замыг иж бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 142 | 15 | 17 | Х.10. . Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” компани хоорондын цахим уулзалтын дүнгийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан талуудын яриа, хэлцлийг эрчимжүүлэх зорилгоор Монголын талын байр суурийг нэгтгэн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шийдэл бүхий саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав | “Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” компани хоорондын цахим уулзалтын дүнгийн талаар Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 14 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |
| 143 | 16 | 18 | **2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл**<br>**2022-03-02**<br>**Дугаар 2022_14**<br>XI.2.1. 2.1. Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг ашиглалтад орохоос өмнө болон ашиглалтад орсны дараа БНХАУ-тай хийх нүүрс урьдчилан борлуулах асуудлаар айлын талаас тавьсан саналыг судлан үзэх, холбогдох гэрээний нөхцөл болон тооцоо, судалгааг хийж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хилийн боомтын Үндэсний зөвлөл (Б.Жавхлан), “Эрдэнэс-Тавантолгой” ХК (Б.Ганхуяг)-нд; | Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг ашиглалтад орохоос өмнө болон ашиглалтад орсны дараа БНХАУ-тай хийх нүүрс урьдчилан борлуулах асуудлаар айлын талаас тавьсан саналыг судлан үзэж, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан. | 100% | |
| 144 | 16 | 19 | XI.2.2.. Хөгжлийн төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх хүрээнд шаардагдах “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас нүүрс урьдчилан борлуулах асуудлаар нэгдсэн танилцуулга бэлтгэж, Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК (Б.Ганхуяг)-нд. | Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко компани хооронд байгуулсан нүүрсний гэрээг үргэлжлүүлэх, урьдчилгаа төлбөр авах асуудлыг танилцуулж, хуралдааны 18 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |
| 145 | 17 | 20 | **2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br>**2022-03-23**<br>**Дугаар 2022_17**<br>IX.3.3. Оюу толгойн уурхайн баяжмалын агуулгад байгаа алтны хэмжээг зохих аргачлал, журмын дагуу тооцож, Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг судлан санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, | Оюу толгойн уурхайн баяжмалын агуулгад байгаа алтны хэмжээг зохих аргачлал, журмын дагуу тооцож, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг судалж байна. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт нарт | | | |
| 146 | 17 | 21 | IX.3.4. “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын “Чалко Трэйдинг Хонгконг” компани хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээний үндсэн нөхцөлүүдийг сайжруулах талаар хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гэрээг үргэлжлүүлэх эсэх саналаа танилцуулахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт. | Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко компани хооронд байгуулсан нүүрсний гэрээг үргэлжлүүлэх, урьдчилгаа төлбөр авах асуудлыг танилцуулж, хуралдааны 18 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Улмаар Засгийн газрын шийдвэрийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко Трэйдинг Хонгконг компани хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээг үргэлжлүүлэн байгуулсан. | 100% | |
| 147 | 17 | 22 | IX.4. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 3 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт томилолтоор ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав: 1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд “Асгат”-ын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд | Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын нутаг дэвсгэрт орших “Асгат”-ын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зарим арга хэмжээний талаар Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 16 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.<br>Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр “Асгат”-ын ордын техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан саналаа танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хуланд даалгасан болно. УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос Монгол Улсын Засгийн Газарт чиглэл өгөх тухай 2022-01-21-ний өдрийн 01 дүгээр тогтоол гарсан. Уг тогтоолд Асгатын мөнгөний ордод нарийвчилсан хайгуулын ажил хийж, нөөцийг тодотгох, нарийвчилсан хайгуулын ажлыг бүс нутгийн хэмжээнд хийх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх “Эрдэнэс Монгол” ХХК-хариуцуулах тухай заалтууд орсон. Тус тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Асгатын мөнгөний орд дахь ашиглалтын 4 тусгай зөвшөөрлийн хүрээнд гүйцээх хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газарт танилцуулсан бөгөөд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна. | 70% | |
| 148 | 17 | 23 | IX.19. . “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” компани хооронд 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан БНХАУ-ын талтай нүүрс урьдчилан борлуулах гэрээний нөхцөлийг эцэслэн тохиролцох, гэрээ байгуулах ажлыг эрчимжүүлж 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор дуусгаж, дүнг танилцуулахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), Гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг)-д даалгав | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг ашиглалтад орохоос өмнө 5 сая тонн, ашиглалтад орсны дараа 20 сая тонн нүүрс нийлүүлэх айлын талаас тавьсан нөхцөлийн талаар БНХАУ-ын Чайна энержи компанитай цахим уулзалт хийж, саналаа тус компанид 2022 оны 03 дугаар сарын 30, 4 дүгээр сарын 05-ны өдрүүдэд хүргүүлсэн бөгөөд тус компанийн зүгээс БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос чиглэл авахаар хүлээж байгаа талаар мэдэгдээд байна. Уг асуудлаар Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр танилцуулж, хуралдааны 18 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |
| 149 | 18 | 24 | **2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл<br>2022-03-30<br>Дугаар 2022_18** | Засгийн газрын шийдвэрийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко Трэйдинг Хонгконг компани хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээний гол нөхцөлүүдийг сайжруулан 250 сая ам.долларын урьдчилгаа төлбөрийг төвлөрүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XI.7.1. 1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын “Чалко Трэйдинг Хонгконг” компани хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээний гол нөхцөлүүдийг сайжруулах чиглэлээр талуудын хэлэлцэн тохиролцсон нөхцөлийг тусган гэрээг үргэлжлүүлэх, гэрээний хүрээнд “Чалко Трэйдинг Хонгконг” компанитай тохиролцсон нөхцөлөөр урьдчилгаа төлбөр төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт | | | |
| 150 | 18 | 25 | XI.7.2. 2. Экспортыг дэмжих ажлын хүрээнд нүүрсний тээвэрлэлтийг эрчимжүүлэн Гашуунсухайт боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, нүүрсний экспортын нэмэлт гарц нээх, шаардлагатай тохиолдолд чингэлэгт тээвэрлэлтийн гаалийн хяналт, бүрдүүлэлтийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхайд зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав. | Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан 2022 оны 47 дугаар захирамжаар байгуулагдсан “Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, холбогдох мэдээлэл, саналыг тухай бүр өгч ажилласан.<br>Улмаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд хийх нүүрсний тээврийн үйл ажиллагаа 2022.05.25-ны өдрөөс эхэлсэн бөгөөд улсын хэмжээнд 2022.06.10-ны өдрийн байдлаар нийт 6.36 сая тонн нүүрс экспортод гаргасан байна. | 100% | |
| 151 | 19 | 26 | **2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр 20 дугаар тэмдэглэл**<br>**2022-04-06**<br>**Дугаар 2022_20**<br>XIII.. Дараахь арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захиралд даалгав: 2.1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн шинэчилсэн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх; 2.2. Шинэчилсэн дүрэмд нийцүүлэн нэгдлийн охин болон хараат компаниудын дүрэм, нэгдлийн хэмжээнд мөрдөх бодлого, журам, гэрээ зэрэг баримт бичгүүдийг шинэчлэх | Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 147 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Эрдэнэс Монгол ХХК-ийн шинэчилсэн зохион байгуулалтын бүтцийн талаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани, төслийн нэгжүүдийг группын зохион байгуулалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлыг хэрэгжүүлэх; 2.3. Шинэчилсэн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах | | | |
| 152 | 20 | 27 | **2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл**<br>**2022-04-20**<br>**Дугаар 2022_24**<br>XIY.10.1. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан төмөр замын төслүүдийн явцын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилтийг 2022 оны 4 дүгээр сард багтаан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав | Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийг санхүүжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Тавантолгой төмөр зам” ХХК ЭТТ-2022/13 дугаартай санхүүжилтийн гэрээг байгуулсан бөгөөд төслийн бүтээн байгуулалтад 2022 оны 6 дугаар сарын байдлаар нийт 118 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үлдэгдэл санхүүжилтийг өмнөх санхүүжилтийн зарцуулалтын тайланг үндэслэн олгохоор төлөвлөн ажиллаж байна. | 70% | |
| 153 | 21 | 28 | **2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугээр тэмдэглэл**<br>**2022-03-16**<br>**Дугаар 2022_16**<br>XYIII.20.1. “Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” компани хооронд 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр хийсэн ээлжит цахим уулзалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын бүтээн байгуулалтын төслийн ажлыг яаралтай эхлүүлэх зорилгоор БНХАУ-ын талтай нүүрс урьдчилан борлуулах талаарх яриа хэлэлцээг нэн тэргүүнд тавьж, гэрээний холбогдох нөхцөлийг тохиролцох арга хэмжээг авч танилцуулсны үндсэн дээр гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг)-д; | Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг ашиглалтад орохоос өмнө болон ашиглалтад орсны дараа БНХАУ-тай хийх нүүрс урьдчилан борлуулах асуудлаар айлын талаас тавьсан саналыг судлан үзэж, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан. | 100% | |
| 154 | 21 | 29 | XYIII.20.2. Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын талаас | Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг ашиглалтад орохоос өмнө болон ашиглалтад орсны дараа БНХАУ-тай хийх нүүрс урьдчилан борлуулах асуудлаар айлын талаас тавьсан саналыг судлан үзэж, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | санхүүжүүлэх саналыг хүлээн авах, хөрөнгө оруулалтын хэмжээг тохиролцох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг), “Тавантолгой төмөр зам” ХХК (Н.Удаанжаргал)-д | | |
| 155 | 22 | 30 | **2022 оны 4 дугаар сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл**<br>**2022-04-20**<br>**Дугаар 2022_24**<br>XIY.14.1. Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; | Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5 дахь заалтад хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх гэж заасан.<br>Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтыг үндэслэн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.3.5-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд ажиллах хүчний хувь хэмжээг хязгаарлахгүй байхыг дэмжсэн саналыг хүргүүлсэн.<br>Монголын алт (МАК) ХХК-иас гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай тодорхой хүсэлт ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч ажиллана. | 70% | |
| 156 | 22 | 31 | XIY.14.2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн асуудлыг судалж, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт | Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Аж үйлдвэржилтийн сэргэлт зорилтыг эрчимжүүлэх хүрээнд дотоодын болон гадаадын зах зээлд борлуулсан, худалдсан, худалдахаар ачуулсан эрдэс бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хэрхэн ногдуулах асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.01.24-ний өдрийн А/09 дугээр тушаалаар батлуулж, ажлын хэсгийн хуралдааныг 3 удаа зохион байгуулсан.<br>Нүүрс, төмрийн хүдэр, жоншны АМНАТ-ийн Олон Улсын туршлагын талаарх судалгааг Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)-ээр хийлгэсэн бол бусад ашигт малтмалын АМНАТ-ын судалгааг Уул уурхайн үндэсний ассоциацитай хамтран Олон Улсын PWC судалгааны байгууллагаар хийлгэсэн. Дээрх судалгаануудад үндэслэн нүүрсний АМНАТ-ийг тооцож авах аргачлалыг батлуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан | 70% | |
| 157 | 23 | 32 | **2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл**<br>**2022-05-11**<br>**Дугаар 2022_28**<br>XYI.6. Гашуунсухайт хилийн боомтод дэвшилтэт технологийн (төмөр зам, авто зам, автомат удирдлагатай тээвэр, жолоочгүй тээвэр, дүүжин тээвэр бүхий) тээвэр, логистикийн Тавантолгой нэгдсэн | Тавантолгой нэгдсэн терминалын асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Өмнөговь аймагт 2022.05.26-ны өдөр ажиллах үеэр танилцуулсан.<br>Гашуунсухайт өртөөнд төмөр замын тээврээр ирсэн ачааг авто машинд шилжүүлэх ачих, өргөн царигийн вагоноос ачааг нарийн царигийн вагонд шилжүүлэн ачих зориулалт бүхий шилжүүлэн ачих терминалын төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Уг терминалыг нийт 74 га талбайд байгуулахаар төлөвлөж байгаа ба төслийн төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын ажлыг 2022 оны 07 дугаар сараас эхлүүлж, үе шаттайгаар ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | терминалыг иж бүрдлийн хамт байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, шаардагдах санхүүжилтийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран шийдвэрлэж, тэдгээрийн оролцоог хангаж ажиллахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт | | | |
| 158 | 23 | 33 | XYI.7. Гашуунсухайт хилийн боомтод тээвэр, логистикийн Тавантолгой нэгдсэн терминалыг барьж байгуулахад шаардагдах газрын хэмжээ, тусгай хэрэгцээнд авах талбайн байршил, эргэлтийн цэгүүдийн солбицлыг нарийвчлан тогтоож, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | Гашуунсухайт хилийн боомтод тээвэр, логистикийн Тавантолгой нэгдсэн терминалыг барьж байгуулахад шаардагдах газрын хэмжээ, тусгай хэрэгцээнд авах асуудал нь манай яамны эрхлэх асуудалд хамаарахгүй тул биелэлт гаргах боломжгүй байна. | /-/ | |
| 159 | 23 | 34 | XX.3.1.2. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцлын асуудлыг судалж, шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцалын асуудлаар тус яамнаас 2022.04.28-ны өдрийн 03/1215 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас тодруулга хүссэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022.05.17-ны өдрийн 03/2238 дугаар албан бичгээр тус яаманд хариу ирүүлсэн бөгөөд уг албан бичигт концессын гэрээ эзэмшигч "Тахилт хайрхан транс" ХХК нь "...замын трасс нь тусгай зөвшөөрөлтэй давхацсан эсэх, давхацсан хэсгийн чиглэлийг өөрчлөхөд хүрвэл ямар хэмжээний нэмэлт хөрөнгө шаардлагатай болох, эдгээр нь замын ашиглалтын зардалд хэрхэн нөлөөлөх гэх мэт асуудал"-ыг судалж байгаа талаар дурдсан болно. | 30% | |
| 160 | 23 | 35 | XX.4.2. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн нэгдлийн компаниудыг нүүрс, эрчим хүчний болон зэс, металл, дэд бүтцийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр хувааж, нэгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх, үйл ажиллагааны чиглэл нь хамаарах "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ зэрэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой улсын үйлдвэрийн газар, компанийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн нэгдэлд оруулан нэгдлийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоох асуудалд Засгийн газрын гишүүдийн саналыг тусгаж, тодорхой санал боловсруулан 30 хоногт багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн | Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 147 дугаар тогтоолоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Эрдэнэс Монгол ХХК-ийн шинэчилсэн зохион байгуулалтын бүтцийн талаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөн "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани, төслийн нэгжүүдийг группын зохион байгуулалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Энх-Амгалан), гүйцэтгэх захирал (О.Хулан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захирал (Х.Бадамсүрэн), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг) нарт; | | | |
| 161 | 24 | 36 | **2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2022-05-25**<br>**Дугаар 2022_30**<br>I.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах талаар санал боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК (О.Хулан) нарт даалгав | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах асуудлыг судалж байна. | 30% | |
| 162 | 24 | 37 | IX.. Улсын чанартай А0202 дугаартай Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын эвдрэлийг засахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав | Улсын чанартай А0202 дугаартай Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын эвдрэлийг засахад шаардагдах хөрөнгийн асуудлыг Эрдэнэс Тавантолгой ХК хариуцан ажиллах шийдвэрийг Засгийн газраас гаргасан. | 100% | |
| 163 | 25 | 38 | **2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр 6 дугаар тэмдэглэл**<br>**2022-01-26**<br>**Дугаар 2022_6**<br>IX.7. . Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээлийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Хөгжлийн банк, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн засаглалыг сайжруулах, активын бүтцийн өөрчлөлт хийх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээний санал боловсруулж, 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, | Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 147 дугаар тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Эрдэнэс Монгол ХХК-ийн шинэчилсэн зохион байгуулалтын бүтцийн талаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Уг хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу засаглалыг сайжруулах зорилгоор тус компанийн бүтэц, зохион байгуулалтын хэлбэрийг олон улсын жишигт нийцүүлэн групп компаний хэлбэрт оруулах хувилбарыг боловсруулж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | | | |
| 164 | 25 | 39 | IX.9. . Алтны төслүүдийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Алтны хэтийн төлөв бүхий талбайд улсын төсвийн хөрөнгөөр эрэл-үнэлгээний ажлыг гүйцэтгүүлж эрдэс баялгийн нөөц баялгийг нэмэгдүүлэх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохдоо холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 243 дугаар тогтоолоор 8.4 сая га талбайд сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн солбицол батлагдсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан "Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам" батлагдаж, 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/16 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон.<br>Дээрх хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Сонгон шалгаруулалтын 8 комисс байгуулагдсан. Үүнд:<br>1.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/80<br>2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/38<br>3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/62, "Комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай" 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/157<br>4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/204<br>5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/215<br>6. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/57<br>7. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/310 дугаар шийдвэр.<br>8. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/108 дугаар шийдвэр.<br><br>2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл 39 багцаар 2.8 сая гектар бүхий 459 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан. Үүнээс 1.3 сая гектар талбайд 276 хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар улсын төсөвт 80.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.<br>2022 оны 01 дүгээр сараас эхлэн нийт 2 багцаар СШ-62, СШ-63 дугаартай сонгон шалгаруулалтын 30 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарлав. Мөн сонгон шалгаруулалтын журмаар 408 талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг tender.gov.mn сайтаар зарлан явуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br><br>Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 110 дугаар тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 03/1108 дугаартай албан бичиг, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай" 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/50 дугаар тушаалыг тус тус үндэслэн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Богд уул нэртэй 14944.63 гектар талбайд ашигт малтмалын хайгуулын XV-022117 тоот тусгай зөвшөөрлийг "Эрдэнэс Монгол" ХХК-д олгов. | 100% | |
| 165 | 25 | 40 | IX.9.2. Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан тус хуулийн төсөлд ашигт малтмалын нөөц ашиглахтай холбогдолтой зарим татварыг орон нутгийн төсөвт шилжүүлэх зохицуулалт тусгахыг Сангийн | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй сумын, 20 хувийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд тус тус шилжүүлнэ." гэж тусгасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | | | |
| 166 | 25 | 41 | IX.9.4. Ашигт малтмалын томоохон орд тогтоогдсон бүс нутагт уул уурхайн цогц бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанаар 2022 оны 2 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт | Ашигт малтмалын томоохон орд тогтоогдсон бүс нутагт уул уурхайн цогц бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулахаар төлөвлөж байна. | 0% | |
| 167 | 25 | 42 | IX.14. . Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Тавантолгойн ордын нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төслийг боловсруулах болон түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр барилга угсралтын ажлыг гүйцэтгэх нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээдтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулах ажлыг нэн яаралтай зохион байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгав | "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй нээлттэй тендерийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр дахин зарласан бөгөөд тендерт "ENR” TOP 250 листэд бүртгэлтэй "Power contruction of China” Ltd, "Norinco international Cooperation” Ltd гэсэн хоёр компани материал ирүүлсэн. Тендер шалгаруулалтад "Norinco international Cooperation” Ltd-ийн ирүүлсэн тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрхийг олгож, 2022 оны 4 дүгээр сарын 14-нд EPC гэрээг байгуулсан бөгөөд одоогоор тус компанитай хамтран төслийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж байна. | 100% | |
| 168 | 25 | 43 | IX.19. . . Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжүүлэхэд шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахтай холбогдуулан барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж дуусгахад шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийн хуваарийг 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор нарийвчлан гаргахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал О.Батнасан нарт, хуваарийг баталж, санхүүжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд 2019 оноос өнөөг хүртэлх хугацаанд нийт 1,180,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2022 онд 24,184 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 87%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд 2022 оны 10 дугаар сард багтаан төмөр замыг иж бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт тус тус даалгав. | | | |
| 169 | 26 | 44 | **2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дүгээр тэмдэглэл** **2022-03-16** **Дугаар 2022_16** XYIII.14. . “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко Трэйдинг Хонгконг компанитай байгуулсан гэрээ, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хэрэгжүүлж байгаа хөгжлийн төслүүдийн санхүүжилт болон Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.4, 3.1.5-д заасан “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нүүрсний ил уурхайн олборлолтын өртгийг бууруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко Трэйдинг Хонгконг компани хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээг үргэлжүүлэх эсэх асуудлаар гэрээний гол нөхцөл, хэрэгжилт, үр өгөөж, үүсэж болзошгүй эрсдэлийг холбогдох хууль тогтоомж, гэрээний хүрээнд судлан үзэж, хэрхэх саналаа Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко компани хооронд байгуулсан нүүрсний гэрээг үргэлжлүүлэх, урьдчилгаа төлбөр авах асуудлыг танилцуулж, хуралдааны 18 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Улмаар Засгийн газрын шийдвэрийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко Трэйдинг Хонгконг компани хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээг үргэлжүүлэн байгуулсан. | 100% | |
| 170 | 26 | 45 | XYIII.14.2. Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг ашиглалтад орохоос өмнө 5 сая тонн, ашиглалтад орсны дараа 20 сая тонн нүүрс нийлүүлэх айлын талаас тавьсан нөхцөлийн талаар холбогдох эрх бүхий этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцох тохиолдолд танилцуулсны үндсэн дээр гэрээ байгуулах арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, “Эрдэнэс-Тавантолгой” | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг ашиглалтад орохоос өмнө 5 сая тонн, ашиглалтад орсны дараа 20 сая тонн нүүрс нийлүүлэх айлын талаас тавьсан нөхцөлийн талаар БНХАУ-ын Чайна энержи компанитай цахим уулзалт хийж, саналаа тус компанид 2022 оны 03 дугаар сарын 30, 4 дүгээр сарын 05-ны өдрүүдэд хүргүүлсэн бөгөөд тус компанийн зүгээс БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос чиглэл авахаар хүлээж байгаа талаар мэдэгдээд байна. Уг асуудлаар Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр танилцуулж, хуралдааны 18 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | | | |
| 171 | 26 | 46 | XYIII.14.3. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн ил уурхайн олборлолтын өртгийг бууруулах, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, шинэ сэргэлтийн бодлогод туссан хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх хувилбарт санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт. | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. | 100% | |
| | 57 | 106 | Уул уурхайн бодлогын дундаж: 81.2 хувь | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| САЛБАР ЧИГЛЭЛ: 4. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО | | | | | | |
| 4.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 172 | 1 | 1 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай**<br>**2009-12-17**<br>**Дугаар 2009.12.17**<br>6.1.4. Паркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих асуудлаар холбогдох дүрэм, журам, заавар батлаж мөрдүүлэх; (6.1.Засгийн газар паркийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4, 10.4, 11.1.1 дэх заалтуудыг үндэслэн Засгийн газрын 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журам, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл олгож үйлдвэрийн удирдлагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. | 100% | |
| 173 | 2 | 2 | **Хог хаягдлын тухай**<br>**/Шинэчилсэн найруулга/**<br>**2017-05-12**<br>**Дугаар 2017.05.12**<br>8.6.2.. 8.6.Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам батлаж, хэрэгжилтэд хяналт тавих; | Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/87 дугаар тушаалаар батлагдсан. Газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Гэрээлэгч компаниуд нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж тухайн төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн жил бүр тайлагнадаг. Тухайн төлөвлөгөөнд мөн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг тусгаж өгдөг. Тус төлөвлөгөөний гол зорилт нь газрын тос олборлох төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн хог хаягдлыг дахин ашиглах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, улмаар ашиглагдах боломжтой хаягдлыг боловсруулах цэгт хүргэх, хог хаягдлыг байгаль орчинд тархахаас сэргийлэх, хоргүй мөн аюулгүй хадгалах тээвэрлэх үйл ажиллагаанд чиглэсэн байдаг. | 100% | |
| 4.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 174 | 1 | 1 | **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай** | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7.3.-т “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2018-11-15**<br>**Дугаар 2018 №84**<br>2.9/. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх. | Монгол Улсын Засгийн газрын 2020.06.01-ний өдрийн 212 дугаар тогтоолоор ашигт малтмал хайх эрх олгогдсон ба тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020.08.26-ны өдрийн 308 дугаар шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших Хүрэнцав нэртэй 1704.51 гектар, Мухар хар толгой нэртэй 4313.57 гектар, Довжоот нэртэй 1393.37 гектар, Халзан нэртэй 453.89 гектар талбай нийт 7865.34 гектар талбай бүхий 4 тусгай зөвшөөрлийг олгосон бөгөөд эдгээр талбайг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төслийн тодорхой хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх зорилгоор Хүрэнцав нэртэй талбайд геологийн эрэл хайгуул,геофизикийн ажил гүйцэтгэх тендер зарлан ажиллаж байна. Компанийн эзэмшлийн хайгуулын тусгай зөвшөөрлийг барьцаалан зээл олгох боломжийн талаар арилжааны банкуудад хандсан бөгөөд арилжааны банкуудаас хайгуулын тусгай зөвшөөрөл барьцаалан зээл олгох боломжгүй тухай хариу ирүүлсэн.<br>БНКазУ-ын Сымбат инженеринг компанийн боловсруулсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулан ажиллаж “Ажлын хэсгийн дүгнэлт”-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Тэргүүн дэд захирал О.Хулангийн “Ажлын хэсгийн дүгнэлт хүргүүлэх тухай” 2021.12.09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр ирүүлсэн. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийн нарийвчлан судалж, төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, баталгаажуулж ирүүлэх тухай ХҮБГ-ын даргын 2022.01.06-ны өдрийн 07/42 дугаартай албан бичгээр Эрдэнэс алт ресурс ХХК-д, Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж, баталгаажуулах, Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2022 оны нэгдүгээр улиралд багтаан зохион байгуулахаар тус төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллах тухай УУХҮ-ийн сайдын 2022.01.06-ны өдрийн 01/43 дугаартай албан бичгийг Эрдэнэс Монгол ХХК-д хүргүүлсэн бөгөөд Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын даалгавар боловсруулах Ажлын хэсгийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн захирлын тушаалаар байгуулан ажиллаж байна. | | |
| 175 | 2 | 2 | **2003 №54. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай / 2003-12-11 / УИХ-ын тогтоол**<br>2. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орнууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай. | Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7.2.-т “Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна. Паркийн бүрэлдэхүүнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр болон исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэсийн үйлдвэр байгуулна.” гэсэн заалт тусгасан. Засгийн газрын 2019.06.05-ны өдрийн “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн уул уурхай, металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор барьж байгуулах боломжийг судлан санал боловсруулж Засгийн газарт танилцуулах үүрэг өгсөн. 2021.05.05-ны өдрийн Засгийн газрын 129 дүгээр тогтоолоор ҮТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгосон. УУХҮЯ болон тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 2021.06.22-ны өдөр | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 5/159-21 тоот ҮТП-ийн удирдлагатай байгуулах гэрээ байгуулсан ба гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | | |
| 4.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 4.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 4.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 4.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 176 | 1 | 1 | **Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2017-03-15 Дугаар 2017_88** 2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажлын явц, үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай. | Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Үндэсний хөгжлийн газрын даргад тус тус даалгасны дагуу “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал” болон “хөрөнгө оруулалтын гэрээний төсөл”-ийг боловсруулж хамран батлахаар СЯ болон ЭЗХЯ-нд хүргүүлсэн бөгөөд СЯ-наас хамтран батлах шаардлагагүй талаар хариу ирүүлсэн бол ЭЗХЯ-д хүргүүлсэн 2022.04.12-ны өдрийн 01/985 дугаартай албан бичигт хариу ирүүлээгүй байна.<br>Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд “Оюутогой”ХХК-иас хөрөнгө оруулж, хамтран ажиллах болон Хөрөнгө оруулалтын гэрээний 3.21-д заасан техникийн шалгуурууд болон үзүүлэлтүүдийг талаар саналаа ирүүлэх тухай УУХҮСайдын 2022.04.18-ны өдрийн 01/1085 дугаар албан бичгийг “Оюутолгой”ХХК-д хүргүүлсэн.<br>"Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” ажлыг эрчимжүүлэн, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх Ажлын хэсгийг “Эрдэнэс Оюутолгой” ХХК-иас байгуулж ажиллуулах хүрээнд Ажлын хэсэгт ажиллах ажилтнуудын нэрсийг УУХҮСайдын 2022.04.28-ны өдрийн 01/1233 дугаар албан бичгээр “Эрдэнэс Оюутолгой” ХХК-д, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах талаар тодорхой саналаа ирүүлэх тухай албан бичгийн УУХҮСайдын 2022.04.26-ны өдрийн 01/1179 дугаар албан бичгээр “Рио тинто Монгол” ХХК-д хүргүүлсний дагуу “Эрдэнэс Оюу толгой” ХХК-иас “Мэдээлэл хүсэх тухай”, Рио тинто компаниас харилцан санал солилцох тухай албан бичгүүдийг тус тус ирүүлээд байна.<br>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл”-ийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажлын хүрээнд АНУ-ын хөрөнгө оруулагчдад танилцуулах ажлыг зохион байгуулсан. | 70% | |
| 177 | 1 | 2 | 3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших асуудлыг зөвшөөрч, төрийн төлөөллийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай. | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших асуудлыг зөвшөөрч, төрийн төлөөллийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх талаар “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал” болон “хөрөнгө оруулалтын гэрээний төсөл”-д тусгасан. | 70% | |
| 178 | 2 | 3 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2021-05-05 Дугаар 2021_129** 2. Энэ тогтоолын 1-д заасан үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ China ENFI Engineering компанитай хамтран боловсруулсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл"-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэр", "Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр", "Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр" болон "Засвар, механикийн заводын өргөтгөл"-ийг тус тус "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | "Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр"-ийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан "Майнинг шорт лонг терм" ХХК-тай 2021.09.17-нд 6/006-21 тоот гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/91 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Эрдэнэтийн овоо зэс молибдены ордын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж байна. | | |
| 179 | 2 | 4 | 3. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газартай Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4-т заасны дагуу гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг хуульд заасан журмын дагуу төрийн өмчид бүртгэж авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4, 10.4, 11.1.1 дэх заалтуудыг үндэслэн Засгийн газрын 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журам, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл олгож үйлдвэрийн удирдлагуудтай гэрээ байгууллан ажиллаж байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хүрээнд Автозам: Зураг төслийн ажлыг Ихэр мөнх ХХК гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хугацаанд ажлыг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан<br>Төмөр зам: Зураг төслийн ажлыг Максимал ХХК гэрээ байгуулан ажиллаж гэрээний хугацаанд ажлыг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан<br>Усан хангамж, ариутгал татуургын систем: Зураг төслийн ажлыг Чанарын түншлэл ХХК гэрээ байгуулан гэрээний хугацаанд ажлыг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан Цахилгаан хангамжийн ТЭЗҮ: Боловсруулах ажлыг Бодит чадал ХХК гэрээ байгуулан гэрээний хугацаанд ажлыг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалт эхэлсэн. | 100% | |
| 4.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 4.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 180 | 1 | 1 | **2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 48 дугаар тэмдэглэл**<br>**2018-11-21**<br>**Дугаар 2018_48**<br>XII. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав: 2.1. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын ажлын явцыг Засгийн газарт танилцуулах; 2.2. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг зохих журмын дагуу дүгнэсний үндсэн дээр гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, газрыг зориулалтын бусаар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгжийн тусгай | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4, 10.4, 11.1.1 дэх заалтуудыг үндэслэн Засгийн газрын 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журам, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл олгож үйлдвэрийн удирдлагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна.<br><br>Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 171 дугаар тогтоолоор Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нутаг нийт 1217.4 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвшөөрлийг цуцлах, газрыг чөлөөлөх арга хэмжээ авах; 2.3. ашигт малтмал, газрын тосны салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг бусдад дамжуулан худалдаж байгаа эсэхийг шалгаж, тусгай зөвшөөрөл олголтыг цэгцлэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулах. | | | |
| 181 | 2 | 2 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>**2020-11-04**<br>**Дугаар 2020_58**<br>XYI.2. . Монгол Улсын Ерөнхий сайдын Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаатай танилцсан дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: Салбарын хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудлын хүрээнд Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэ онд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийсэн. Тус ажлын хэсэг нь 2021.01.27-ны өдрөөс 2021.06.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, Оросын холбооны улс, Казакстан зэрэг 10 гаруй улсын уул уурхайн хууль тогтоомжийг судлан үзэж танилцаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн өөрчлөлттэй холбоотой саналыг сонсох, нэгдсэн байр сууринд хүрэх зорилт тавин ажиллаж байна. Мөн Газрын тосны тухай болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгаа, хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төсөл, дагалдан гарах хуулийн төслийг тус тус боловсруулсан.<br><br>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж үнэлгээний тайланг боловсруулж байна. Цаашид уг судалгааны ажлын үр дүнг үндэслэн ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулна. | 30% | |
| 182 | 2 | 3 | XYI.2. 5. Өмнийн говийн бүсэд хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын төслийн хүрээнд шаардагдах усны хэрэгцээг хэрхэн хангах асуудлыг судлан тодорхой шийдлийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, холбогдох аймгийн Засаг дарга нарт; | “Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарыг тодорхойлж шийдвэрлүүлэхтэй холбогдуулан Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр болон кокс, эрчим хүчний үйлдвэрт шаардлагатай ус хангамжийг шийдвэрлэх боломжит хувилбарыг боловсруулан ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга (presentation) бэлтгэн ЗГ-ын 2022.01.26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. ЗГ-ын 2022.01.26-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл гарсан. | 100% | |
| 183 | 3 | 4 | **2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл** | “Эдийн Засаг Хөгжлийн Яам” /хуучнаар/ нь “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Дархан-Уул аймагт хэрэгжих Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2020-09-23**<br>**Дугаар 2020_51**<br>XII.1. 12. Дархан-Уул аймагт хэрэгжих уул уурхай, металлургын цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор гангийн үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, төсөлд шаардлагатай цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг судалж, үе шаттай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар газар ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох арга хэмжээ авахыг Дархан-Уул аймгийн Засаг дарга Н.Насанбат нарт | үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, концессын гэрээнд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А-268 дугаар тушаалаар байгуулсан ба тушаалын 2 дугаар хавсралтад заасан удирдамжийн дагуу Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл хийх ажлын хэсгийн төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А-314 дүгээр тушаалаар батлуулан ажилласан. Төслийн явцыг эрчимжүүлэх төлөвлөгөөний дагуу шинээр ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох “MCC-CERI” компаниар гүйцэтгүүлж, Монгол хэлнээ хөрвүүлэх, засвар хийх ажлыг Монгол Улсын “Кью Эм Си” ХХК гүйцэтгэж, 2021.09.30-ны өдрийн УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн, 2021.11.04-ний өдрийн УУХҮЯ, АМГТГ-ын ЭБМЗ-ийн СТР-2021-01 дугаар дүгнэлт гаргаж, АМГТГ-ын даргын 2021.12.01-ний өдрийн Т/220 дугаар тушаалаар ТЭЗҮ-ийг хүлээн авсан.<br>Мөн “Монгол ган цогцолбор I” төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 24 га газрыг Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн захирамжаар олгосон байна.<br>(“Эдийн Засаг Хөгжлийн Яам” /хуучнаар/ нь “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд байгуулсан “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор цуцалсантай холбоотойгоор төслийн ажил түр зогсоод байна) | | |
| 184 | 4 | 5 | **2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл**<br>**2022-03-16**<br>**Дугаар 2022_16**<br>XYIII.10. . “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 01 тоот албан даалгаврын 5.1-д заасны дагуу аж үйлдвэржилтийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулан Засгийн газрын хуралдаанд 2022 оны 4 дүгээр сард багтаан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт даалгав. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу “аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулж” Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮС-ын 2022.05.24-ний өдрийн 01/1500 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 70% | |
| 185 | 5 | 6 | **2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл**<br>**2021-03-03**<br>**Дугаар 2021_14**<br>XII.4. 6. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг дахин хянаад дүгнэлт гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | БНКазУ-ын Сымбат инженеринг компанийн боловсруулсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулан ажиллаж “Ажлын хэсгийн дүгнэлт”-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн Тэргүүн дэд захирал О.Хулангийн “Ажлын хэсгийн дүгнэлт хүргүүлэх тухай” 2021.12.09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр ирүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийн нарийвчлан судалж, төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, баталгаажуулж ирүүлэх тухай ХҮБГ-ын даргын 2022.01.06-ны өдрийн 07/42 дугаартай албан бичгээр “Эрдэнэс алт ресурс” ХХК-д, Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж, баталгаажуулах, Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2022 оны нэгдүгээр улиралд багтаан зохион байгуулахаар тус төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллах тухай УУХҮСайдын 2022.01.06-ны өдрийн 01/43 дугаартай албан бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн бөгөөд Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын даалгавар боловсруулах Ажлын хэсгийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн захирлын тушаалаар байгуулан ажиллаж байна. | | |
| 186 | 6 | 7 | **2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>**2022-04-13**<br>**Дугаар 2022_22**<br>I.. Тогтоолын төсөлд Дархан-Уул аймгийн Хонгор сумын Төмөр толгойн орд, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Төмөртэйн орд, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Хуст-Уулын төмрийн ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д шилжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав | Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь MV-013851 дугаартай Хуст-Уулын, MV-013319 дугаартай Төмөртэйн, MV-010738 дугаартай Төмөр толгойн төмрийн хүдрийн ордуудыг тус тус эзэмшиж байна. | 100% | |
| 187 | 7 | 8 | **2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл**<br>**2022-05-11**<br>**Дугаар 2022_28**<br>XX.3.1.8. Эрдэнэтийн гангийн үйлдвэр байгуулах төсөл (Барилгын арматурын үйлдвэрийн төсөл)-ийн гүйцэтгэлийг эрчимжүүлэх болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлийн өр төлбөрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэлийн XX.3.1.8. заалтыг хэрэгжүүлэх хүрээнд ХҮБГ-ын дарга Д.Даваадорж Хөгжлийн банкны бизнес, хөгжил хариуцсан дэд захирал З.Батырбект, Төслийн санхүүжилтын газрын захирал Б.Сайнзаяа нартай "Бэрэн групп" ХХК-ийн зээл, өр төлбөр, төслийн ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай нэмэлт санхүүжилт /зээл/-ийн асуудлаар удаа дараа уулзалт хийж, боломжит хувилбарыг супалж байна. 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар "Бэрэн групп" ХХК-ийн төслийг өр, зээл, нэмэлт зээлийн асуудлаар Хөгжлийн банк дээр хийж байгаа тооцоо судалгааны ажил эцэслэн шийдэгдээгүй байна. | 30% | |
| | 13 | 16 | Хүнд үйлдвэрийн бодлогын дундаж: 78.1 хувь | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| САЛБАР ЧИГЛЭЛ: 5. НИЙТЛЭГ АСУУДАЛ | | | | | | |
| 5.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 188 | 1 | 1 | **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай**<br>**2011-02-02**<br>**Дугаар 2011.02.02**<br>19.1.9. Төрийн захиргааны төв байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендэрийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр салбарт баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүнгийн тайлан, төрийн захиргааны төв болон харьяа байгууллагын хүйсийн тэнцвэрт байдлын 2021 оны судалгаа, яамны дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын 2021 оны мэдээг тус тус гарган 2022.01.14-ний өдрийн 01/104 дүгээр албан бичгээр Жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн. АМГТГ нь Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж байгаа сургагч багш бэлтгэх /"Жендэрийн ойлголт", "Хүйс ба жендэрийн ялгаа" "Жендэрийн үүрэг", "жендэрийн хэвшмэл ойголт" ,"Жендэрийн тэгш байдал" ,"Хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн статистик"/ гэсэн сэдэвтэй цахим сургалтад 5 дугаар сард хамрагдаж санал солилцсон. Байгууллагын дотоод журамд жендэрийн мэдрэмжтэй хуулийн заалтыг 2022 оны 2 дугаар сард нэмэлтээр оруулан батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. "Монголын Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл/ТНЗ/ ашгийн бус, нийгэмд үйлчлэх ТББ"-нь Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлт ба ажлын байрны ур чадварын шалгуурт жендэрийн үнэлгээ хийж байгаа тул байгууллагын нийт албан хаагчдын мэргэжил, боловсролын судалгааг хүйс насаар нь ангилж, хавсралт хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлэв. | 100% | |
| 189 | 2 | 2 | **Төрийн албаны тухай**<br>**/Шинэчилсэн найруулга/**<br>**2017-12-07**<br>**Дугаар 2019.01.01**<br>55.3.. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | УУХҮЯ-ны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2022.02.14-ний өдрийн тушаалаар батлуулсан. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугамаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 12 албан хаагчийг хамруулсан байна. Мөн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2022 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 24-ний А/44 тоот тушаалаар байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд: Буцалтгүй тусламж 6, гэр бүлийг дэмжих 1, чөлөө олгох 9, нийгмийн асуудал шийдвэрлэх 2, нийт 18 тушаал шийдвэр гарсан байна. | 100% | |
| 190 | 3 | 3 | **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай**<br>**/Шинэчилсэн найруулга/**<br>**2020-05-07**<br>**Дугаар 2020.07.01**<br>13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021.04.19-ний өдрийн А/81 дугаар Салбарын стратеги төлөвлөгөө батлах тухай тушаалаар Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөг баталж ЗГХЭГ-т хүргүүлсэн | 70% | |
| 191 | 3 | 4 | 21.5.. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (нийт 179 шийдвэрийн 269 зүйл, заалтын биелэлт 91.8%-тай дүгнэгдсэн), үнэлгээний дүнг яамны Удирдлагын зөвлөлийн 2021.02.14-ний өдрийн 03 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022.02.15-ны өдрийн "Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хүргүүлэх тухай" 01/351 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүргүүлсэн. Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд хэрэгжилтийг оруулж баталгаажуулсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 2022 оны I улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (нийт 52 шийдвэрийн 132 зүйл, заалтын биелэлт 81.7%-тай дүгнэгдсэн), 2022.05.24-ний өдөр Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулав.<br>-УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ (70.0%) хийж, Удирдлагын зөвлөлийн 2022.01.17-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022.01.18-ны өдрийн “ХШҮ-ний тайлан хүргүүлэх тухай” 01/131 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулсан.<br>-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (17 зорилт, 72 арга хэмжээ 77.7 хувьтай дүгнэгдсэн), Удирдлагын зөвлөлийн 2022.01.17-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, 2022.01.18-ны өдрийн 01/132 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулав.<br>-“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төслүүдийн 2021 хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (83.3%) хийж, Удирдлагын зөвлөлийн 2022.01.17-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, 2022.01.18-ны өдрийн 01/131 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>- Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, ХШҮ-ний тайланг Удирдлагын зөвлөлийн 2022.06.13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж 2022.06.16-ны өдрийн 03/1695 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв. Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулсан.<br>- УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт болон хөгжлийн төслүүдийн мэдээллийг холбогдох нэгжүүдээс гаргуулан нэгтгэж, 7 хоног бүрийн Баасан гарагт Эдийн засаг, хөгжлийн яаманд цахим шуудангаар хүргүүлсэн.<br>- Засгийн газрын 2021 оны “Төлөвлөгөө батлах тухай” 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг зохих хугацаанд sodbaigali_b@mof.gov.mn<br>цахим хаягаар Сангийн яаманд хүргүүлж ажиллав.<br>- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (78.6%), Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (87.2%) болон Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (86.0%)-ийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Удирдлагын зөвлөлийн 2022.03.30-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 2022.04.28-ны өдрийн 01/1225 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулсан.<br>- Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (70.5%) хийж 2022.02.21-ний өдрийн 01/437 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 192 | 4 | 5 | | - УУХҮЯ-ны 2021 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (90.3 % буюу 4.52 оноо) хийж, нэгдсэн тайланг Удирдлагын зөвлөлийн 2022.03.30-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022.03.31-ний өдрийн 01/823 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулсан.<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 21 аймгийн Засаг дарга нартай 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (71.4%) хийж, холбогдох санал, зөвлөмжийг боловсруулсан. Танилцуулгыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны үйл ажиллагааны тайланд нэгтгэж 2022.03.31-ний өдрийн 01/823 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулсан.<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын 2021 онд баталсан тушаалын биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (нийт 412 тушаалын биелэлт 98.4%-тай дүгнэгдсэн), тайланг боловсруулсан.<br>- УУХҮЯ-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (нийт 7 зорилгын 134 арга хэмжээний биелэлт 95.07%-тай дүгнэгдсэн), үнэлгээний дүнг яамны Удирдлагын зөвлөлийн 2022.03.30-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>- Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг холбогдох нэгжүүдээс гаргуулан нэгтгэж, 7 хоног бүрийн Баасан гарагт ЭЗХЯ-нд цахим шуудангаар хүргүүлсэн. | | |
| 192 | 4 | 5 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>**2021-12-17**<br>**Дугаар 2022.05.01**<br>8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор УУХҮЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар баталсан. Энэхүү тогтоолд тусгасан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгаж байна. | 100% | |
| 193 | 4 | 6 | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг | ЗГ-ын 2020 оны 105 дугаар тогтоолоор УУХҮЯ-ны чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг баталсан. Үүнд:<br>1. Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Санхүүгийн хэлтэстэй);<br>2. Геологийн бодлогын газар (Геологийн судалгаа, төлөвлөлтийн хэлтэстэй);<br>3. Уул уурхайн бодлогын газар (Техник, технологийн хэлтэстэй);<br>4. Хүнд үйлдвэрийн бодлогын газар (Дэд бүтцийн хэлтэстэй);<br>5. Газрын тосны бодлогын газар (Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэстэй);<br>6. Судалгаа, хөрөнгө оруулалтын газар (Статистик, судалгааны хэлтэстэй);<br>7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэстэй) буюу яамны орон тооны хязгаарыг 78 байхаар тогтоосон байна.<br>УУХҮЯ-ны хаяг:<br>• Монгол Улс, Улаанбаатар, нэгдсэн Үндэстний гудамж -5/2, Засгийн газрын II байр<br>• Утас: (51)-263506<br>• Факс: (11)-318169<br>• Цахим шуудан: info@mmhi.gov.mn<br>Иргэд, байгууллагаас захидал, өргөдөл хүлээн авах ажилтан Ш.Уранчимэг<br>Утас: 263506, 318169 /факс/, өрөөний дугаар 201 тоот.<br>Дээрх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 194 | 4 | 7 | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Салбарын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайлан, үйл ажиллагааны тайлан, дотоод аудитын төлөвлөгөөг сүүлийн 2 жилийн байдлаар хагас, бүтэн жилээр байгууллагын цахим хуудсанд тогтмол ил тод, нээлттэй байршуулж байна. | 100% | |
| 195 | 4 | 8 | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан | Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн тайланг байгууллагын цахим хуудсанд тогтмол ил тод, нээлттэй байршуулж байна. | 100% | |
| 196 | 4 | 9 | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн тайланг байгууллагын цахим хуудсанд тогтмол ил тод, нээлттэй байршуулж байна. | 100% | |
| 197 | 4 | 10 | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг байгууллагын цахим хуудсанд тогтмол ил тод, нээлттэй байршуулж байна. | 100% | |
| 198 | 4 | 11 | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | УУХҮЯ-ны бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр нь Монгол Улсын ЗГ-ын 2020 оны 105 дугаар тогтоолоор батлагдан гарч шинэ бүтцийн дагуу албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-ийн 2021 оны 167, 381 дүгээр тогтоолоор тус тус шинэчлэн баталсан. Албан тушаалтны нэр, албаны харилцах утасны дугаарыг байгууллагын цахим хуудсанд тогтмол ил тод, нээлттэй байршуулж байна. | 100% | |
| 199 | 4 | 12 | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | МУ-ын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс УУХҮЯ-нд хандан ирүүлсэн хүсэлт, санал, гомдлыг тухай бүр хүлээн авч, хариуг Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан шийдвэрлэж хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд иргэд, аж ахуйн нэгжүүдээс эхний хагас жилийн байдлаар нийт 148 өргөдөл гомдол,санал хүсэлтийг тус яаманд ирүүлсэн байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа.<br>Нийт 148-өргөдөл гомдол, санал, хүсэлт хүлээн авч 100% шийдвэрлэж хариу өгсөн.<br>Үүнд:<br>Гомдол - 56 (38%)<br>Хүсэлт – 55 (37 %)<br>Санал – 37(25%)<br>1-5 хоногт шийдвэрлэсэн-20 /12%/<br>6-10 хоногт шийдвэрлэсэн-40 /29%/<br>11-30 хоногт шийдвэрлэсэн-88 /59%/<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж байна. | 100% | |
| 200 | 4 | 13 | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Уул уурхай, хүнд үйлдвэр яам нь аж үйлдвэрийн салбар (уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн)-ын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импорт, улсын төсвийн орлого болон биет хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл) зэрэг мэдээллийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулан боловсруулж сар бүр www.mmhi.gov.mn цахим хуудас болон www.opendata.gov.mn цахим хуудсаар, мөн Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-аас Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн статистик мэдээ, Геологийн статистик мэдээ, Уул уурхайн статистик мэдээ, Газрын тосны статистик мэдээ, Хүнд үйлдвэрийн статистик мэдээ, АМГТГ-аас улсын төсвийн төвлөрүүлэх орлого болон төвлөрүүлсэн орлогын мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар боловсруулж сар бүр www.mrpam.gov.mn цахим хуудас болон www.opendata.gov.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, хүртээмжтэйгээр хүргэж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 201 | 4 | 14 | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | 2022 оны эхний хагас жилийн байдлаар УУХҮЯ-ны үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбоотой 140 мэдээ, мэдээллийг бэлтгэж яамны цахим хуудас болон сошиал хуудсаар нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг гэрээт болон гэрээт бус хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан. Салбарын болон яамны үйл ажиллагааны талаарх 140 онцлох мэдээ, статистик мэдээ 20, видео мэдээ 1. | 100% | |
| 202 | 4 | 15 | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл | Сул орон тооны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж байна. 2022 оны хагас жилийн байдлаар УУХҮЯ-нд 2 ажлын байр, харьяа агентлаг болох АМГТГ-т 5, ҮГА-нд 2 ажлын байранд тус тус сул орон тоо гарч холбогдох хууль, журмын дагуу Төрийн албаны зөвлөлтэй хамтран сонгон шалгаруулалтыг зарлан тусгай шалгалт зохион байгуулж сул ажлын байрыг нөхсөн. | 100% | |
| 203 | 4 | 16 | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж байна. ТЖАХ-ийг сонгон шалгаруулах журмын дагуу УУХҮЯ-нд 2 ажлын байр, харьяа агентлаг болох АМГТГ-т 5, ҮГА-нд 2 ажлын байранд тус тус сул орон тоо гарч холбогдох хууль, журмын дагуу Төрийн албаны зөвлөлтэй хамтран сонгон шалгаруулалтыг хийсэн | 100% | |
| 204 | 4 | 17 | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэлд Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын ЗГ-ын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж, мөрдлөг болгон ажиллаж байна. | 100% | |
| 205 | 4 | 18 | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөнд салбарын хүний нөөцийн стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхээр орсон. Үүний дагуу ГУУХҮГТСалбарын хүний нөөцийн стратегийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж салбарын хүний нөөцийн судалгааг эхлүүлэхээр ажиллаж байна. | 70% | |
| 206 | 4 | 19 | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Яамны хүний нөөцийн мэдээллийг www.mmhi.gov.mn вэб хуудсанд газар хэлтэс хариуцсан ажлын чиг үүргийг оруулсан. | 100% | |
| 207 | 4 | 20 | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам | Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу ТНБДаргын 2021.11.23-ны өдрийн А/92 дугаар тушаалаар УУХҮЯ-ны албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх эрх бүхий “Байгууллагын үнэлгээний баг”-ийг байгуулсан. Үнэлгээний баг 2021.12.15-ны өдөр хуралдан УУХҮЯ-ны нийт албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлж хурлаас гарсан нэгдсэн саналыг ТНБДаргад хүргүүлсэн. Үүний дагуу Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.10, 9.8, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, Сангийн сайдын 2012 оны 238 дугаар тушаалаар баталсан “Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”, Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсгийн 8.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТНБДаргын 2021.12.20-ны өдрийн А/110 тушаалаар мөнгөн урамшуулал олгох тухай тушаал батлагдан хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу УУХҮЯ-ны 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, УУХҮЯ-ны “Үнэлгээний баг байгуулах тухай” ТНБДаргын 2021.11.23-ны өдрийн А/92 дугаар тушаал, Үнэлгээний багийн хурлын тэмдэглэл, Үнэлгээний багийн хурлаас гарсан санал, УУХҮЯ-ны албан хаагчдын 2021 оны жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшингийн үнэлгээний товъёогийг УУХҮЯ-ны архивт хүлээлгэн өгсөн. УУХҮЯ-ны 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэж ХШҮДАГ-т 2022.01.04-ний өдөр хүргүүлсэн. / УУХҮЯ-ны 2021 оны нэгдсэн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тайланг УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/823 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн./<br>Дээрх журмын дагуу 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг ТЖАХ-даас 2022.06.13-ны өдөр гаргуулж байгууллагын Үнэлгээний багийн хурлыг 2022.06.17-ны өдөр зохион байгуулан үнэлгээг хийлгэн ТНБДаргаар 2022.06.20-ны өдөр баталгаажуулан УУХҮЯ-ны архивт хүлээлгэн өгсөн. УУХҮЯ-ны 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн 2022.06.27-ны өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж байна. | | |
| 208 | 4 | 21 | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Хуулийн хугацаанд мэдээллийг шилэн дансанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан<br>Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон танилцуулгатай танилцан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл болон экспортын төсөөлөл, бүтээгдэхүүний үнэ, 2022 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын хүлээгдэж буй гүйцэтгэл, 2023-2025 оны төсөөллийг холбогдох тайлбар, танилцуулгатайгаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022.04.01-ний өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 03/851 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Улсын Их хурлын 2022.05.27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн баталсан.<br>Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан УУХҮСайдын 2023 оны төсвийн хязгаарын санал, 2024-2025 оны төсөөллийг боловсруулан “2023 оны төсвийн хязгаарын санал, 2024-2025 оны төсөөлөл хүргүүлэх тухай” 01/1605 дугаартай албан бичгийг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн холбогдох тайлбар, үндэслэлээр хангаж ажилласан. | 100% | |
| 209 | 4 | 22 | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд мэдээллийг шилэн дансанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% | |
| 210 | 4 | 23 | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% | |
| 211 | 4 | 24 | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | АМГТГ-аас 2022 оны эхний хагас жилийн байдлаар Улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 33.7 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж байна. | 100% | |
| 212 | 4 | 25 | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр мэдээллийг сар бүр нийт 12 удаа УУХҮЯ-ны шилэн дансанд байршуулж байгаа болно. | 100% | |
| 213 | 4 | 26 | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр мэдээллийг УУХҮЯ-ны шилэн дансанд байршуулж байгаа болно. | 100% | |
| 214 | 4 | 27 | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр мэдээллийг УУХҮЯ-ны шилэн дансанд байршуулж байгаа болно. | 100% | |
| 215 | 4 | 28 | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө | 2022 оны эхний хагас жилийн байдлаар бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр гараагүй байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | | | |
| 216 | 4 | 29 | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Үндэсний аудитын газраас УУХҮСайдын багцын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн дагуу харъяа байгууллагуудын Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч нартай нэгдсэн уулзалт зохион байгуулж аудитаас өгсөн зөвлөмж, болон төрийн хэмнэлтийн хуулийн талаар танилцуулж, шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтийн талаар зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан. | 100% | |
| 217 | 4 | 30 | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны болон сайдын багцын 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, 2022 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Шилэн дансанд нийтэлсэн.<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах худалдан авах ажиллагаатай холбоотой тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан зэргийг багтаасан тайлан мэдээг сар бүр, аудит болон хяналт шалгалтын дүгнэлтийг тухай бүр Шилэн дансанд оруулж ажилласан. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны тайланг 3 удаа, хяналт шалгалт, аудитын дүгнэлтийг 2 удаа оруулсан. | 100% | |
| 218 | 4 | 31 | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт | Энэ оны эхний хагас жилийн байдлаар худалдан авах ажиллагаанд хийгдсэн дотоод аудитын дүгнэлт, Сангийн яамнаас 2021 оны худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ, нийт 2 мэдээллийг шилэн дансанд байршуулсан | 100% | |
| 219 | 4 | 32 | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулагдсан тендер шалгаруулалтад оролцогч байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс ирүүлсэн асуулт, нэмэлт тодруулгад уг цахим системийн “тодруулга” цэсээр дамжуулан шуурхай хариу өгөн, худалдан авах ажиллагаанд оролцож байгаа холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангаж ажилласан. Тайлант хугацаанд буюу 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 4 төрлийн тендер шалгаруулалттай холбоотой ирүүлсэн 9 тодруулга, асуулгад хариу өгсөн. | 100% | |
| 220 | 4 | 33 | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | 1. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Засгийн газар хоорондын Хөгжлийн хамтын ажиллагааны хэлэлцээ 2020.11.18-19-нд цахимаар зохион байгуулагдаж, УУХҮЯ-аас анх удаа ХБНГУ-ын талтай хамтран 2.0 сая еврогийн төсөвт өртөг бүхий техникийн туслалцааны төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон.<br>Хэлэлцээний дүнг 2020.12.30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээний мөрөөр авч хэрэгжүүлэх төлөвлөгөө баталсныг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.15-ны өдрийн 10-1/143 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан УУХҮЯ болон ХБНГУ-ын Засгийн газар хамтран хэрэгжүүлэх төслийн нэрийг “Эрдэс баялгийн удирдлагын зөвлөх үйлчилгээ” (Advisory Services for Mineral Resource Management) байхаар Сангийн яам болон ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай эцэслэн тохиролцсон.<br>Төсөл нь 2 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд Германы талаас Холбооны геологийн шинжлэх ухаан, байгалийн нөөцийн газар (BGR), Монголын талаас УУХҮЯ, АМГТГ, ҮГА хамтран хэрэгжүүлэхээр тогтсон. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар санал солилцох, төслийн хамтарсан гэрээг байгуулахтай холбогдуулан талуудын хамтарсан уулзалт, хурал 2022.04.26, 05.05, 05.12, 05.18, 05.20, 05.31, 06.16-ны өдрүүдэд нийт 7 удаа зохион байгуулагдсан.<br>Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Гео-шинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн (BGR)-тэй хамтран хэрэгжүүлэх “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” төслийн гэрээг эцэслэх хүрээнд саналыг хянан германы талд 2022.05.31-ний өдөр хүргүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төслийн хүрээнд (1) e-reporting, CMCS системүүдийн сайжруулалт; (2) яамны албан хаагчдын чадавхжуулах сургалт; (3) уул уурхайн салбарын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ; (4)Монголын ОУИТБС-ын нэгжийн тогтвортой байдлыг бэхжүүлэх; болон (5) Ашигт малтмалын баялаг, нөөцийн ангиллыг сонгосон 5 төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж боловсруулах, Mongolian Resource Code-ийн хэрэглээний тодорхой бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн үндсэн 5 чиглэлээр хамтран ажиллахаар тогтоод байна.<br>2. Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2019 оны 06 дугаар сараас эхлэн “Олборлох салбарын засаглалыг сайжруулах” (TA 9752 MON) төсөл хэрэгжиж байгаа бөгөөд тус төслийн хугацаа 2021 онд дуусна. Иймд төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор Дэлхийн банктай хамтран төслийг цаашид санхүүжүүлэх талаар боломжийг судлан хүсэлт тавьж ажилласан бөгөөд тус банкны Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах олон талт итгэлцлийн сангаас 500.0 мянган ам.долларыг 2022-2023 оны хооронд олгохоор болж 2022.05.02-ны өдөр TF0B8169 тоот тусламжийн гэрээнд талууд гарын үсэг зурсан.<br>Энэ хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон зардлыг шийдвэрлүүлэхээр сайдын 2022.05.30-ны өдрийн 01/1540 дугаар албан бичгийг, 2022 оны төсвийн санхүүжилтийн хуваарийн саналыг 2022.06.09-ний өдрийн 03/1638 дугаар албан бичгийг тус тус Сангийн яаманд хүргүүлээд байна.<br>3. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах Австрали Монголын эрдэс баялгийн хөтөлбөрт хамтран ажиллах саналыг 2022.04.26-ны өдрийн 03/1911 дүгээр албан бичгээр Адам Смит Интернэйшнл Монгол ХХК хүргүүлсэн. Хамтран ажиллах хүрээнд дараах төслийн саналыг боловсруулан хүргүүлсэн. Үүнд:<br>СХОГ-аас 2 санал: Байгаль орчин, нийгэм болон засаглалын шалгуур (ESG шалгуур)-ыг олон нийтэд сурталчлан таниулах, мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх төсөл болон Эрдэс баялгийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийн судалгааны төсөл; ГТБГ-аас 1 санал: Уламжлалт бус газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний төсөл; ГБГ-аас 3 санал: Ашигт малтмалын ордыг цогц байдлаар судлан дагалдах бүрдвэрийн нөөцийг тооцоолоход мөрдөх аргачилсан зөвлөмжийн төсөл боловсруулах, 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажил гүйцэтгэх заавар, түүнд тавигдах шаардлага боловсруулах болон Орон нутаг, олон нийтэд зориулсан нөлөөллийн аян, контент үйлдвэрлэх төсөл.<br>4. Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг/КОЙКА/-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2024 онд шинээр хэрэгжүүлэх төслийн саналд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай 2 төслийн саналыг 2022.04.29-ний өдрийн 03/1245 дугаар албан бичгээр СЯ-нд хүргүүлсэн.<br>5. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-аас 2023 онд Монгол Улсад хэрэгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай “Нүүрснээс устөрөгчийн гаргах боломжийн талаарх судалгааны төсөл” болон “Уул уурхайн салбарын хөдөлмөрийн эрүүл мэндийг тогтолцоог сайжруулах төсөл”-ийн саналуудыг Англи хэл дээр боловсруулан СЯ-нд хүргүүлсэн. | | |
| 221 | 4 | 34 | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны батлагдсан төсөвт нийт 193,2 сая төгрөгийг Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулахаар тусгагдсан бөгөөд уг батлагдсан төсөвт өртөгөөр хийж гүйцэтгүүлэх ажлын жагсаалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/97 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Нийт 7 багц бүхий тендер шалгаруулалтыг 2022 оны 02 дугаар сараас эхлүүлэн, нийт 4 удаа зарласан боловч амжилтгүй болсон. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тендер шалгаруулалтыг 3 дугаар улиралд багцын тоог бууруулан, нийт 5 багцтайгаар дахин зарлах тул судалгаа шинжилгээний ажлын тайлан жилийн эцэст гарна. | | |
| 222 | 4 | 35 | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон харьяа төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2021 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 2022.01.14-ний өдрийн 03/99 дугаартай албан бичгээр хүргүүлэн тайлагнасан.<br>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 онд дотоодын үйлдвэрүүдээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний тайланг нэгтгэн боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2022.02.09-ний 01/288 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын хэмжээнд 2021 онд нийт 74,5 тэрбум төгрөгийг дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулсан байна.<br>Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийг шилэн данс, байгууллагын цахим хуудас болон төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д тухай бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна | 100% | |
| 223 | 4 | 36 | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.2, 15.10.15, УУХҮСайдын 2018 оны А/105 дугаар “Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримтын жагсаалт батлах тухай” тушаал, Засгийн газрын 199 дугаар “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” тогтоолын 14.1.3. “төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг”, 14.1.5. “үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 800 000 төгрөг”-д тус тус заасны дагуу Төрийн сан банкны 100200700941 /ЧД.Улсын тэмдэгтийн хураамж/ тоот дансанд тушаасан баримтыг, материалын хамт ирүүлж, шаардлага хангасан аж ахуй нэгжид тухайн үйл ажиллагаатай нь холбоотойгоор Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх эсвэл Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг олгодог.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын дагуу бүх төрлийн шатахуун болон шингэрүүлсэн шатдаг хийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус яамнаас олгодог. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтийг 2022 оны 3 дугаар сараас эхлэн www.license.mn цахим системээр хүлээн авч шуурхай шийдвэрлэж байна. Тус яамны цахим хуудас болон тусгай зөвшөөрөл шийдвэрлэлтийн www.license.mn хуудсуудад тусгай зөвшөөрлийн төрөл, шийдвэрлэх журам, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, тусгай зөвшөөрөлтэй ААН, байгууллагын мэдээллийг тухай бүр шинэчлэн нийтэлж, олон нийтэд мэдээлэл хүргэж байна<br>Тэсэрч, дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасны дагуу Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрлийг 76 аж ахуйн нэгж 86 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн төлбөр 3.250.000 төгрөг байна. | 100% | |
| 224 | 4 | 37 | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл | Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажилласан. 2022.01.19-ний өдрөөс 2022.06.15-ны өдрийн хооронд Сайдын эрхлэх асуудлын хүрээний геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хуулийн этгээдэд нийт 51 тусгай зөвшөөрлийг шинээр болон хугацаа сунган олгосон бөгөөд холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | | | |
| 225 | 4 | 38 | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийн хэлэлцүүлгийг салбарын мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгжүүдийн дунд 2022 оны 5 дугаар сард тус бүр 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Тэсэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын төсөлд 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдөр санал авахаар тус яамны цахим хуудсанд тус тус байршуулсан. | 100% | |
| 226 | 4 | 39 | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | Эзэмшиж байгаа оюуны өмч байхгүй болно. | /-/ | |
| 227 | 4 | 40 | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл | 2024 онд Төрийн захиргааны байгууллагуудыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигтийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх тухай тогтоолын төсөлд холбогдох саналыг боловсруулан хүргүүлсэн. | 100% | |
| 228 | 4 | 41 | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд өөрийн эзэмшлийн ямар нэгэн барилга байгууламж болон газар байхгүй болно. | /-/ | |
| 229 | 4 | 42 | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг | Байгууллагын нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэлийн мэдээллийг www.mmhi.gov.mn цахим хуудсанд оруулсан. | 100% | |
| 230 | 4 | 43 | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | Байгууллагын удирдлагын мэдээллийг www.mmhi.gov.mn цахим хуудсанд оруулсан. | 100% | |
| 231 | 4 | 44 | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | ТӨБЗГазрын 2022.05.20-ны өдрийн А 1/999 дугаар албан бичгийн дагуу яамны балансад бүртгэлтэй нийт 4 ширхэг тээврийн хэрэгслээс ”Тоёота лексус-570” маркийн 0131 УНҮ, 2300 УБЯ улсын дугаартай 2 ширхэг Жип ангиллын машин, “Соната хьюндэй-VII” маркийн 0384 УБҮ дугаартай суудлын автомашинуудыг актаар хүлээлгэн өгсөн болно. | 70% | |
| 232 | 4 | 45 | 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл | Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь төслийн Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг Байгаль орчны үнэлгээний тухай хуульд заасны дагуу төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ зэрэг баримт бичигт тусгаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт “технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно” гэж заасны дагуу “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлал”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Журам, аргачлал батлах тухай” 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/135 / А/200 дугаар хамтарсан тушаалаар баталж, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэгт заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ажиллаж байна. Тус журам аргачлал батлагдсанаар хүнд болон хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн технологийн түвшнийг үнэлэх боломж бүрдэх юм.<br>Байгальд орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх Байгаль орчинд ээлтэй, нийгмийн үр ашигтай тээвэрлэлтийн нөхцөл бүрдүүлэх зорилгоор Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул 19 дүгээр талбайн үйлдвэрлэлийн баазаас Баянхошуу-Өвдөгийн хилийн боомт чиглэлийн 210,7 км хатуу хучилттай авто замыг 4 багцад хуваан барилгын ажлыг гүйцэтгэсэн ба эхний 2 багцын нийт 104 км автозамын барилгын ажлыг БНХАУ-ын Дачин Ойлфийлд зам гүүрийн компани гүйцэтгэж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. 3, 4 дүгээр багцын барилгын ажил гүйцэтгэгчээр Монгол улсын “Арж капитал” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажилласан. Тус хатуу хучилттай авто замыг 2016 онд бүрэн ашиглалтад оруулсан ба тус замаар гарын тосны экпортын тээвэрлэлт гүйцэтгэж байна. Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээт 21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт чиглэлийн хатуу хучилттай замд нийлэх газрын тос тээвэрлэлтийн 58 км хатуу хучилттай автозам барих төсвийг “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн 2018 оны нэмэлт ажлын төлөвлөгөө, төсөв болон 2019 оны ажлын төлөвлөгөө, төсөвт тусгаж баталсан. Өнөөгийн байдлаар тус замын барилгын ажил хийгдэж байгаа ба 2021 оны эцэст замын барилгын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>Газрын тосны эх үүсвэрийн хайгуул, олборлолтод олон улсын байгаль орчны шаардлагад нийцсэн стандарт нэвтэрсэн байна. Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян газрын тосны ордуудын олборлолтын үйл ажиллагаанд ASME (Америкийн механик инженерүүдийн нийгэмлэг), API (Америкийн газрын тосны хүрээлэн), GB (БНХАУ-ын үндэсний стандарт), SY/T (БНХАУ-ын газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн стандарт) зэрэг олон улсын байгаль орчны шаардлагад нийцсэн стандартуудыг ашиглаж байгаа ба гэрээлэгч компаниуд ордын ашиглалтын үйл ажиллагааны хүрээ нэмэгдэж байгаатай холбогдуулан дараах стандартуудыг шинээр нэвтрүүлсэн болно | | |
| 233 | 4 | 46 | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт байхгүй болно. | /-/ | |
| 234 | 4 | 47 | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл | УУХҮЯ-наас олгож буй тусгай зөвшөөрлийн мэдээлэл, ЭБМЗ-ийн үйл ажиллагааны мэдээлэл, АМГТГ-аас олгож буй ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, хайгуулын болон уулын ажлын тайлан, төлөвлөгөөний мэдээлэл, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл зэргийг ашиглаж буй системүүдээс гарган авч нийтэд нээлттэйгээр мэдээлж байна. (https://mpc.mmhi.gov.mn/, https://license.mn/, https://cmcs.mrpam.gov.mn/cmcs) | 100% | |
| 235 | 4 | 48 | 8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугамаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 12 албан хаагчийг | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамруулсан бөгөөд холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мэдээлэл хариуцагчийн зардлаар 2022 онд гадаад дотоодын их дээд сургуульд суралцагч яваагүй болно. | | |
| 236 | 4 | 49 | 8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасныаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлпийг www.mmhi.gov.mn цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр байршуулж байна. | 100% | |
| 237 | 5 | 50 | **Олон улсын гэрээний тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-01 Дугаар 2017.01.01** 24.2.. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох байгууллагатай хамтран биелүүлнэ. | Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнүүдийн тус яамны эрхлэх асуудлын болон хамтран хэрэгжүүлэх асуудлын хүрээнд тухайн гэрээний үүргийг биелүүлэх чиглэлээр бусад яам, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал:<br>-Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцийг хэрэгжүүлэх, тайланг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, ХНХЯ-руу тухай бүр тайланг хүргүүлэн ажиллаж байна.<br>-Мөн хүний эрх, хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийг алагчлах хэлбэрийг устгах тухай конвенциудын хэрэгжилттэй холбоотой, зохион байгуулалтын ажил, тайлан боловсруулах, хэлэлцүүлэх ажлын хэсэгт тус яамнаас хариуцсан ажилтнууд орж ажиллаж байна. | 100% | |
| 238 | 5 | 51 | 24.5.. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаад тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина | Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаа талаар шууд хяналт тавих үүргийг одоогоор тус яамнаас хүлээгээгүй байна.<br>Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам"-ын 2 дугаар хавсралтын дагуу нэгдэн орсон гэрээнүүдийг тайланг хариуцан боловсруулах яамдуудын жагсаалт гарсан. | /-/ | |
| 239 | 5 | 52 | 25.1.. Монгол Улс олон улсын гэрээний дагуу тухайн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол тайланг уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох төрийн байгууллагатай хамтран боловсруулна | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолоор Монгол Улсын олон талт Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах байгууллагуудыг хавсралтаар баталсан. Олон улсын олон талт гэрээний жагсаалтад байгаа Уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар Конвенцийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг УУХҮЯ-наас тухай бүр гаргаж ХНХЯ-д хүргүүлэв. | 100% | |
| 240 | 5 | 53 | 25.3.. Энэ зүйлийн 25.1, 25.2-т заасны дагуу боловсруулсан тайланг төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /25.1.Монгол Улс олон улсын гэрээний дагуу тухайн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол тайланг уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох төрийн байгууллагатай хамтран боловсруулна./ | Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцид нэгдэн орох тухай хуулийн төслийг Уул уурхайн яам/хуучнаар/ 2015 онд Монгол Улсын Их хуралд өргөн барьж, батлуулснаар нэгдэн орсон ба 2016 оноос мөрдөж эхэлсэн. Уг конвенцийн тайланг хуваарийн дагуу 2017, 2021 онд талуудыг оролцуулсан ажлын хэсэг байгуулан боловсруулж үндсэн хариуцагч болох ХНХЯ-руу хүргүүлэн ажилласан. Хуваарийн дагуу дараагийн тайланг 2026 онд хүргүүлэхээр ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | /25.2.Тайлан боловсруулах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага тайланг түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, шаардлагатай хэлээр орчуулах үүрэгтэй./ | | | |
| 241 | 5 | 54 | 34.2.. Энэ зүйлийн 34.1-д заасан хуулийн төслийг тухайн олон улсын гэрээг хариуцан байгуулж байгаа төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу боловсруулах үүрэгтэй.<br>/34.1.Олон улсын гэрээ байгуулснаар, түүнд нэгдэн орсноор, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хүчин төгөлдөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах, батлах саналыг өргөн мэдүүлэхдээ тухайн хуулийн төслийг хамт өргөн мэдүүлнэ./ | Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенцийг тус яам хариуцан байгуулсан ба уг конвенцийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн тухайн асуудлаар тусгасан зохицуулалтуудыг боловсронгуй болгох саналыг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.<br>Тухайлбал: Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд уурхайн ажилчдын аюулгүй байдалд нөлөөлөхүйц асуудлуудын талаар болон цалин хөдөлмөрийн хөлсний талаарх асуудлаар санал боловсруулан ХНХЯ-нд хүргүүлсэн.<br>-Мөн уг конвенцод дурьдсан хяналтын тогтолцоооны талаар Төрийн хяналт шалгалтын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлт, Эрүүл мэндийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулахаар холбогдох судалгаануудыг хийж байна.<br>Тус яамны хувьд 2022 онд шинээр Олон улсын гэрээнд нэгдэн орох тухай хуулийн төсөл хэлэлцүүлсэн асуудал байхгүй, Олон улсын гэрээний тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан хуулийн төслийг боловсруулах шаардлага гараагүй болно. | /-/ | |
| 5.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 242 | 1 | 1 | **Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>**2019-06-06**<br>**Дугаар 2019 №62**<br>1.7/г/. уул уурхайн салбарт ажиллагсдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Уул уурхайн салбарт ажиллагсдын осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд 2017 оноос яамны дэргэд салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна. Тус хорооноос уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийг сурталчлах, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал/ХЭМАБ/-ын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, холбогдох дүрэм, журам, стандартыг сайжруулах чиглэлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв болон Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд салбар хорооноос дараахь гол ажлуудыг хийж хэрэгжүүлж байна Үүнд;<br>-Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 176-р конвенцид нэгдэн орж, тус конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагууд /ХНХЯ, МХЕГ, МАОЭНХ, МҮЭ, салбарын аж ахуйн нэгж байгууллагууд/-тай хамтран ажиллаж байна. Конвенцоор хүлээсэн үүргийн дагуу хэрэгжилтийн тайланг 2 удаа Олон Улсын хөдөлмөрийн байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.<br>-2018-2020 онд уул уурхайн салбарт мөрдөгдөж буй аюулгүй ажиллагааны дүрмүүдийг орчин үеийн техник, технологийн дэвшилтэй уялдуулан хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулан захиргааны актад бүртгүүлээд байна<br>-2019-2022 онд уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүд, ХАБЭА-н ажилтнуудад “ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо, шаардлага MNS ISO 45001:2018” стандартыг хэрэгжүүлэх сургалтыг нийт 5 удаа зохион байгуулсан.<br>-Хөдөлмөрийн эрүүл мэндийн талаарх ойлголтыг түгээх, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах, үзлэг оношилгооны тогтолцоог сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.03.03-ны өдрийн А/39 тушаалаар батлагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны хурал 2022.04.06-ны өдрийн 14:00 цагт зохион байгуулагдсан ба үйл ажиллагааны төлөвлөгөөнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагаандаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2 дугаар заалтын хэрэгжилтийг тодорхойлох хамтарсан томилолт хийх тухай саналыг өгсөн.<br>“Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын Удирдлагын тогтолцоо, шаардлага MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх арга зүй” цуврал сургалтыг салбар хорооны гишүүдэд болон аж ахуйн нэгжүүдийн дээд шатны удирдлагууд, Удирдах зөвлөлийн гишүүд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудад зохион байгуулах ажлын хүрээнд 2022.04.11-ний өдөр үйл ажиллагааны төлөвлөгөө ирүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 814 цахим хаяг руу захидал илгээж, утсаар холбогдон, 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн сургалтын ирцийг хангахад хамтран ажилласан.<br>“Аюулгүй байдал, эрүүл мэндийн соёлыг хамтдаа төлөвшүүлье” сарын аянг хамтран зохион байгуулж, тайланг УУХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргад 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1/3058 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн 2021 оны ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан 68 тайлангийн мэдээллийг нэгдсэн санд нэгтгэсэн | | |
| 243 | 2 | 2 | **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>**2020-12-04**<br>**Дугаар 2020 №39**<br>1.1/. 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:<br>1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх; | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар АМГТГ-т Урсгал зардлаар 5,196.6 сая төгрөг батлагдсанаас Засгийн газрын 43, 93 дугаар тогтоолын дагуу төсөвт зохицуулалт хийгдэж 5,090.2 сая төгрөг болж буурч батлагдсан. Үүнээс 2021 оны жилийн эцсийн байдлаар урсгал зардал 5,015.03 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 265,400.0 сая төгрөг батлагдсан бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 268,696.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. 2021 оны батлагдсан төсвийн дагуу төсвийн сар, улирлын хуваарийн саналыг УУХҮЯ-нд хүргүүлж батлуулсан бөгөөд батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу зарцуулалтыг хийж гүйцэтгэн ажилласан | 100% | |
| 244 | 2 | 3 | 1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах; | Яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран Сайдын багцын харьяа байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч нартай уулзах уулзалтыг зохион байгуулсан. Энэ уулзалтаар 2021 оны нэгдсэн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтэд анхаарч ажиллах болон Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн ханган ажиллах талаар мэдээлэл өгч мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.<br>УУХҮСайдын харьяа байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Засгийн газрын нэгдсэн тайлангийн цахим программд шивж оруулан тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулан баталгаажуулсан.<br>УУХҮСайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн 2021 оны жилийн эцсийн тайланг гаргаж удирдлагад танилцуулан аудит хийлгэхээр 2022.04.05-ны өдрийн 01/896 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br>УУХҮСайдаас 2021 оны жилийн эцсийн тайланд аудит хийлгүүлэхээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн албан бичгийн дагуу аудит хийхэд шаардлагатай тайлбар, үндэслэлээр ханган, дүгнэлт гаргуулсан. Аудитлагдсан тайланг Засгийн газрын нэгдсэн тайланд нэгтгүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөмж, тайлбар, үндэслэлээр ханган ажилласан.<br>Үндэсний аудитын газраас 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 07/473 дугаартай албан бичгээр АМГТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй дүгнэлт” авсан бөгөөд 2020 оны Санхүүгийн байдал, үр | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүнгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийг “Үндэсний аудит”-ын газарт 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 1/2887, 2021 оны 9 дүгээр сарын 24-ний 1/4271 дугаартай албан бичгээр “УУХҮЯ”-нд 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1/5308 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. | | |
| 5.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 245 | 1 | 1 | **“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ** 3.20.. Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. | *Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/36 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллахыг салбарын 3 тал хэлэлцээрт тусгасан.<br>-Салбарын 2021-2022 оны 3 талт хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн тухай хуулийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу 2021.07.01-ний өдөр бүртгэж авсан. Аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж хэрэгжилтийг жил бүр дүгнэж байна.<br>“Хүний эрх ,хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” УУХҮСайдын 2018 оны 6 дугаар албан даалгавар гарсан. Албан даалгаврыг аймаг нийслэлийн засаг дарга нар, байгууллага аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>-УУХҮСайд болон Аймаг нийслэлийн засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжилтийг хангаж ажиллах, журмын хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахаар тусгасан. Энэхүү заалт нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам (ЗГ-ын 2017 оны 151 дүгээр тогтоол) 3.2.8-д заасан олборлолтын талбайд 18 нас хүрээгүй иргэнийг оруулахгүй байх гэж тусгасан байдаг. Насанд хүрээгүй хүнийг хөдөлмөр эрхлүүлсэн зөрчил 2022 оны эхний хагас жилийн байдлаар гараагүй байна. | 100% | |
| 246 | 2 | 2 | **Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл 2018-05-01 Дугаар 2018 №07 ТББХ** 5.. Олон удаагийн шүүхийн шийдвэртэй яамдууд хүний нөөцийн бодлого алдагдсан асуудлыг засаж, сайжруулах арга хэмжээг нэн даруй авах | 2022 оны хагас жилийн байдлаар Шүүхийн шийдвэртэй асуудал Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд байхгүй болно. | 100% | |
| 247 | 3 | 3 | **Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ** 2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах; | ЗГХЭГ-аас төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталыг ашиглалтад оруулсантай холбогдуулан www.opendata.gov.mn цахим хуудсанд эрдэс баялгийн салбарын статистик мэдээллийг сар бүр тогтмол байршуулж байна. Энэ хүрээнд дараах мэдээллийг холбогдох эх үүсвэрээс авч, цахим санд оруулж байна. Үүнд: геологи, уул уурхай, газрын тосны салбараас Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээлэл, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын голлох бүтээгдэхүүний экспорт болон импортын мэдээлэл, кадастрын бүртгэлийн мэдээлэл, геологи, хайгуулын мэдээлэл, нүүрс, газрын тос болон хүнд үйлдвэрийн салбарын статистик мэдээлэл, Ашигт малтмал, газрын тосны газрын Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээлэл зэрэг багтаж байна. Мөн түүнчлэн салбарын хэмжээнд статистик мэдээллийн бэлэн байдлыг сайжруулах зорилгоор УУХҮСайдын 2020.12.07-ны өдрийн А-311 дүгээр тушаалын дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас холбогдох мэдээ, тайланг хүлээн авч ажиллаж байна. Мэдээллийг тухай бүр байршуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын болон яамны мэдээллийн товхимол, танилцуулгын агуулга, чанарыг сайжруулж, мэдээллийн шуурхай байдлыг ханган ажиллаж байна. | 100% | |
| 5.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 248 | 1 | 1 | **Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай**<br>**2018-05-23**<br>**Дугаар 2018_46**<br>3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Монгол бичгийн өвийг хамгаалах, судлах, сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд тус яам нь байгууллагын хаягыг крилл болон монгол үндэсний бичгээр хослуулан бичиж байршуулсан. Мөн салбарын хэмжээнд зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд ном товхимол, сэтгүүл гарын авлага зэрэгт үндэсний бичиг, кирилл бичгийг хослуулан хэвлүүлж хэрэглэж байна. Ажилтан албан хаагчдыг монгол үндэсний бичиг сурах чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд монгол үндэсний сурах бичиг ажлын хэрэглээнд нь өгсөн болно. | 100% | |
| 249 | 2 | 2 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2022-04-05**<br>**Дугаар 2022_43**<br>1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох; | Ковид-19 цар тахлын улмаас Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалт зохион байгуулаагүй болно. | 100% | |
| 250 | 2 | 3 | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | Хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасны дагуу ажилтан албан хаагчдад архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсан болно.. | 100% | |
| 5.д. УАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | |
| 251 | 1 | 1 | **Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай**<br>**2010-03-18**<br>**Дугаар 2010_10/09**<br>2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйдвэр, үйлчилгээ, хүн амын суурьшлын шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, | Жил бүрийн гуравдугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагт Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохиогоор ажилладаг уламжлалтай. Үүний дагуу 2022.03.24-ний Пүрэв гарагт цар тахлын нөхцөл байдлын улмаас дуут дохиогоор аюулгүйн цэгт цуглах дадлага сургууль хийгдэхгүй тул албан хаагчид ажлын байрандаа байж, гамшгийн үеийн дуут дохио дуугарсан үед авах арга хэмжээний талаарх мэдлэгээ бататгаж, ОБЕГ-ын албан хаагчидтай хамтран газар хөдлөлтийн талаарх сургалт зохион байгуулж, зөвлөгөө, зөвлөмжийг байгууллагын дотоод сүлжээ able программаар албан хаагчдад сурталчлан таниулж ажилласан. | 100% | |
| 5.е. Засгийн газрын тогтоол | | | | | |
| 252 | 1 | 1 | **Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** | 1.2 2023 оны төсвийн хязгаарын саналыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2022-05-25**<br>**Дугаар 2022_203**<br>1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;<br>1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх | эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийж, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг төлөвлөн 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1557 дугаартай албан бичгээр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны төсвийн хязгаарын санал, 2024-2025 оны төсөөллийг боловсруулан 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1605 дугаартай албан бичгээр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.<br>1.3 Төсвийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хууль, зөвлөгөөн болон сургалт, семинаруудыг цахимаар зохион байгуулж байна.<br>1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахгүй бөгөөд энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулаагүй болно. | | |
| 253 | 2 | 2 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>**2022-05-25**<br>**Дугаар 2022_204**<br>1.Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн | Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн шууд захирагч нарын төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 03/1439 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Бүртгэлтэй автомашиныг ТӨБЗГ-аас гаргасан хуваарийн дагуу хүлээлгэн өгсөн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай | | | |
| 254 | 2 | 3 | 9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | ТӨБЗГазрын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А 1/999 дугаартай албан бичгийн дагуу яамны балансад бүртгэлтэй нийт 4 ширхэг тээврийн хэрэгслээс :"Тоёота лексус-570" маркийн 0131 УНҮ, 2300 УБЯ улсын дугаартай 2 ширхэг Жип ангиллын машин, "Соната хьюндэй-VII" маркийн 0384 УБҮ дугаартай суудлын автомашинуудыг актаар хүлээлгэн өгсөн болно. АМГТГ: Монгол орны хэмжээнд геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжуудад заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд байгууллагын ажлын онцлогоос хамааран албан томилолтоор жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах шаардлагатай байгаа тул орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | |
| 255 | 3 | 4 | **"Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл" батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58** 3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл"-д хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах асуудлыг судалж, хамтран ажиллах албан хаагчийн нэр авахаар ХНХЯ-аас 2021.12.15-ны өдрийн 01/3340 дугаар албан бичгийг ирүүлсэн. Тус ажлыг хариуцан, хамтран ажиллах албан хаагчаар УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын Техник технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Хулангийн нэрийг 2021.12.21-ний өдрийн 01/3150 дугаартай албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн. | 30% | |
| 256 | 4 | 5 | **Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139** 3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай | УУХҮЯ-ны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугмаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 12 албан хаагчийг хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2022 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | 100% | |
| 257 | 5 | 6 | **"Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийг шинэчлэн батлах тухай 2022-04-06 Дугаар 2022_147** | Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 147 дугаар тогтоолоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Эрдэнэс Монгол ХХК-ийн шинэчилсэн зохион байгуулалтын бүтцийн талаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Монгол Улсын иргэн бүрт эзэмшүүлсэн давуу эрхийн хувьцааны бүртгэлийг баталгаажуулах арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай | танилцуулсан. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани, төслийн нэгжүүдийг группийн зохион байгуулалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | | |
| 258 | 6 | 7 | **Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-01-05 Дугаар 2022_7** 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Байгууллагын цахим хуудас дээр монгол бичгээр нийтлэх дэд програмыг хөгжүүлэх компани болон үнийн саналыг судалж байна. | 30% | |
| 259 | 7 | 8 | **Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай 2021-10-13 Дугаар 2021_314** Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор энэ тогтоолын хавсралтад заасан Засгийн газрын тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. 2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан салбар, орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг 2021 оны 12 дугаар сард багтаан авч | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт мөрдөгдөж байсан 29 зорилттой 8 тогтоолд ЗГ-ын 206 дугаар тогтоолын дагуу үр дүнд суурилсан эцсийн үнэлгээг хийж удирдлагад танилцуулав. ЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон 8 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн эцсийн үнэлгээ 59,2 хувьтай дүгнэгдсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | | | |
| 260 | 8 | 9 | **Төмөр замын шугамын чиг тогтоох тухай**<br>**2022-01-19**<br>**Дугаар 2022_51**<br>3. Батлагдсан чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон давхацсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт, төмөр замын чигтэй давхацсан нутаг дэвсгэрт газар чөлөөлөхөд шаардагдах хөрөнгийг төслийн нийт санхүүжилтэд оруулан тооцохыг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Удаанжаргалд тус тус даалгасугай | - Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар 09-ний өдрийн 109 дүгээр тогтоол гарч Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Энэхүү төмөр замын чиг нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Оорцог толгой нэртэй XV-021806 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайгаар дайран өнгөрч байгаа ба уг тусгай зөвшөөрлийн талбайгаас Төрийн мэдэлд буцаан авах талаар Геологи, уул уурхайн кадастрын хэлтсээс 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр “Аж эксплорейшн” ХХК-тай сонсох ажиллагааг явуулав.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар 09-ний өдрийн 109 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 238 дугаар шийдвэрээр “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын шугамын чигийн дагуу давхцалтай Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Оорцог толгой нэртэй XV-021806 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайгаас 1110.13 гектар талбайг хэсэгчлэн буцаан авсныг бүртгэв. | 70% | |
| 261 | 9 | 10 | **Төмөр замын шугамын чиг тогтоох тухай**<br>**2022-03-09**<br>**Дугаар 2022_109**<br>3. Энэ тогтоолын хавсралтаар баталсан төмөр замын шугамын чигийн дагуу аливаа зөвшөөрөл олгохгүй байх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал нарт даалгасугай. | Зам, тээврийн хөгжлийн яамны төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 8/1656 дугаартай албан бичиг явуулж Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 километр төмөр замын бүтээн байгуулалтын замын трассын тоон мэдээллийг /shape file/ хүлээн авсан болно.<br>Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 109 дүгээр тогтоолын дагуу 2022 оны 04 дүгээр сард геологи уул уурхайн компьютержсон кадастрын системд хориглосон хязгаарласан талбайд нэмж бүртгэн оруулсан. | 70% | |
| 262 | 10 | 11 | **Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай**<br>**2021-10-13**<br>**Дугаар 2021_315**<br>3. Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн харьяа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллах чиглэлийн дагуу сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 04/2643 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Мөн салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлж байгаа байгууллагуудад тооллогод хамрагдах асуудлаар чиглэл өгч ажилласан. Тооллого зохион байгуулах ажлын хэсэгт ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн шинжээч, Санхүүгийн хэлтсийн дарга болон шинжээч нарыг томилон ажиллуулж ҮСХ-той хамтран ажилласан. Тооллогод УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудыг бүрэн хамруулан ажилласан. | 100% | |
| 263 | 11 | 12 | **Жагсаалт батлах тухай**<br>**2021-12-01**<br>**Дугаар 2021_359**<br>2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн | Засгийн газрын 2021.12.01-ний өдрийн 359 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, 2 дугаар хавсралтаар аймаг нийслэлд эрх шилжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд уг тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний жагсаалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ажил тусгагдаагүй. Засгийн газрын тогтоолын төсөлд өгөх | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг техникийн хяналтын зардлын тооцооны хамт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | саналыг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/2935 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн уг 359 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд өгөх саналыг 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/137 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн | | |
| 264 | 11 | 13 | 4. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудын хүрээнд 2021, 2022 онуудад худалдан авах ажиллагааг 100% цахимаар зохион байгуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэмжээнд 2021 онд 8, 2022 онд 5 төрлийн худалдан авалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан зохион байгуулсан бөгөөд тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажилласан. | 100% | |
| 265 | 12 | 14 | **Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-12-14 Дугаар 2021_397** 1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. 1.1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн өмнөх онд хийсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж санхүүжүүлэх; 1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах; 1.3. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт | УУХҮСайдын 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид олгогдоогүй санхүүжилт болон ковидын нөхцөл байдлаас болж он дамжин санхүүжих төсөл арга хэмжээ байхгүй бөгөөд Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилт байхгүй болно. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | багтаан бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | | | |
| 266 | 13 | 15 | **Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед айл өрхөд дэмжлэг үзүүлэх тухай**<br>**2021-12-31**<br>**Дугаар 2021_410**<br>3. Энэ тогтоолын 1-д заасны дагуу төлбөрийг төрөөс хариуцан төлөхөд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын цэвэр ашгаас болон уул уурхайн томоохон орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулснаас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдэд ногдох, төсөвт аливаа авлага үүсгэхгүй байдлаар хуримтлагдсан ашиг, зардлын хэмнэлтээс тооцож санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Х.Бадамсүрэн)-т тус тус даалгасугай. | Нийгмийн хариуцлагын хүрээнд 2020 оны 211 дүгээр тогтоол, 2021 оны 207 дугаар тогтоолын дагуу 2021 онд 883,487.8 сая төгрөг, 2022 оны 01 дүгээр сард 36.0 тэрбум төгрөг нийт 919,487.8 сая төгрөг төлөөд байна. 2022 оны 1 дүгээр сарын санхүүжилтийн дүнг СЯ-наас баталгаажуулж ирүүлсний дараа уг тогтоолын хэрэгжилтийг тайлагнах нөхцөл бүрдэх юм. Уг тогтоолын хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй. | /-/ | |
| 267 | 14 | 16 | **Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**<br>**2022-05-11**<br>**Дугаар 2022_192**<br>2. Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчилсөнтэй холбоотойгоор шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын дагуу УУХҮЯ-ны 2022 оны батлагдсан төсөвт багтаан үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн болно. | 100% | |
| 268 | 15 | 17 | **Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**<br>**2022-05-11**<br>**Дугаар 2022_194**<br>4. Энэ тогтоол гарсантай холбогдон гарах нэмэлт зардлыг 2022 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлж, цаашид жил бүр холбогдох төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай | УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн а/32 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг цаашид үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. | 100% | |
| 5.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 269 | 1 | 1 | **Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай**<br>**2021-04-13**<br>**Дугаар 2021_89**<br>2. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай: Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг 2021 оны 5 дугаар сарын 9-ний дотор багтаан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг (Г.Ёндон)-т даалгасугай. | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан.<br>Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан.<br>Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯамнаас 2021.12.10-ны өдрийн 01/3068 дугаартай албан бичиг хүргүүлээд байна. | 70% | |
| 270 | 2 | 2 | **Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2021-05-19**<br>**Дугаар 2021_146**<br>4. Нийслэл Улаанбаатар хотод багтаамж ихтэй, шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг судалж, боломжит эх үүсвэрийг тооцож төслийн ажлыг 2021 онд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт зөвшөөрсүгэй | Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлд “Богдхан төмөр зам” төслийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд эхний ээлжинд зураг төсөв, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 23.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төсвийн тодотголд тусган компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлсэн. “Тавантолгой Төмөр зам” ХХК-аас Богдхан төмөр замын төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн төвийн 2021.12.22-ны өдрийн 243/2024 дүгээр Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулсан. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2022.01.07-ны өдрийн 01 дүгээр шийдвэр болон Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022.01.11-ний өдрийн 01 дүгээр шийдвэрээр батлуулаад байна. | 70% | |
| 5.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 271 | 1 | 1 | **2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br>**2021-03-10**<br>**Дугаар 2021_17**<br>XII.4. . Монгол Улсын Засгийн газраас 2020-2024 онд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалт, “Үндэсний баялгийн сангийн тухай” болон “Эрдэс баялгийн биржийн тухай” хуулийн төслүүдийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав: 1. “Үндэсний баялгийн сангийн тухай” хуулийн төслийг хамтарсан Ажлын хэсэг байгуулж Хууль тогтоомжийн тухай | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуульд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт. | | | |
| 272 | 1 | 2 | XII.4. 2. “Эрдэс баялгийн биржийн тухай” хуулийн төслийг хамтарсан Ажлын хэсэг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, тандан судалгааны ажлын тайланг хийж гүйцэтгэн, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн 2021-09-27-ны өдөр цахимаар зохион байгуулж, Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын УИХ-д 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлэв. Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу холбогдох ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдаж мөн дэд ажлын хэсэг байгуулагдан УИХ-ын холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 100% | |
| 273 | 2 | 3 | **2021 оны 3 дугаар сарын 03-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл**<br>**2021-03-03**<br>**Дугаар 2021_14**<br>XII.2. . Засгийн газраас 2020-2024 онд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав: 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол болон Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2021 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд | Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг тус тус боловсруулах ажлын хэсгийг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу ажиллаж байна. Хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж, зарим хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Хуулийн төслийн явцаас танилцуулбал:<br>1/ Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар 25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.01.27-ны өдрөөс 2021.06.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, Оросын холбооны улс, Казакстан зэрэг 10 гаран улсын уул уурхайтай холбоотой хууль тогтоомжтой үзэж танилцан Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн өөрчлөлттэй холбоотой санал, үзэл санааг сонсох, нэгдсэн нэг байр сууринд хүрэх зорилт тавин ажилласан.<br>Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, тайланг хийгээд байна. Үүнд:<br>• Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөө<br>• хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ<br>• хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг болно.<br>Одоогоор үзэл баримтлалын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас санал авахаар хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.<br>2/ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуульд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.<br>3/ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, тандан судалгааны ажлын тайланг хийж гүйцэтгэн, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн 2021-09-27-ны өдөр цахимаар зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын УИХ-д 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлэв. Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу холбогдох ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдаж мөн дэд ажлын хэсэг байгуулагдан УИХ-ын холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | | |
| 274 | 2 | 4 | XII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг тус тус боловсруулах ажлын хэсгийг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгааг хийн, хуулийн төслийг боловсруулж байна. Хуулийн төслүүдийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Хуулийн төслийн боловсруулалтын явцаас танилцуулбал:<br>1/ Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулах зорилгын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар баталсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан.<br>Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийж ажилласан.<br>Хуулийн төслийг Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны албан хаагчдад танилцуулан санал хүлээн авч байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаж ажиллаж байна.<br>2/ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан.<br>Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯамнаас 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/3068 дугаартай албан бичиг хүргүүлээд байна.<br>3/ Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий холбогдох төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг УУХҮСайдын 2021 оны А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулан, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бусад арга хэмжээг тус тус авч, Засгийн газрын 2021.09.29-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 53 дугаар тэмдэглэл гарч, улмаар УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтож, УИХ-ыг өргөн мэдүүлэх тов тогтоолгох бичгийг 2021.12.28-нд хүргүүлээд байна. 4/ Үндсэн хуулиар иргэн байгалийн баялаг ашиглалтаас үр өгөөж хүртэх энэ талаар мэдэх эрхтэй байхаар заасны дагуу Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг УУХҮСайдын 2020 оны А/270 дугаар тушаалаар байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж, үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төслийг боловсруулж яамны цахим хуудаст тавьж олон нийтийн саналыг авч байна. | | |
| 275 | 3 | 5 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>**2020-11-04**<br>**Дугаар 2020_58**<br>XYI.2. 4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэлжүүлэх, түүнд тавих хяналтыг цахимжуулах эрх зүйн болон техникийн орчинг бүрдүүлэх асуудлыг Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 17 дугаар тогтоолын 1, 2, 9 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд судлан зохих шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт; | Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийсэн. Тус ажлын хэсэг нь 2021.01.27-ны өдрөөс 2021.06.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, Оросын холбооны улс, Казакстан зэрэг 10 гаруй улсын уул уурхайн хууль тогтоомжийг судлан үзэж танилцаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн өөрчлөлттэй холбоотой саналыгсонсох, нэгдсэн байр сууринд хүрэх зорилт тавин ажиллаж байна. Мөн Газрын тосны тухай болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгаа, хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төсөл, дагалдан гарах хуулийн төслийг тус тус боловсруулсан.<br>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийжүнэлгээний тайланг боловсруулж байна. Цаашид уг судалгааны ажлын үр дүнг үндэслэн ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/273 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт холбогдох мэргэжилтнүүд ажиллаж ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг цахимжуулахаар Төрийн худалдан авах ажиллагааны газрынхантай хамтран www.tender.gov.mn цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийлгүүлж бэлтгэл ажлыг хангаад байна. Мөн цахим платформын танилцуулах сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр танхимаар, 2022 оны 4 дүгээр сарын 21, 5 дугаар сарын 04-ний өдрүүдэд цахимаар аж ахуйн нэгж болон сонирхсон этгээдүүдэд сургалт зохион байгуулж, гарын авлага, танилцуулга видео хичээлийг боловсруулан давхардсан тоогоор 500 гаруй хэрэглэгчдийг хамруулан зохион байгуулаад байна. Газрын харилцаа геодези, зураг зүйн газартай мэдээлэл солилцох 2021 оны 2021/80 дугаартай гэрээний дагуу геологи уул уурхайн компьютержсон кадастрын системийн сантай холбох сервисийг үүсгэсэн бөгөөд Газрын харилцаа геодези, зураг зүйн газраас гаргах сервис хүлээгдэж байна. | | |
| 276 | 4 | 6 | **2021 оны 8 дугаар сарын 11-ний өдөр 46 дугаар тэмдэглэл**<br>**2021-08-11**<br>**Дугаар 2021_46**<br>ХҮII.2. 5. . Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуульд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | 100% | |
| 277 | 5 | 7 | **2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл**<br>**2021-08-25**<br>**Дугаар 2021_48**<br>ХҮI.5. . Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал болон Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолд заасан хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг 2021.12.28-нд УИХ-д өргөн мэдүүлэх албан бичгийг хүргүүлсэн. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2021.12.10-нд хүргүүлээд байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 278 | 6 | 8 | **2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 52 дугаар тэмдэглэл**<br>**2021-09-22**<br>**Дугаар 2021_52**<br>IX.6. . Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн боловсруулалтын явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуульд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | 100% | |
| 279 | 7 | 9 | **2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 60 дугаар тэмдэглэл**<br>**2021-11-17**<br>**Дугаар 2021_60**<br>**II**.2. Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд урьдчилсан байдлаар танилцуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуульд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | 100% | |
| 280 | 8 | 10 | **2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 65 дугаар тэмдэглэл**<br>**2021-12-22**<br>**Дугаар 2021_65**<br>XXIY.2. . Шинэ сэргэлтийн бодлого болон боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтын хөгжлийн ерөнхий цогц төлөвлөгөөний төслийг Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Шинэ сэргэлтийн бодлогын Эрчим хүчний сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Аж үйлдвэржилтийн сэргэлтийн цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хот, хөдөөгийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу “Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулж” Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮС-ын 2022.05.24-ний өдрийн 01/1500 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Захирагч Д.Сумъяабазар, Ногоон хөгжлийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Төрийн бүтээмжийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус даалгав. | | | |
| 281 | 9 | 11 | **2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл** **2021-02-24** **Дугаар 2021_13** XI.3.6. Эрхлэх асуудлын хүрээнд хугацаа хоцорч, хэрэгжилт нь удаашралтай байгаа төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож ажиллахыг холбогдох сайд нарт.” | -“Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах” төслийн ТЭЗҮ-ийн дүгнэлт, танилцуулгыг ЗГ-ын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2021.03.15-ны өдрийн 01/594 дүгээр албан бичгээр ГХ-ны Сайдад хүргүүлсэн. “Эдийн Засаг Хөгжлийн Яам” /хуучнаар/ нь “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан. Энэ хугацаанд 630 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төслийн хэрэгжилтэд шаардлагатай уурхай, баяжуулах үйлдвэр байгуулах, дэд бүтэц /авто болон төмөр зам, төмөр замын ачих буулгах терминал, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц/-ийн ажлууд хийгдсэн боловч төмөр, гангийн үйлдвэр байгуулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн ажил гэрээнд заасан хугацаандаа хийгдээгүй байна. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл гарч, уг тэмдэглэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Дархан-Уул аймагт хэрэгжих Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, концессын гэрээнд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А-268 дугаар тушаалаар байгуулсан ба тушаалын 2 дугаар хавсралтад заасан удирдамжийн дагуу Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл хийх ажлын хэсгийн төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А-314 дүгээр тушаалаар батлуулан ажиллаж байна. Төслийн явцыг эрчимжүүлэх төлөвлөгөөний дагуу шинээр ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох “MCC-CERI” компаниар гүйцэтгүүлж ТЭЗҮ-ийн тайланг 2021 оны 4 дүгээр сард хүлээн авсан. ТЭЗҮ-ийг Монгол хэлнээ хөрвүүлэх, засвар хийх ажлыг Монгол Улсын “Кью Эм Си” ХХК гүйцэтгэж, 2021.09.30-ны өдрийн УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн, 2021.11.04-ний өдрийн УУХҮЯ, АМГТГ-ын ЭБМЗ-ийн CTP-2021-01 дүгээр дүгнэлт гаргаж, АМГТГ-ын даргын 2021.12.01-ний өдрийн Т/220 дугаар тушаалаар ТЭЗҮ-ийг хүлээн авсан. | 100% | |
| 282 | 10 | 12 | **2022 оны 2 дугаар сарын 9-ний өдөр 9 дүгээр тэмдэглэл** **2022-02-09** **Дугаар 2022_9** Ү.5. . Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс шинээр эхлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, орон нутагт эрх нь шилжсэн худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2022 онд Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын нийт 3 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас шинээр эхлэх 2 төсөл, арга хэмжээ батлагдсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар “XVI.1.2. УУХҮЯ-ны барилгын их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2022.02.21-ний өдөр, “XVI.1.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2022.02.18-ны өдөр эхлүүлэхээр баталсан. Тендер шалгаруулалтыг 2022 оны 02 дугаар сарын 28, 30-ны өдрүүдэд зарлан, зохин байгуулсан боловч 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан төсвийн тодотголоор дээрх төсөл арга хэмжээнүүд цуцлагдсан болно. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 283 | 11 | 13 | **2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл**<br>**2022-02-23**<br>**Дугаар 2022_12**<br>Х.5. . 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | МУ-ын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс УУХҮЯ-нд хандан ирүүлсэн хүсэлт, санал, гомдлыг тухай бүр хүлээн авч, хариуг Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан шийдвэрлэж хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд иргэд, аж ахуйн нэгжүүдээс эхний хагас жилийн байдлаар нийт 148 өргөдөл гомдол,санал хүсэлтийг тус яаманд ирүүлсэн байна.<br>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа.<br>Нийт 148-өргөдөл гомдол, санал, хүсэлт хүлээн авч 100% шийдвэрлэж хариу өгсөн.<br>Үүнд:<br>Гомдол - 56 (38%)<br>Хүсэлт – 55 (37 %)<br>Санал – 37(25%)<br>1-5 хоногт шийдвэрлэсэн-20 /12%/<br>6-10 хоногт шийдвэрлэсэн-40 /29%/<br>11-30 хоногт шийдвэрлэсэн-88 /59%/ | 100% | |
| 284 | 12 | 14 | **2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл**<br>**2022-02-16**<br>**Дугаар 2022_11**<br>XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах боломжийг судлан Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран холбогдох судалгаа хийж Төрийн худалдан авах ажиллаганы www.tender.gov.mn системийг ашиглан сонгон шалгаруулалт явуулж эхлээд байна. Мөн УУХҮЯ-аас олгодог тусгай зөвшөөрлүүдийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж https://license.mn/ цахим системээр тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах хүсэлтийг аж ахуйн нэгжээс хүлээн авч шийдвэрлэж байна. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж https://mpc.mmhi.gov.mn/ цахим системээр аж ахуйн нэгж, байгууллагууд улсын төсвийн тайлан, хувийн хөрөнгийн хайгуулын тайлан, ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, газрын тосны ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн нээлттэй мэдээллийг https://cmcs.mrpam.gov.mn/cmcs цахим систем, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тайлан хүлээн авах үйл ажиллагааг http://inforep.mram.gov.mn/ цахим систем, геологи, эрдэс баялгийн мэдээллийг https://mris.mn цахим систем тус тус ашиглан төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж байна. | 100% | |
| 285 | 13 | 15 | **2022 оны 3 дугаар сарын 9-ний өдөр 15 дугаар тэмдэглэл**<br>**2022-03-09**<br>**Дугаар 2022_15**<br>XXII.2.3. Эрхлэх асуудлынхаа хүрээний Засгийн газрын тусгай сангийн чиг үүрэг, зориулалтыг эргэн авч үзэх болон сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд үнэлэлт өгөх талаар арга хэмжээ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд засгийн газрын тусгай сан байхгүй болно. | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | авч, шаардлагатай бол Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд | | | |
| 286 | 14 | 16 | **2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br>**2022-03-23**<br>**Дугаар 2022_17**<br>IX.11. . “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан салбарын болон аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийг байгуулахаар ажиллаж байна. | 30% | |
| 287 | 15 | 17 | **2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>**2022-04-13**<br>**Дугаар 2022_22**<br>XI.2. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, спортын холбоодын тэргүүн, сонгуульт албан тушаалтны ажлыг хавсран гүйцэтгэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яам, агентлаг, төрийн өмчит компани болон үйлдвэрийн газрын удирдлага, захирлуудад даалгав | Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, спортын холбоодын тэргүүн, сонгуульт албан тушаалтны ажлыг хавсран гүйцэтгэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг агентлаг, төрийн өмчит компани болон үйлдвэрийн газрын удирдлага, захирлуудад үүрэг чиглэл өгч ажиллаж байна. | 100% | |
| 288 | 15 | 18 | XYIII.3.3. Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд харгалзан үзэх боломжтой ажил хэрэгч саналыг судлан бодлого, шийдвэр гаргахдаа авч үзэж, иргэдийн санал, хүсэлтийг хуульд заасны дагуу эцэслэн шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлсэн иргэдийн санал, хүсэлт, гомдлын дагуу тус яамнаас тухай бүр хөдөө орон нутагт томилолтоор ажиллаж, үүссэн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Үүнд:<br>– Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумын иргэдээс Байгаль орчин, аялал жуулчлалын болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад хандан гаргасан гомдлын дагуу Баянхонгор аймгийн нутагт уул уурхайн хайгуул, олборлолт явуулж буй “Эрдэнэ Монгол” ХХК болон бусад аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, хяналт шалгалт хийх, орон нутгийн иргэд, удирдлагуудтай уулзалт хийж үүссэн нөхцөл байдлын талаар санал солилцож, үр дүнг яамны удирдлагуудад танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг 2022 оны 4 дүгээр сарын 07-13-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумдад ажилласан.<br>– УИХ-ын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан, Г.Мөнхцэцэг нараас Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зарим компаниудын үйл ажиллагааг газар дээр нь шалгаж шаардлагатай арга хэмжээ авах, УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэгээс Дундговь аймгийн Баянжаргалан, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын зарим малчид, иргэдийн хууль зөрчиж олгосон, хууль хэрэгжүүлдэггүй компаниудын тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авах хүсэлтийг манай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд уламжилсан. УИХ-ын дээрх | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэр бүхий гишүүдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/128 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамаар ахлуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар зэрэг төрийн холбогдох байгууллага, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн зарим хамаарал бүхий сумдын удирдлага, төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, малчид, иргэдийн төлөөллийг оролцуулсан Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг эхний хурлаа 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 100%-ийн ирцтэй хуралдсан бөгөөд 2022 оны 6 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд тус аймгуудад томилолтоор газар дээр ажиллаж байна.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар Цагаандэл уул хилийн боомт болон тус боомт чиглэлд барихаар төлөвлөж буй хатуу хучилттай авто замын төслийн хэрэгжилтэд байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эсэхийг судалж, дүгнэлт гаргах, нутгийн удирдлага, ард иргэдтэй уулзах, хууль, тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрийг ухуулан таниулах, сурталчлах үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгийн газар зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулсан. Тус ажлын хэсэг Өмнөговь аймагт 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 20-ны өдрүүдэд удирдамжийн дагуу ажилласан. | | |
| 289 | 16 | 19 | **2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл**<br>**2022-05-04**<br>**Дугаар 2022_27**<br>ХYIII.2.13. Төрийн хүнд суртлыг арилгах, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч тухай бүр нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 3 дүгээр сарын 11-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллаж байна.<br>Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмын дагуу яамны ажиллагсдын болон харьяа үйлдвэр компаниудын зарим удирдах ажилтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан авч АТГ-т хүргүүлсэн. /2022.03.01, 03/522/ Хугацаа хожимдуулсан албан хаагч байхгүй болно. 2022 оны хагас жилийн байдлаар нийт 74 албан хаагч ХАСХОМ-ын мэдүүлэг өгсөн байна. Яамны 10 албан хаагчийн ХАСУМ-ын мэдүүлгийг хянуулсан байна.<br>Авлигатай тэмцэх газрын Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Ганхуягтай хамтран 2022 онд Авлигын эсрэг хамтдаа сэдэвт аяны хүрээнд яамны сурталчилгааны самбарыг шинэчлэн яамны вэб сайтад мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг сургалтад 4 албан хаагчийг хамруулаад байна. | 100% | |
| 290 | 17 | 20 | **2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл**<br>**2022-05-11**<br>**Дугаар 2022_28**<br>ХХ.3.1.9. Хөгжлийн төслүүдийн гүйцэтгэл, Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаврын биелэлтийг арга хэмжээ тус бүрээр гаргаж, яамдын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжээр баталгаажуулан 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд; | -“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төслүүдийн 2021 хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (83.3%) хийж, Удирдлагын зөвлөлийн 2022.01.17-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, 2022.01.18-ны өдрийн 01/131 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>- Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (70.5%) хийж 2022.02.21-ний өдрийн 01/437 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>- Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт, Хөгжлийн төслүүдийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ (49.06%) хийж 2022.06.29-ний өдрийн 03/1838 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 100% | |
| 291 | 18 | 21 | **2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дүгээр тэмдэглэл**<br>**2022-03-16**<br>**Дугаар 2022_16** | Захиалагчийн шийдвэрээр томилогдсон үнэлгээний хороод тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд заасан хугацаанд шуурхай зохион байгуулан, үр дүнг мэдэгдэл гарсан өдөрт нь багтаан цахим системд оруулан ажилласан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XYIII.17.2. Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав; | Шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд тухай бүр оруулж, хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтын дагуу 2 гэрээний гүйцэтгэлийн мэдээллийг эхний хагас жилийн байдлаар оруулсан байна. Харьяа агентлагуудад гэрээний мэдээллийг хуулийн хугацаанд оруулж, хариу мэдэгдэх тухай албан бичгийг 2022.06.09-ний 03/1645 тоотоор хүргүүлсэн | | |
| 292 | 18 | 22 | XYIII.17.3. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав | Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг төлөвлөн 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1557 дугаартай албан бичгээр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. | 100% | |
| 293 | 19 | 23 | **2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br>**2022-03-23**<br>**Дугаар 2022_17**<br>IX.2.3. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд төрийн өмчит болон оролцоотой уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг Монголбанканд төвлөрүүлэх талаар судлан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав; | Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд аж ахуйн нэгжүүдийн худалдан авах чадвар буурсан, эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн 28 аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүжилтийг дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, ОХУ-аас ирүүлсэн 11 сарын хил үнийг үндэслэн нийт 762,575.97 сая төгрөгийн санхүүжилтийг хөнгөлттэй зээл хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн. Тус зээл нь Монголбанкны бодлогын хүү болох 6-9,5 хувь болон Арилжааны банкны 3 хувийн хүү нэмэгдэж нийт 9-12,5 хувийн хүүтэй олгогдсон. Нийт 19 аж ахуйн нэгжид 364,774.55 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг олгоод байна. | 70% | |
| 5.з. Засгийн газрын албан даалгавар | | | | | | |
| 294 | 1 | 1 | **Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>**2021-09-15**<br>**Дугаар 2021_01**<br>12.1. 12.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд: 12.1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх; | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуульд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | 100% | |
| 295 | 1 | 2 | 12.2. 12.2.Эрдэс баялгийн бирж байгуулах асуудлыг судлан танилцуулах; | Эрдэс баялгийн бирж байгуулах асуудлаар судалгаа хийж, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуулийн дагуу боловсруулж, яамдаас санал авсан. Хуулийн төслийг 2021.09.29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газрын гишүүдийн зүгээс дэмжсэн. Сангийн сайдын зүгээс ч мөн дэмжсэний дагуу хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авсан. Харин Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зүгээс зөвшөөрлийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн ч агуулгын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор дэмжих боломжгүй байгаа талаар хариуг ирүүлээд байна. Иймээс уг асуудлаар Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн даргатай уулзсан боловч уг зөвшөөрлийг өгөх боломжгүй талаар мэдэгдсэн. Иймд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хэлбэрээс өөрөөр асуудлыг УИХ-д өргөн мэдүүлэхэд эрсдэл үүсээд байсан.<br>Улмаар СЯ-наас 2021.12.21-ний өдөр УИХ-д тус хуулийн төслийг хууль тогтоомжийн дагуу өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгосон.УУХҮЯамнаас 2021.12.22-ны өдрийн 01/3162 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр хүргүүлсэн. | | |
| 296 | 1 | 3 | 12.3. 12.3.Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтад байнгын хяналт тавьж, газрын түүхий тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажлыг шуурхай эхлүүлэх; | Ерөнхий сайдын 2021.07.24-ний өдрийн 122 дугаар, 2021.08.09-ний өдрийн 133 дугаар захирамжаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан Шадар сайдын 2021.08.17-ны өдрийн 87 дугаар тушаалаар ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, төслийн ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан гарсан Шадар сайдын 2021 оны 01/21 дугаартай Албан даалгаврын хэрэгжилтийг 2021.12.01-ний өдрийн байдлаар гаргаж ШС-ын ажлын албанд хүргүүлсэн. Тос дамжуулах хоолойн тендерийг 2021.10.20-ны өдөр нээж үнэлгээг хийж тендерт оролцсон компаниудад мэдэгдэл хүргүүлээд байна. Ерөнхий сайдын албан даалгавраар өгсөн үүргийн дагуу үйлдвэрийн бүтээн байгуулалт болон тос дамжуулах хоолойн төслийн талаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж ажилласан. Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр албан даалгавар шинэчлэгдэн гарсан ба хэрэгжилтийг хангаж ажиллаж байна | 30% | |
| 297 | 1 | 4 | 12.4. 12.4.Зэс хайлуулах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх; | Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байгуулах “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэр технологийн паркад байгуулах 12 мянган тонны хүчин чадалтай “Эрдэнэт” ТӨҮГ-ын ил уурхайн овоолгын шүүрлийн хүчиллэг ногоон усыг боловсруулж, катодын цэвэр зэс үйлдвэрлэх Гал сэнтий ХХК-ийн захиалгаар Идэр металлурги ХХК-ийн боловсруулсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр ЭБМЗ-ийн боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлийн хуралд оролцож санал дүгнэлтээ тусгуулан хэлэлцүүлж батлуулсан | 70% | |
| 298 | 1 | 5 | 12.5. 12.5.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг түшиглэн нүүрс угаах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх; | ’Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг түшиглэн нүүрс угаах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |
| 299 | 1 | 6 | 12.6. 12.6.Хар төмөрлөгийн (кокс, ширэм, шууд ангижруулсан төмөр) үйлдвэрлэлийг Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт хөгжүүлэх асуудлыг судлан ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх; | “Хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах төслүүд (Дархан Уул аймагт Дарханы төмөрлөгийн үйлдвэр дээр хэрэгжүүлж байгаа Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл, Орхон аймагт “Бэрэн групп” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төсөл”, Дорноговь аймагт МДМУ ХХК “Хар төмөрлөгийн цогцолбор”-ийн төсөл, “Болдтөмер Ерөө гол” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Алтан ширээт аж үйлдвэрийн парк)-ийн төслийгн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулан холбогдох материалын хамт УУХҮ-ийн сайдын 2021.10.25-ны өдрийн 01/2561 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2022.03.02-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд "Алтан ширээт аж үйлдвэрийн парк"-ийн төслийн бүтээн байгуулалтын явц болон цаашид хийгдэх ажил, тулгамдаж байгаа асуудлын талаар УУХҮСайд танилцуулсан. | | |
| 300 | 1 | 7 | 12.8. 12.8.Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, хүнээс хамааралгүй, ил тод, шуурхай болгох; | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн "Талбайн солбицлыг тогтоох тухай" 243 дугаар тогтоолоор батлагдсан талбайд 2.5 сая гектар талбайд өөрчлөлт оруулахаар Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв, Дорноговь, Өвөрхангай, Булган, Баянхонгор, Архангай, Завхан, Говь-Алтай, Дундговь, Баян-Өлгий, Ховд, Увс, Өмнөговь аймгуудын Засаг дарга нарт Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу албан бичиг хүргүүлэн, нэмж батлуулах тухай албан хүсэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газрын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/1473 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>2022 оны 01 дүгээр сараас эхлэн нийт 2 багцаар СШ-62, СШ-63 дугаартай сонгон шалгаруулалтын 30 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарлав.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн хүрээнд<br>-Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалтын цахим системийн сургалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Үндэсний геологийн алба, Австрали улсын АМЕР төсөлтэй хамтран 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр "Blue sky" хурлын зааланд танхимын хэлбэрээр зохион байгуулсан.<br>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Үндэсний геологийн алба, Австрали улсын АМЕР төсөлтэй хамтран 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын цахим системийн сургалтыг Zoom ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулсан.<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Үндэсний геологийн алба, Австрали улсын АМЕР төсөлтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын цахим системийн сургалтыг Zoom ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 01/1488, 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/1506 дугаар албан бичгийн дагуу ирүүлсэн 408 талбайг кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн.<br>Сонгон шалгаруулалтын урилгын мэдээллийг багцлан бэлтгэж Төрийн худалдан авах ажиллагааны газрын tender.gov.mn цахим системд байршуулсан. | 70% | |
| 301 | 1 | 8 | 17. 17.Албан даалгаварт тусгагдсан төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд онцгой анхаарч ажиллахыг Засгийн газрын нийт гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | Албан даалгаварт тусгагдсан төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд анхаарч ажиллаж байна. Тухайлбал, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг 2022.05.11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон. | 100% | |
| 302 | 2 | 9 | **Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>**2022-01-11**<br>**Дугаар 2022_1**<br>5.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд: 5.1.Аж үйлдвэржилтийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөг 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах; 5.2.Тавантолгой болон бусад нүүрсний ордын усан хангамжийн асуудлыг судлан үзэж, хэрхэн шийдвэрлэх саналаа, | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Тус яамнаас МУ-ын Үндсэн хуулийн 6.2-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж тус, хуулийн төсөлд бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүй асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Монгол Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу Хууль | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | говийг усжуулах төслийн хамт 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулах; 5.3.Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулах; 5.4.Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2024 онд багтаан дуусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах; 5.5.Эрдэнэт, Оюутолгой болон зэсийн бусад ордуудыг иж бүрнээр нь ашиглаж, зэс боловсруулалтыг нэмэгдүүлэх, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн талаар 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөрт багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах; 5.6.Эрдэнэт үйлдвэрийн зэс боловсруулах үйлдвэрийн төсөлд хөрөнгө оруулалт татан хувилбарт санал боловсруулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах; 5.7.Цагаан суваргын зэсийн ордын ашиглалтыг дэмжих талаар хувилбарт санал боловсруулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах; 5.8.Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх; 5.9.Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл анхдагч хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх; 5.10.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2022 оны 03 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | тогтоомжийн хуульд заасны дагуу ХЗДХЯ болон СЯ-наас 2022-06-17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | | |
| Монгол Улсын Ерөнхий сайдын албан | | | | | | |
| 303 | 1 | 1 | **Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар**<br>**2022-01-26**<br>**Дугаар 2022_-**<br>1. 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарт: 1.1.Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар, техник хяналтын зардлын тооцоо болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор шилжүүлэх | Уг албан даалгаврын 1.1. болон 1.3.-д хамаарах ажил байхгүй.<br>1.2. УУХҮСайдын багцын хэмжээнд 2022 онд хөрөнгө оруулалтын нийт 2,505,300.0 мян.төгрөгийн 3 төрлийн төсөл, арга хэмжээг төлөвлөн, УУХҮСайдын 2021.11.24-ний өдрийн А/282 дугаар тушаалаар батлуулсан. Уг тушаалын дагуу дээрх 3 нэр төрлийн худалдан авалтуудын тендерийг 2021.12.15, 2022.01.10, 2022.01.24-ний өдрүүдэд тус тус зарлан шалгаруулж 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө дуусгахаар төлөвлөн УУХҮСайдын 2021.11.24-ний өдрийн А/283 дугаар тушаалаар батлуулсан.<br>- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль 2022.04.29-ний өдөр батлагдсанаар дээрх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 1,150,000.0 төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт хасагдаж хүчингүй болсон. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээ авах; 1.2.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулах; 1.3.Засгийн газрын шийдвэрээр орон нутагт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, ил тод байдлыг хангах, тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллах | - “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төсөл, арга хэмжээний 5 багц бүхий тендер шалгаруулалт 2022.01.12-ны өдрөөс эхлэн зарлагдсан бөгөөд одоогоор 1, 2, 3, 4 дүгээр багцуудад гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулсан. | | |
| | 52 | 116 | Нийтлэг асуудлын дундаж: 91.9 хувь | | | |
| НИЙТ ДҮН: 85.1 хувь | | | | | | |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ